

Туслах технологи 2030
Кейс судалгаа: Бүрэн тайлан

Монгол Улсын Улаанбаатар хотын барилга байгууламжийн орчны хүртээмж ба хамруулсан загвар

Бэлтгэсэн
Дэлхийн хөгжлийн
бэрхшээлийн Инновацын
Сүлжээ (GDI Hub)

**4-р Хэсэг Чадавх ба
Оролцоо**
Хамруулсан дэд бүтэц

Улс
Монгол Улс

Огноо
2020 оны 9 дүгээр сар



Санхүүжүүлсэн



Удирдсан



Түншлэгчүүд





Санал болгож буй эшлэл: Патрик, М., МкКиннон, И. ба Остин, В. (2020) Монгол улсын Улаанбаатар хотын хамруулсан загвар ба хүртээмж. ТТ2030 Тэгш хамруулсан дэд бүтцийн кейс судалгаа. Дэлхийн хөгжлийн бэрхшээлийн инновацын Сүлжээ (GDI Hub), Их Британи, Умард Ирландын Нэгдсэн вант улсын Гадаад, хамтын нөхөрлөл, хөгжлийн албанд хамтран бэлтгэв. DOI: 10.13140/RG.2.2.26922.44485

Suggested citation: Patrick, M., McKinnon, I. and Austin, V. (2020) Inclusive Design and Accessibility in Ulaanbaatar, Mongolia. AT2030 Inclusive Infrastructure Case Studies. Prepared by the Global Disability Innovation Hub and partners for the UK Foreign, Commonwealth and Development Office. DOI: 10.13140/RG.2.2.26922.44485





Хураангуй: Илүү хүртээмжтэй хот болох НЬ

Улаанбаатар хот бол хүртээмж болон хамруулсан загварын хувьд өвөрмөц онцлогтой, өвөрмөц боломжтой хот юм. Хотын төв нь илүү хөгжсөн, эргэн тойрон гэр хорооллоор хүрээлэгдсэн хуваагдлаар дүүрэн хот юм. Хотын хүн амын 70 орчим хувийг бүрдүүлэх хороолол сүүлийн 30 жилд тодорхой төлөвлөгөөгүйгээр тэлж иржээ. Хотын энэ хэсэгт үндсэн дэд бүтцийн хүртээмжгүй байдал, тэгш бус байдал улам өргөжиж, эрүүл мэнд, сайн сайхан байдалд нөлөөлж, улмаар хотын хөгжилд асар их бэрхшээлийг үүсгэж байна. Нүүдэлчдийн түүх, 20-р зууны Зөвлөлт холбоот улсын нөлөө, технологийн хот болон хөгжих орчин үеийн төлөвлөгөө



Улаанбаатарын гэр хороолол нь хотын төвөө тойрсон байрлалтай. Эх сурв.: Google Streetview

зэргийг бүгдийг нь хольсон архитектур, төлөвлөгөөтэй. Эдгээр олон тооны хүчин зүйлүүд нь барилга байгууламжийн орчинд хөгжлийн бэрхшээлийг тэгш хамруулахад нөлөөлж байна.

2016 онд Монгол Улс НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах конвенцыг соёрхон баталснаас хойш долоон жилийн дараа 'Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль' батлав. Энэхүү хууль нь хамруулалт бүх салбарт ахиц дэвшил гаргахад чухал алхам болж байна. 2009 онд хүртээмжийн стандартуудыг боловсруулсан, одоо шинэчлэн боловсруулж байна. Гэсэн хэдий ч тэдгээр стандартууд нь заавал биелүүлэх биш тул тэдгээрийг хэрэгжүүлэх, дагаж мөрдөхөд нь саад учруулж байна. Хамруулсан загвар, хүртээмжийн талаарх өнөөгийн ойлголт нь олон улсын нөлөө, стандартаар ойлгодог хэдий ч архитектурын сургалт, хот байгуулалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд тусгаагүй байна.



Оролцогчид барилга байгууламжийн орчноос ялгаварлан гадуурхалт мэдэрдэг

Улаанбаатар хотын гэр хороолол болон газар зүй, цаг уур, соёлын өвөрмөц онцлогийг барилга байгууламж, орчны хүртээмжийг төлөвлөхдөө тусгах шаардлагатай. Одоогоор хамруулсан загварыг налуу зам, хүртээмжтэй бие засах газар зэрэг үндсэн биет өөрчлөлтүүдээр харж байгаа хэдий ч, энэхүү загвар нь илүү их зүйлийг хийх боломжтой юм. Хотын хөгжлийг төлөвлөхдөө хүртээмжгүй, тэгш бус барилга

байгууламжийн талаар сайн ойлголттой хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн дуу хоолойг хүргэж хамруулсан загварыг хэрэгжүүлж болно. Барилга байгууламжийн орчныг тэгш, хамруулсан болгоход хот төлөвлөлт, дэд бүтэц, барилгын төслүүдийг хамруулсан загварыг баримталж тууштай хэрэгжүүлэх ёстой.

Барилга байгууламжийн тэгш хамруулсан орчин нь хүртээмж, мөн боломжийг бий болгож, оролцоог хангаж, нийгэмд тэгш байдлыг нэмэгдүүлдэг. Энэ нь хэнийг ч орхигдуулахгүй байх уриаг баталгаажуулж, нийгэм бүхэлдээ хамтран ажилласны үр дүнд бий болдог. Өөрөөр хэлбэл бодлого, төлөвлөлт, барилга байгууламж зэрэг бүхий салбар дахь оролцогч талуудад хамруулсан загварын ашиг тусыг ойлгуулдаг. Цогц алсын хараатай, үйл ажиллагааны төлөвлөгөөтэй, илүү хүртээмжтэй Улаанбаатар хоттой болохын тулд бүх оролцогч талууд болон олон нийтэд хөгжлийн бэрхшээлийн талаар боловсрол олгох шаардлагатай. Ингэснээр хотын нөхцөл байдал, хөгжил нь ялгаатай байдлын оролцоог хангаж, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс болон хүн бүрийн амьдралыг сайжруулах боломжийг олгоно.

“Хүртээмжтэй Улаанбаатар гэдэг нь хүн бүхэнд шударга, тэгш боломжийг олгодог байхыг хэлнэ. Бүх хүмүүст аюулгүй, хүртээмжтэй орчныг бий болгосноор хот хүн бүрд хүссэн боломжоо ашиглах, хүссэн үйл ажиллагаандаа оролцох боломжийг олгоно”.

Хамруулсан загвар гэдэг нь хурдацтай өөрчлөгдөж буй хотод мэдрэмжтэй, дасан зохицохуйц дизайн гаргах боломжийг олгох бөгөөд техникийн стандартаас илүү сэтгэлгээ, арга зүй гэж ойлгох юм. Өөрөөр хэлбэл, нүүдэлчин хэв маягаар амьдарч ирсэн баялаг түүхээс хотын суурьшмал амьдрал, арга барилд дасан зохицохдоо, цаг уурын эрс тэс байдал, түүнээс үүсэн гарах стресс зэрэг тогтвортой хөгжлийн асуудлуудыг харгалзан

үзэх хэрэгтэй гэсэн үг юм.

Гол саад бэрхшээлүүд:

- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс барилга байгууламжийн орчинд нэвтрэхэд сэтгэл зүйн хийгээд эдийн засгийн хувьд хүндрэл бэрхшээлтэй тулгарч байна.
- Хот хувьсан өөрчлөгдөхдөө саадгүй зорчих, нэвтрэх орон зайг анзааралгүй хязгаарлаж байна. Хот төлөвлөлт, түүний уялдаа холбоотой ажиллагаа нь барилга байгууламжийн хүртээмжтэй орчныг барих орон зайг бүрдүүлэх ёстой.
- Хүртээмжтэй дизайны зардлын талаарх мэдлэг дутмаг байгаа нь шийдвэр гаргагчдад саад болж байна. Сайн чанарын дизайн нь илүү их өртөгтэй байх ёсгүй.
- Хууль тогтоомж, бодлогын хэрэгжилт хангалтгүй тул түүний механизмыг сайжруулах шаардлагатай байна.
- Барилга байгууламжийн орчинд хариуцлага дутмаг, дэд бүтцийн төслүүд одоо мөрдөгдөж буй стандартыг хэрэгжүүлэхгүй байх
- Орон нутгийн хамруулсан загварын шийдлүүдийн сайн жишээнүүд дутагдалтай байгаа нь олон нийт, болон төлөвлөгчдийг түүнд тэмүүлэх урам зориг оруулахад саад болж байна. Мөн Улаанбаатар хотод хүртээмжтэй, хамруулсан загварын алсын хараа хэрэгтэй.

Санал болгож буй арга хэмжээнүүд


- Хүмүүст юу чухал болохыг олж мэдэх.
- Хотын оролцогч талууд Улаанбаатар хотыг илүү хүртээмжтэй, хамруулсан загвартай болгох талаарх алсын хараа, хүсэл эрмэлзэлтэй байх ёстой.
- Ойлголтыг нэмэгдүүлэх, боловсрол олгох нь амин чухал юм. Хамруулсан загвар нь хүн бүрд ямар ашиг тустай болохыг зааж өгч, нийтийг хамарсан соёлыг бий болгоход тусалдаг.
- Барилга байгууламжийн хүртээмжтэй орчин нь зөвхөн техникийн стандартуудын асуудал биш юм. Түгээмэл загвар нь үзэмж, хялбар ашиглалт, аюул ослыг бууруулах зэрэгт анхаардаг бол хамруулсан загвар нь сайн загварчлахыг хэлнэ.
- Улаанбаатар хотын өвөрмөц уур амьсгал, соёл, газар зүйн байдал зэрэгт нийцсэн хамруулсан загварын стратеги шаардагдана.
- Төсөл хэрэгжиж эхлэхээс хамруулсан загварыг суулгаж, түүний төсөвлөлтийг зохион байгуулалтыг төлөвлөх нь илүү үр дүнтэй байдаг.
- Болох газраасаа хийж эхэл. Хотыг амьдрахад ая тухтай, хамруулсан загвартай болгохыг хүмүүс өөрсдөө нээж илрүүлэх хэрэгтэй.

Орчныг бүрдүүлэх

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст таатай орчин бий болгохын тулд хууль эрх зүйн таатай орчин, зураг төсөл боловсруулах, шийдвэр гаргах явцад оролцох, соёлын эерэг өөрчлөлт, хүртээмжтэй барилга байгууламж, чанартай, боломжийн үнэтэй туслах технологитой байх зэрэг асуудлуудыг хамрах хэрэгтэй.

Тэгвэл хамруулсан Улаанбаатар ямар байх ёстой вэ?

- Хүртээмжийн стандартууд заавал мөрдөгддөг, хүний өөр, өөр чадвар болон хөгжлийн бэрхшээлийг хэлбэрүүдийг харгалзан үзсэн байх
- Олон нийтийн газрууд нь хүртээмжтэй, нээлттэй байх бөгөөд хүмүүсийн эрх тэгш байх боломжийг олгодог байх
- Сайн чанарын, боломжийн үнэтэй, туслах технологийг авах боломжтой байх
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаар мэддэг, ойлгодог, дэмждэг соёлтой байх
- Бүгдэд зориулсан тэгш, хүртээмжтэй, боломжтой, оролцоотой байх



Гадна талбайд дасгал хийхэд хүртээмжтэй байх нь чухал

Цаашид яах вэ?

Энэхүү кейс судалгаанд Улаанбаатар хотын талаар дөрвөн сарын хугацаанд хийсэн судалгааны ажлын гол үр дүнг тоймлон харуулав. Энэ нь бага, дунд орлоготой орнуудын барилга байгууламжийн орчин болон хамруулсан загварт хийх, зургаан кейс судалгааны эхнийх нь бөгөөд кейс судалгаануудын тайлан хамруулсан загварын талаарх дэлхийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд орох юм.

Энэхүү судалгааны үр дүнг олон улсын болон орон нутгийн түвшинд оролцогч талуудад хуваалцана. Монгол улсад төсөл хэрэгжүүлэх замаар Дэлхийн хөгжлийн бэрхшээлийн инновацийн сүлжээ (GDI Hub) болон түншлэгчидтэй идэвхтэй хамтран ажиллахаар төлөвлөж байна.

Талархал

Энэхүү тайланг Дэлхийн Хөгжлийн Бэрхшээлийн Инновацийн Сүлжээ (GDI Hub)-ний судлаач Микаэла Патрик, Иайн Маккинон болон Викки Остин нар бичлээ.

Монгол улс, Улаанбаатар хотоос энэхүү судалгааны ажил болон тайлан гаргахад хувь нэмрээ оруулсан Дамдинсүрэнгийн Тулгамаа, Нарангэрэлийн Тамирхүү, Бямбадоржын Ням-Очир, Чулуундаваагийн Ундрахбаяр, Лхагважавын Энхбуянт, Ямхины Авирмэд нарт талархал илэрхийлье. Мөн уг тайланг Монгол хэлнээ хөрвүүлсэн Дамдинсүрэнгийн Тулгамаа, Нарангэрэлийн Тамирхүү нарт талархал илэрхийлье.

Энэхүү кейс судалгааг хийхэд Азийн хөгжлийн банкны Монгол дах суурин төлөөлөгчийн газар, Нийгмийн хөгжлийн сэдэвчилсэн групп, Хот суурин газрын салбарын бүлэг, Хотын цаг уурын өөрчлөлтөд дасан зохицох чадварын сангийн багтай хамтран ажиллаж, дэмжлэг авч ажилласан.

Судалгаанд оролцсон бүх оролцогчдод чин сэтгэлээсээ шударгаар хандсанд талархал илэрхийлье. Судалгаандаа хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дуу хоолойг нэмэгдүүлэх нь бидний зорилго бөгөөд энэхүү судалгаа нь илүү тэгш хамарсан, хүртээмжтэй Улаанбаатар хотын талаарх таны алсын харааг илэрхийлнэ гэж найдаж байна.

Энэхүү ажлыг дэмжиж ажилласан Дэлхийн хөгжлийн бэрхшээлийн инновацийн Сүлжээ (GDI Hub)-ний хамт олон Кэтрин Перри, Профессор Кэти Холлоуэй, Викки Остин, Роза Салазар, Луиза Геббетт нарт талархал илэрхийлье. Эцэст нь хэлэхэд бид өөрсдийн судалгааны зөвлөх багийн гишүүд болох Луис Артида, Профессор Ричард Бибб, Рама Гираво, Чапал Хаснабис, Доктор Мария Кетт, Софий Морлей болон Жулиан Вокер нар үнэтэй санал зөвлөмжөө өгч байсанд талархал илэрхийлье.

Энэ судалгааг хийхэд Лондонгийн Их Сургуулийн Коллежийн (UCL) ёс зүйн зөвшөөрөл, Монголын улсын засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Хөгжлийн Бэрхшээлтэй Хүний Хөгжлийн Ерөнхий Газрын зөвшөөрлийг тус тус авсан болно.

Дэлхийн хөгжлийн бэрхшээлийн инновацын Сүлжээ

www.disabilityinnovation.com

Дэлхийн хөгжлийн бэрхшээлийн инновацын Сүлжээ (GDI Hub) нь хөгжлийн бэрхшээлийн инновацын судалгаа, шинжилгээг хийдэг төв юм. Бидний алсын хараа нь оролцоонд саад бэрхшээлгүй, хүн бүрд тэгш боломж олгохыг зорьдог. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн инновац нь хөгжлийн бэрхшээлийг тэгш хамруулах, нийгмийн шударга ёсны төлөөх томоохон хөдөлгөөний нэг хэсэг гэж бид үзэж болно. GDI Hub нь дараах судалгаа, инновац, хөтөлбөр, сургалт, сурталчилгаа гэсэн 5 чиглэлээр ажилладаг. бид туслах технологи, хүртээмжтэй дизайн, Соёл ба оролцооны салбарын шийдэлд анхаарлаа хандуулдаг экспертүүд юм. Зүүн Лондон хотод байрлах, Лондон-2012 Паралимпийн наадмын хотхоныг хамруулсан загвартай болгосон туршлагадаа үндэслэн дэлхийн хэмжээний судалгаа, санаа, бүтээл, шинэ мэдлэг, шийдэл, бүтээгдэхүүн, бодлогыг хамтын бүтээл, оролцоо, хамтын ажиллагааны хүрээнд тодорхойлж байна. Эрдэм шинжилгээний судалгааны төв (ARC) ба Хамт олны ашиг сонирхлын компани (CIC)-ийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн Зөвлөх удирддаг. 33 оронд үйл ажиллагаа явуулах бид 2024 он гэхэд 15 сая хүнд нөлөөлнө гэж үзэж байна.

АИФО

www.aifo.it

АИФО нь Итали улсын байгууллага бөгөөд Энэтхэг, Бразил, Монгол улсад гишүүн нийгэмлэгтэй олон улсын сүлжээ байгууллага юм. Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагатай албан ёсны харилцаатай. Монгол улсад АИФО байгууллага нь 1991 оноос одоог хүртэл Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хамт олонд түшиглэн сэргээн засах (ХОТСЗ) хандлагыг хэрэгжүүлж байна. 1996 онд өөрийн төлөөлөгчийн газрыг нээсэн. Улс орнуудад аливаа үйл ажиллагааг явуулахдаа “Бидэнгүйгээр бидний тухай ярихгүй байх” олон улсын уриаг даган мөрддөг. АИФО-гийн бүх үйл ажиллагааг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн идэвхтэй оролцоотойгоор, тэднийг асуудалдаа эксперт гэж хүлээн зөвшөөрч хэрэгжүүлдэг. Монгол улсад хөгжлийн бэрхшээлийн салбарт 29 жил ажилласны үндсэн дээр хөгжлийн бэрхшээлийн салбарыг хөгжүүлэхэд хувь нэмрээ оруулдаг чадалтай хүмүүсийг таньж мэдсэн бөгөөд сургалт болон дэмжлэгийн хувьд урт хугацааны түүхтэй байгууллага билээ.

Тэгш Нийгэм Холбоо ТББ

Тэгш Нийгэм Холбоо ТББ нь Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хамт олонд түшиглэн сэргээн засах (ХОТСЗ) хандлага болон Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенцыг хэрэгжүүлж хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн амьдралын чанарыг



сайжруулахад хувь нэмрээ оруулах зорилгоор 2006 онд байгуулагдсан. Тэгш Нийгэм Холбоо ТББ нь АИФО байгууллага болон үндэсний Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагуудтай хамтран Европын холбооны хоёр төсөл, хөдөлмөр эрхлэлтийн талаар буцалтгүй тусламжийн төслүүдийг тус тус хэрэгжүүлсэн. Мөн 2016 онд Монгол улсын Их хурлаар батлагдсан Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг боловсруулахад хувь нэмрээ оруулсан. 2017 оны нэгдүгээр сараас ХНХ-ын сайдын тэргүүлдэг Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус зөвлөлийн гишүүнээр сонгогдон ажиллаж байна. 2015, 2018 онуудад Тэгш Нийгэм Холбоо ТББ нь Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухайн конвенцын хэрэгжилтийн талаар хоёр сүүдэр илтгэлийг бичихэд оролцсон байгууллага юм.

Түгээмэл хөгжил төв

www.Hurteemj.edu.mn

Түгээмэл хөгжил төв нь 2010 онд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үүсгэл санаачилгаар байгуулагдсан ТББ бөгөөд Монгол дах анхны бие даан амьдрах төв юм. Тус төв нь хүн бүрд хүртээмжтэй орчныг бүрдүүлэх, бие даан амьдрахад дэмжих замаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог нэмэгдүүлэх, гишүүдийг чадавхжуулах зорилготой үйл ажиллагаа хэрэгжүүлдэг байгууллага юм. Одоогийн байдлаар тус төв нь нийт 160 гаруй хөгжлийн бэрхшээлтэй гишүүн, 17 үндсэн ажилтантайгаар үйл ажиллагаагаа явуулж байна. Эдгээр ажилтнуудын 12 нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс юм. Түгээмэл хөгжил төв үндсэн зорилгоо хэрэгжүүлэхэд бие даан амьдрах, нийгмийн оролцоо, тэгш хамруулах боловсрол гэсэн дөрвөн хөтөлбөрийн хүрээнд үйл ажиллагаагаа хэрэгжүүлдэг. Түүнчлэн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог нэмэгдүүлэх, халамжийн үйлчилгээ, боловсрол, дэд бүтцийн хүртээмжийн чиглэлээр судалгаа хийх, түүний үр дүнд суурилсан бодлого боловсруулах, төр, нийгэмд таниулан сурталчлах, нөлөөлөх зэргээр хүний эрхэд суурилсан ажлуудыг тогтмол зохион байгуулж ирсэн.

Азийн Хөгжлийн Банк

www.adb.org

АХБ нь нэн ядуу байдлыг арилгахад тогтвортойгоор хувь нэмрээ оруулж, Ази, Номхон далайн тивийг хамруулсан, уян хатан, тогтвортой, хөгжүүлэхийг зорьдог билээ. 1966 онд байгуулагдсан бөгөөд 68 гишүүн оронтой бөгөөд энэ бүсээс 49 гишүүн орон байдаг. Хөгжиж буй гишүүн орнуудад бодлогын ярилцлага, зээл, хөрөнгө оруулалт, баталгаа, буцалтгүй тусламж, техникийн туслалцаа зэрэг хэлбэрээр тусалдаг.



Гарчиг

Өмнөх үг	1
Өмнөх үг	2
Нэр томъёоны тайлбар	3
Товчилсон үгийн тайлбар	5
ТТ2030 ба Хамруулсан Дэд бүтэц Хөтөлбөрийн мэдээлэл	6
ТТ2030 –ын тухай	6
Яагаад доогуур орлоготой хотуудад анхаарлаа хандуулах хэрэгтэй вэ?	10
Дэлхийн зорилготой нийцсэн эсэх?	11
Монгол улсад хийсэн кейс судалгааны танилцуулга	15
Үндэслэл ба холбогдох хүчин зүйлс	18
Монгол улсын хөгжлийн бэрхшээл ба хүртээмж	18
Улаанбаатар хотын хөгжлийн түүх ба соёл	23
Хотын хөгжил ба амьдрах орчин	24
Эрүүл мэнд, байгаль орчин ба цаг уур	29
Үйл ажиллагааны хураангуй	30
Монголд хамруулсан загвар болон хүртээмжтэй барилга байгууламжийн орчин бүрдүүлэхэд хэн гол нөлөөтэй	32
Хамруулсан загварт хөтлөх зам – хаана байна?	33
Ажиглалт	34
Улаанбаатар хотод амьдарч байгаа хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн туршлага:	34
Хотын хөгжил, дэд бүтэц ба газар	37
Бодлогоос бодит үйл ажил руу – хариуцлага болон хэрэгжилт	43
Хамруулсан хотыг бий болгоход тохируулсан, хамтарсан хандлагыг ашиглах нь	46
Хамруулсан загвар	47



Орчныг нээлттэй болгох нь: мэдлэг, боловсрол ба оролцоо	53
Илүү хамруулсан хот уруу	55
Суралцсан зүйлс	58
Юу болж байна, юу асуудал болж байна вэ?	59
Туслах технологи болон барилга байгууламжийн орчныг хэрэглэх талаар бид юу сурсан бэ?	60
Тэргүүлэх чиглэлийг тогтоох нь	61
Бодит ажлуудыг нээн илрүүлэх нь	61
Хязгаарлалтууд ба цаашдын судлах зүйлүүд	65
Хамруулах чиглэл – тэд хаашаа чиглэж байна вэ?	67
Дүгнэлт: Хамруулахад чиглэсэн үйл ажиллагаанууд	68
Цаашид яах вэ?	71
Ашигласан хэвлэлийн тойм	72



Өмнөх үг

“БҮХ НИЙТИЙН ОРОЛЦООГ ХАНГАСАН ХОТ БОЛОХ НЬ”

Монгол улс 2009 онд НҮБ-ын “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц”-д нэгдэн орсон бөгөөд олон улсын өмнө хүлээсэн үүргээ амжилттай хэрэгжүүлж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хангах, оролцоог дэмжих, хамгааллыг сайжруулах хүрээнд бодлого, эрх зүйн орчноо сайжруулах, төрийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхээр Улсын Их Хурлаас 2016 онд “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль”-ийг батлан хэрэгжүүлж байна.



2017 онд Монгол улсын Засгийн Газраас хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн өмнө тулгамдаж байгаа эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, нийтийн тээвэр, зам, орон сууц, олон нийтийн барилга байгууламжийн хүртээмж гэх мэт олон асуудлыг шийдвэрлэхэд салбар дундын хамтын ажиллагаа, уялдааг сайжруулах, конвенц болон хуулийн хэрэгжилтийг хангахаар “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр”-ийг батлан хэрэгжүүлж байна. Түүнчлэн, хөгжлийн бэрхшээлтэй иргэн нийгмийн харилцаанд бие даан оролцоход учирч буй саадыг арилгах, дэд бүтэц, үйлчилгээний хүртээмжтэй орчныг бий болгох зорилгоор Саадгүй байдал, хүртээмжийн тухай хуулийн төслийг боловсруулах салбар дундын ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна.

Монгол улсын хувьд “Хүртээмж” “Хамруулсан загвар” гэх ойлголтууд нь хэдий шинэ, хөгжиж буй боловч төр, төрийн бус байгууллага, иргэд, олон улсын байгууллагуудаас хүртээмжтэй, оролцоог хангасан нийгмийг бий болгохын төлөө бодит нөхцөл байдлыг тодорхойлж, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж өгөх судалгаа, шинжилгээний ажлуудыг тогтмол явуулж ирсэн. Энэ удаа Дэлхийн хөгжлийн бэрхшээлийн инновацын сүлжээ (GDI Hub), Лондонгийн их сургуулийн коллежоос “Раул Фолерогийн анд нөхдийн холбоо” /АИФО/ Италийн байгууллага, Тэгш Нийгэм Холбоо ТББ болон “Түгээмэл хөгжил” төв хамтран Монгол улсад хүртээмжтэй орчин, хамруулсан загварыг ойлгох нь сэдэвт судалгаа хийж, Саадгүй байдал, хүртээмжийн тухай хуулийн төсөл, мөн хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, хүртээмжтэй нийгмийг сайжруулах чиглэлээр төрөөс баримталж буй бодлого, хөтөлбөр, арга хэмжээг төлөвлөх, боловсруулах, хэрэгжүүлэх, хянах үйл явцад хувь нэмрээ оруулж байна.

Бид Улаанбаатар хотоо бүх хүний оролцоог хангасан, хүний эрхийг дээдэлсэн, хөгжлийн хот болгон цэцэглэхэд төр, төрийн бус байгууллагууд, нийгмээрээ хамтран ажиллаж тэдний оролцоо, үзэл бодол, дуу хоолойг хүндэтгэн тусгасан “Бүх нийтийн оролцоог хангасан хот” болгоно гэдэгт итгэлтэй байна.

Э.Тамир

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын дарга



Өмнөх үг

Хүртээмжтэй орчин бүрдүүлэх нь зөвхөн хөгжлийн бэрхшээлтэй хүнд хамаарах зүйл мэтээр ойлгож, налуу зам хийх, ариун цэврийн өрөөг тохижуулах төдийгөөр асуудлыг шийдэх гэсэн явцуу хүрээнд ажилладаг. Гэвч нийгмийн хөгжлийг даган энэхүү ойлголтыг илүү өргөн утгаар нь авч үзэх болсон. Тухайлбал саадгүй орчныг бий болгох нь бодлого шийдвэр, үйл ажиллагаа, техник технологи, боловсрол, нийгмийн хамгаалал, аялал жуулчлал, үйлчилгээ гэх мэт бүхий л салбарт хамаарах асуудал болгон хөгжүүлж байна. Энэ нь тухайн улсын болон хотын хөгжлийн суурь асуудал ч болж байна. Улс орнууд хэдий соёл заншил, амьдралын хэв маяг өөр өөр байх ч хэний ч хувьд нийгмийн оролцоо эрх тэгш байх зарчимд нэгддэг.

Дэлхийн хөгжлийн бэрхшээлийн инновацын сүлжээ (GDI Hub) нь Туслах технологи 2030 хөтөлбөрийн хүрээнд Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант улсын Гадаад, хамтын нөхөрлөл, хөгжлийн албаны дэмжлэгтэйгээр зургаан оронд хамруулсан загвар, хүртээмжтэй орчныг ойлгох эрдэм шинжилгээний судалгааг тэргүүлэн гүйцэтгэж байгаа бөгөөд Монгол улсад уг судалгааг АИФО олон улсын байгууллага, Тэгш Нийгэм Холбоо ТББ, “Түгээмэл хөгжил” төв хамтран хэрэгжүүлсэн.

Энэхүү судалгаанаас гарч буй зөвлөмж нь Монгол улсад хамруулсан загварыг хэрэгжүүлэхэд үндсэн суурь судалгаа болох бөгөөд бидэнд олон санааг таниулж байгаагаараа онцлогтой юм. Мөн оролцогч талуудын шийдвэр гаргах явцад болон хүртээмжийн тухай хууль гэх зэрэг хөгжлийн ажлуудад хувь нэмрээ оруулах юм.

Мөн энэхүү судалгаа нь Монгол улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030-ыг хэрэгжүүлэхэд хувь нэмрээ оруулж байгаад баяртай байна.

Дэлхийн судалгаанд дуу хоолойгоо хүргэх боломж олгосон Дэлхийн хөгжлийн бэрхшээлийн инновацын сүлжээ (GDI Hub) болон АИФО байгууллагад гүнээ талархаж байгааг минь хүлээн авна уу

Л.Энхбуянт

Тэгш Нийгэм Холбоо ТББ-ын тэргүүн

Ч.Ундрахбаяр

“Түгээмэл хөгжил” төвийн тэргүүн



Нэр томъёоны тайлбар

Хамруулах – Хэн нэгнийг эсвэл бүлэг хүмүүсийг орхигдуулахгүй байх

Хамруулсан хот - хүн бүр нас, хүйс, хөгжлийн бэрхшээлээс үл хамааран хотын амьдралд оролцох, боломжийг эдлэх, барилга, байгууламжийн орчинд нэвтрэх нөхцөлтэй хотыг хэлнэ. Хүн бүрийн шударга, тэгш оролцоог хангасан хот гэсэн үг.

Хамруулсан орчин - Нас, хүйс, хөгжлийн бэрхшээлээс үл хамааран ихэнх хүмүүсийн хэрэглэдэг, хүртээмжтэй орчныг хэлнэ. Энэ нь хамруулсан загварын зарчим болон хүн бүрийн ялгаатай байдлыг анхааралдаа авч, нийгэмд хүртээмж, боломж, оролцоо, тэгш байдлыг хөхиүлэн дэмждэг.

Дэд бүтэц – Энэ нь нийгмийг дэмждэг биет болон зохион байгуулалтын бүтэц, үйлчилгээ, хэрэгсэл юм. Сайн дэд бүтэц нь эрүүл мэнд, сайн сайхан байдал зэрэг таатай нөхцөл байдлыг дэмждэг. Энэ нэр томъёонд ихэвчлэн тээвэр, ус, хаягдал усны систем, эрчим хүч, харилцаа холбооны салбар, эрүүл мэнд, боловсрол, нийгмийн халамжийн систем зэргийг багтаасан нийгмийн хамгааллын бүтэц хамаарна¹. Энэхүү тайланд зориулан хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн өдөр тутмын амьдрал, нийгэм дэх оролцоог хангахад хувь нэмэр оруулах бүхий л (биет, институтийн эсвэл дижитал) бүтцийг дэд бүтцийн хүрээн дор багтаан судалсан.

Хамруулсан дэд бүтэц – Нас, хүйс, хөгжлийн бэрхшээлээс үл хамааран ихэнх хүмүүсийн хэрэглэдэг, хүртээмжтэй дэд бүтцийг хэлнэ. Илүү хамруулсан нийгмийг дэмжих дэд бүтэцтэй болоход тулгарч байгаа бэрхшээлүүдэд идэвхтэй хариу үзүүлдэг. Энэ нь хамруулсан загварын зарчим болон хүн бүрийн ялгаатай байдлыг анхааралдаа авч, нийгэмд хүртээмж, боломж, оролцоо, тэгш байдлыг хөхиүлэн дэмждэг.

Хамруулсан загвар – Барилга, газар, орон зай нь бүх хүнд зориулагдсан, түүнийг ашиглахад тохитой хялбар байх загварын хандлагыг хэлнэ. Хамруулсан загвар нь дэлхийн бүх хүн төрөлхтөн аюулгүй, хүртээмжтэй орчныг бий болгож шударга, тэгш амьдрахад тусална.

Түгээмэл загвар – Ямар нэгэн тохируулга, тусгайлсан загвар шаардахгүйгээр ихэнх хүмүүсийн ашигладаг, ойлгодог, хүртдэг орчны нийлбэр загвар юм. Түгээмэл загвар нь

¹ Anjlee Agarwal and Andre Steele, 'Disability Considerations for Infrastructure Programmes' (Evidence on Demand, 8 March 2016), https://doi.org/10.12774/eod_hd.march2016.agarwaletal.



долоон үндсэн зарчмаар зохион байгуулагддаг: хүн бүр ашиглах боломжтой, ашиглахад уян хатан, хэрэглэхэд энгийн, мэдээлэл нь ойлгомжтой, ямар нэг осол, санамсаргүй зүйл гаргахыг аль болох багасгасан, биеийн хүч бага шаардах, хэмжээ, зай аль болох бага эзлэн ашиглагдах

Хүртэх – Бараа, үйлчилгээ, орчин нь тэгш үндсэн дээр тасралтгүй явагдах харилцааг хэлнэ

Хүртээмж – Хөгжлийн бэрхшээл, нас, хүйсээс үл хамааран биет орчинд (тээвэр, мэдээлэл, харилцаа /мэдээллийн болон харилцааны технологи, тогтолцоо/, нийтэд нээлттэй байгууламж, үйлчилгээ гэх мэт) орох, хүрэх, ашиглах боломжтой байхыг хэлнэ.

Боломжит тохируулга – тогтолцоо, орчин, дэд бүтэц, үйлчилгээ, бүтээгдэхүүнийг хүртэхэд боломжийн болгож тохируулж, хүн бүрд ашиглахад шударга, ямар нэгэн ялгаварлан гадуурхалт үүсгэхгүй байх. Эдгээр өөрчлөлт, тохируулгыг хувь хүний хэрэгцээнд тохируулж хийх ба ингэснээр нийгэмд хамрагдахад дэмжлэг болно.



Товчилсон үгийн тайлбар

АХБ: Азийн хөгжлийн банк

АИФО: Раул Фолерогийн анд нөхдийн холбоо, Италийн төрийн бус байгууллага

ТТ: Туслах технологи

ТТ2030: Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант улсын тусламжийн санхүүжилттэй хөтөлбөр, 'Хүн бүрд зориулсан ямар туслах технологи амьдралыг өөрчлөх боломжтойг судалж байна'

ХБИБ: Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллага

ГХНХА (FCDO): Гадаад, хамтын нөхөрлөл, хөгжлийн алба (хуучнаар DFID гэж нэрлэдэг байсан)

GDI hub: Дэлхийн Хөгжлийн Бэрхшээлийн Инновацын Сүлжээ

БДАТ: Бие даан амьдрах төв

БДОУ: Бага, дунд орлоготой улсууд

ШХХА: Шинэ хотын хэлэлцэх асуудал

ХБИ: Хөгжлийн бэрхшээлтэй иргэд

ТХЗ: НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилтууд

УЭААЦ: Ус, эрүүл ахуй, ариун цэвэр

ДЭМБ: Дэлхийн эрүүл мэндийн байгууллага

НҮБ: Нэгдсэн Үндэстний Байгууллага

ХБХЭК: Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай НҮБ-ын конвенц



ТТ2030 ба Хамруулсан Дэд бүтэц Хөтөлбөрийн мэдээлэл

ТТ2030 –ын тухай

Энэ судалгаа нь Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант улсын Гадаад, хамтын нөхөрлөл, хөгжлийн албаны тусламжийн санхүүжилттэй “ТТ2030: Хүн бүрд зориулсан амьдралыг өөрчлөх туслах технологи” хөтөлбөрийн нэг хэсэг юм. ТТ2030 хөтөлбөр нь бүх нийтийн амьдралыг өөрчлөх туслах технологийн (ТТ) хүртээмжийг сайжруулахад юу тус болохыг олж илрүүлэх зорилготой юм. Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (ДЭМБ)-ын тооцоолсноор одоогоор дэлхий дээр туслах технологи шаардлагатай 1 тэрбум хүн байдаг ч тэдний 90% орчим нь туслах технологи ашиглах боломжгүй байгаа ба энэ тоо 2050 он гэхэд 2 тэрбумд хүрэх төлөвтэй байна. Хөтөлбөр нь судалгаа, нотлох баримт, инновац, улс орны хэрэгжүүлэлт, чадавх, оролцооны салбарыг хамарсан үйл ажиллагаагаараа 9 сая хүнийг шууд, 6 сая хүнийг шууд бусаар хамруулах зорилготой юм. Хөтөлбөр нь одоогоор 33 оронд хэрэгжиж байгаа бөгөөд маш өргөн хүрээнд хамтрагчидтай ажилладаг².

Хамруулсан дэд бүтцийн тухай

ТТ2030-ын хамруулсан дэд бүтцийн дэд хөтөлбөр нь туслах технологи шаардлагатай бүх хүмүүс туслах технологийг амжилттай олж авах, ашиглах нь хүртээмжтэй, хамруулсан орчин, дэд бүтцийг дэмжихээс хамаарна гэсэн санаанаас үүдэлтэй.

'Хамруулсан загвар' нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн орчныг бүрдүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг гэж Дэлхийн хөгжлийн бэрхшээлийн инновацийн Сүлжээ (GDI Hub) үздэг³. Дэлхийн хотуудын хүртээмжийн одоогийн нөхцөл байдлыг судалж, бодлого, аж үйлдвэрт хамруулсан загварыг бий болгох нь туслах технологийг илүү хүртээмжтэй болгож, туслах технологи хэрэглэдэг бүх хэрэглэгчдийг хамруулж оролцуулахад чухал шаардлагатай байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хамруулах, хамруулсан загварын одоогийн ойлголт нь өндөр орлоготой орнуудад болдог гэсэн хязгаарлагдмал ойлголттой байна⁴. Харин энэхүү судалгаа нь бага, дунд орлоготой орнуудад хамт олон, үйлдвэр, бодлого боловсруулагчидтай шууд холбоо тогтоож, олон ялгаатай нөхцөл байдалд хамруулсан

² For further information on the AT2030 programme please visit <http://www.at2030.org>

³ For more information on GDI Hub's approach to inclusive design please visit: <http://www.disabilityinnovation.com/inclusive-design>

⁴ For more information on GDI Hub's approach to inclusive design please visit: <http://www.disabilityinnovation.com/inclusive-design>



орчныг юу бүрдүүлж байгаа талаарх онцгой мэдлэгийг цуглуулахыг зорьсон юм. Энэ нь бүхий л ялгаатай нөхцөл байдалд тохирох хамруулсан загварын талаарх мэдлэгийг бий болгож үйл ажиллагааг эхлүүлэх юм. Судалгаа нь гурван чиглэлээр явагдана.

1. Тухайн орчинд амьдарч буй хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс болон барилга байгууламжийн орчны талаарх туршлагаас хуваалцах;
2. Аж үйлдвэрт анхаарлаа хандуулсан ойлголтын талаарх эрдэм шинжилгээний судалгаа, хамруулсан загварыг амьдрал дээр хэрэглэх;
3. Засаглал, хамруулсан загвар, хүртээмжийн удирдамж, протоколын талаарх бодлогод анхаарлаа хандуулсан эрдэм шинжилгээний өндөр зэрэглэлийн судалгаа хийх.

Чанарын болон оролцооны аргаар судалгаа хийж, барилга байгууламжийн орчинд нөлөөлдөг болон сонирхсон янз бүрийн оролцогч талуудыг (шийдвэр гаргагчид, хот төлөвлөгчид, архитекторууд болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс гэх мэт) татан оролцуулсан. Ингэснээр хамруулсан барилга байгууламжийн орчин, хамруулсан, хүртээмжтэй дэд бүтцийн талаарх бэрхшээл болон боломжуудын талаар шинэ ойлголтыг бий болгож, янз бүрийн орчин, нөхцөл, соёл иргэншилд тохирсон хамруулсан загвар ямар байж болохыг тодруулах болно.

Хүртээмжтэй дэд бүтэц судалгаа нь:

- Гурван жилийн судалгааны хөтөлбөр
- Бага, дунд орлого бүхий 6 орны 6 хотод
- Орон нутгийн түншлэгч нар, олон оролцогч талуудтай хамтран
- Барилга байгууламжийн орчинд бодлого, үйлдвэрлэл, олон нийтийн түвшинд судална.

Яагаад “хамруулсан дэд бүтэц” чухал вэ?

“Хүртээмж” нь аливаа хэлбэрээр хөгжлийн бэрхшээл ба ядуурлын хоорондох анхдагч хүчин зүйл болдог. Хөдөлмөр эрхэлж чадахгүй байх, үндсэн дэд бүтэц болох ус, цахилгаан дутмаг байх эсвэл эмэгтэйчүүдэд аюулгүй орчин бий болгож чадахгүй байх тохиолдолд, тэгш бус байдал, нийгмийн гадуурхал нэмэгддэг. Энэ нь хөгжлийн бэрхшээл эсвэл ядуурлын аль алиных нь шалтгаан, үр дагавар байж болох бөгөөд хөгжлийн бэрхшээл ба

ядуурлын хоорондын холбоог бэхжүүлэх⁵ ⁶ "хортой цикл"⁷ гэж тодорхойлдог. Тухайлбал, Монгол Улсад дор хаяж нэг хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй өрхийн амьдралын түвшин бусад өрхийн амьдралын түвшнээс хоёр дахин ядуу байдаг⁸. Ядуурлын олон хэмжээст шинж чанарын судалгаагаар дунд орлоготой нөхцөлд хөгжлийн бэрхшээлтэй өрхүүдийн ядуурал бага орлоготой өрхтэй харьцуулахад харьцангуй өндөр байгааг харуулсан нь 'хөгжлийн бэрхшээлийн хөгжлийн цоорхой'⁹ байгааг харуулж, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хамруулан хөгжүүлэх хөтөлбөрүүдийн ач холбогдлыг тодорхой харуулж байна.

Хүмүүс хангалттай орон зайнд, хүссэн үйлчилгээ, үйл ажиллагаагаа хүртэх эрхтэй ба хүртээмжийг НҮБ-ын ХБХЭК¹⁰-д эдлэх ёстой нэгэн эрх болгож заасан байдаг. Барилга байгууламж, дэд бүтэц нь хүртээмжийг бий болгодог эсвэл байхгүй болгодог бөгөөд үүнийг хүрээлэн буй орчинд өөрийн дураар нэвтрэх чадваргүй хүмүүс, ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс хамгийн гүнзгий ойлгодог¹¹. Хөгжлийн бэрхшээлийн циклийг болон тэгш бус байдлыг таслан зогсоохын тулд хүртээмжтэй, хамруулсан орчныг төлөвлөх нь нэн чухал юм. Үүнийг хийхийн тулд барилга байгууламжийн орчны хүртээмжид ямар саад бэрхшээлүүд байгаа, хүртээмжтэй орчныг төлөвлөх, барих, хэрэгжүүлэх, зохицуулахад ямар саад бэрхшээл тулгарч байгаа талаар зөвшилцөлд хүрэх ёстой. Хөгжлийн бэрхшээлийн шударга байдалд суурилсан хандлага, барилга байгууламжийн орчин нь илүү тэгш нийгмийг бий болгоход хүртээмжтэй дэд бүтцийг төлөвлөх, бий болгохын ач холбогдлыг онцолж "хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хувьд хангалттай орон зай төлөвлөх нь шударга ёсыг баримталж буй явдал юм"¹² гэж санал болгож байна.

Дэд бүтэц, тээвэр, барилга байгууламжийн орчин нь аль ч улс орны хөрөнгө оруулалтын томоохон салбаруудын нэг бөгөөд дэд бүтцийн хувьд "сайн" нь эерэг өөрчлөлт, хөгжлийн зорилгод хүрэхэд түлхэц болдог. Дэд бүтэц нь нийгмийг дэмжихэд зориулагдан төлөвлөгдсөн байх ёстой. Харин хүртээмжгүй тохиолдолд хувь хүмүүс эсвэл тодорхой

⁵ Christoffel J. Venter, Thomas E. Rickert, and David A. C. Maunder, 'From Basic Rights to Full Access: Elements of Current Accessibility Practice in Developing Countries', *Transportation Research Record: Journal of the Transportation Research Board* 1848, no. 1 (January 2003): 79–85, <https://doi.org/10.3141/1848-11>.

⁶ Department for International Development, UK Government, 'Disability, Poverty and Development'.

⁷ Department for International Development, UK Government, 'Disability, Poverty and Development' (Department for International Development, 2000).

⁸ Asian Development Bank, 'Living with Disability In Mongolia: Progress Toward Inclusion' (Manila, Philippines: Asian Development Bank, December 2019), <https://doi.org/10.22617/TCS190596-2>.

⁹ Monica Pinilla-Roncancio and Sabina Alkire, 'How Poor Are People With Disabilities? Evidence Based on the Global Multidimensional Poverty Index', *Journal of Disability Policy Studies*, 17 May 2020, 104420732091994, <https://doi.org/10.1177/1044207320919942>.

¹⁰ Disability Inclusive and Accessible Urban Development Network (DIAUD), World Enabled, and CBM, 'The Inclusion Imperative: Towards Disability-Inclusive and Accessible Urban Development. Key Recommendations for an Inclusive Urban Agenda', 2016, 40.

¹¹ Aimi Hamraie, 'Designing Collective Access: A Feminist Disability Theory of Universal Design', *Disability Studies Quarterly* 33, no. 4 (5 September 2013), <https://doi.org/10.18061/dsq.v33i4.3871>.

¹² Victor Santiago Pineda, 'Enabling Justice: Spatializing Disability in the Built Environment', n.d., 14.



бүлэг хүмүүсийг хасаж, амьдралын чанарыг бууруулж, хүний эрхийг зөрчдөг.

Доогуур орлоготой газруудад дэд бүтцийн үндсэн хэрэгцээ маш их байдаг ба хүртээмжийг нэмэлт зүйл гэж үздэг бөгөөд дэд бүтэцдээ тооцох нь ховор байдаг¹³. Хүртээмжгүй дэд бүтэц нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрх чөлөө, хараат бус байдал, эрх, боломж ашиглах байдал зэрэгт гүнзгий нөлөөлдөг. Хүртээмжгүй дэд бүтцийг бий болгоход нөлөөлж буй зарим хүчин зүйлүүдэд төлөвлөлтүүдийн сонголтуудын талаар шийдвэр гаргагчдын ойлголт дутмаг, ижил тэгш байдлыг бий болгоход боломжийг алдаж, тал бүрийн хэрэгцээг анхаарч, хэрэглэгчийн байр суурийг анхаараагүй байдаг¹⁴. Хамруулсан дэд бүтцийн талаар iBuild төвийн удирдсан өмнөх судалгаагаар дэд бүтцийн урт хугацааны олон түвшний ашиг тусыг тооцож, илүү цогц хандлага, ойлголттой байхын ач холбогдлыг чухалчилсан¹⁵.

Дэлхийн Хөгжлийн бэрхшээлийн тайланд¹⁶ хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст 'орчин бүрдүүлэх' -ийн ач холбогдлыг онцлон тэмдэглэж, эдгээр орчныг биет, нийгэм, хандлагын орчин гэж тодорхойлжээ. Доогуур орлоготой газарт хүртээмжийн орчны талаарх бодлого, дагаж мөрдөх болон стандартуудын тохиромжтой байдал зэргийг хэрэгжүүлэхэд албан бусаар нүүн суурьших, хөдөө орон нутаг зэрэг нь орчин нөхцөлийг бүрдүүлэхэд саад болж байна гэж үзсэн. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн дэмжих технологи нь хурдацтай хөгжиж буйг уг тайланд дурдаад барилга байгууламжийн орчныг зохицуулахад илүү уялдаатай, дасан зохицох боломж бүхий орчин дах стандарт, дүрэм журмыг боловсруулах шаардлагатайг санал болгожээ¹⁷.

Хамруулсан загварыг цогцоор нь ойлгож, дэд бүтцийн хөтөлбөрүүдэд хэрэгжүүлбэл тэдгээр саад бэрхшээлийг арилгах болно. Аливаа улс оронд хөрөнгө оруулалтын томоохон чиглэлүүдийн нэг болох дэд бүтцийн хөгжил нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд таатай орчныг бүрдүүлэхэд тэргүүлэх боломжтой байдаг¹⁸.

¹³ The World Health Organisation, 'World Report on Disability' (The World Health Organisation, 2011).

¹⁴ Agarwal and Steele, 'Disability Considerations for Infrastructure Programmes'.

¹⁵ Richard Dawson, 'Delivering Effective and Inclusive Infrastructure', ESRC Evidence Briefings (Economic and Social Research Council, March 2018), <https://esrc.ukri.org/news-events-and-publications/evidence-briefings/delivering-effective-and-inclusive-infrastructure/>.

¹⁶ The World Health Organisation, 'World Report on Disability'.

¹⁷ The World Health Organisation.

¹⁸ Hamraie, 'Designing Collective Access'.

Яагаад доогуур орлоготой хотуудад анхаарлаа хандуулах хэрэгтэй вэ?

Дэлхий хурдтайгаар хотжиж, нийт дэлхийн хүн амын талаас илүү нь хотод амьдарч байна¹⁹. Энэ өсөлт нь дэд бүтцийн өсөлттэй үргэлж тэнцвэртэй яваад байдаггүй ба хотын хөгжлийг хоёр хэсэг болгож, тэгш бус байдлын том цоорхойг үүсгэхэд нөлөөлдөг²⁰. Бага, дунд орлоготой бүс нутагт хотжилт хамгийн ихээр явагдаж, “ядуурал нь хотжиж” байна²¹. 2050 он гэхэд дэлхийн хүн амын 66% нь хотод амьдрах болно; Үүний 90% нь бага, дунд орлоготой нөхцөлд байх болно²². НҮБ-ын тооцоогоор хотуудын иргэдийн 75% нь суурь үйлчилгээ авах, чанартай нийтийн орон зайтай байх, боломжийн үнээр орон сууц худалдан авах, амьжиргааны боломж зэргээр хорин жилийн өмнөхөөс харьцангуй бага болж энэ мэт орон зайн тэгш бус байдал нийгмийн гадуурхлыг улам бүр дордуулж байна²³. Хот дэд бүтэц сайтай, үйлчилгээ авах, ажиллах, боловсрол эзэмших зэрэг боломжуудтай байх нь нийгэмшихэд амин чухал юм.

Дэлхийн банкны үзэж байгаагаар хот суурин газрын хамруулалт нь олон талт шинжтэй бөгөөд орон зайн хамруулалт, нийгмийн хамруулалт, эдийн засгийн хамруулалт гэсэн гурван хүрээнд илэрхийлэгддэг²⁴. Эдгээр гурван чиглэл нь хүртээмж (орон сууц, газар, зам талбай, зайлшгүй шаардлагатай үйлчилгээ гэх мэт), боломж (боловсрол, хөдөлмөр эрхлэлт эсвэл оршин сууж буй газрынхаа хөгжил цэцэглэлтийг нэмэгдүүлэхэд оролцох гэх мэт), оролцох эрх (нийгэмд оролцох чадвар) гэсэн зарчмууд дээр тулгуурладаг. Эдгээр зарчмууд нь хамруулсан дэд бүтцийг төлөвлөх үндсэн суурь болдог.

Хөгжлийн бэрхшээлийг хамруулсан дэд бүтцийн хувьд "юу тохирч байгаа" талаар хийсэн судалгаагаар хотыг бүхлээр нь, цогц байдлаар харах нь нэг төрлийн буюу бусдаас тусгаарласан маягийн дэд бүтцийн шийдлээс зайлсхийх нь чухал болохыг харуулж байна. Нэмж дурдахад, доогуур орлоготой газруудад дэд бүтцийн томоохон бүрэлдэхүүн хэсгүүдийг нэмж барих шаардлагатай байгаа ба бага, дунд орлоготой хотуудад хамруулсан дэд бүтцэд анхаарлаа хандуулж, ‘эхнээс нь зөв хийх’ боломж байна²⁵.

¹⁹ Bharat Dahiya and Ashok Das, ‘New Urban Agenda in Asia-Pacific: Governance for Sustainable and Inclusive Cities’, in *New Urban Agenda in Asia-Pacific*, ed. Bharat Dahiya and Ashok Das, *Advances in 21st Century Human Settlements* (Singapore: Springer Singapore, 2020), 3–36, https://doi.org/10.1007/978-981-13-6709-0_1.

²⁰ Dahiya and Das.

²¹ The World Bank, ‘World Inclusive Cities Approach Paper’ (The World Bank, May 2015).

²² ‘New Urban Agenda’ (United Nations, 2017).

²³ UN-Habitat, ‘Flagship Programme 1: Inclusive, Vibrant Neighbourhoods and Communities’ (UN-Habitat), accessed 19 September 2020, <https://unhabitat.org/programme/inclusive-vibrant-neighbourhoods-and-communities>.

²⁴ The World Bank, ‘World Inclusive Cities Approach Paper’.

²⁵ Infrastructure and Cities for Economic Development (ICED), ‘Delivering Disability Inclusive Infrastructure in Low Income Countries’.



Дэлхийн зорилготой нийцсэн эсэх?

Хотууд, ялангуяа доогуур орлоготой хотууд нь НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилтууд 2030 хөтөлбөрийн цөм бөгөөд үүнийг ТХЗ-ын 11 дүгээр зорилгод “Хотуудыг болон оршин суугчдыг хамруулсан, аюулгүй, уян хатан, тогтвортой байлгах” гэж хамгийн тодорхой тэмдэглэсэн байдаг. Амьдрах орчин (Habitat) III ба Хот байгуулалтын шинэ хөтөлбөрт нь хотууд болон хотжилт нь ядуурал, гадуурхлын шалтгаан болох боломжтой боловч хот суурин газрыг тогтвортой хөгжилд оролцооны хандлагаар дамжуулж хөгжлийн явцад хамруулах чухал гэж үзэх хандлагад шилжих нь чухал болохыг тэмдэглэв. Эдгээр дэлхийн хөтөлбөрүүд нь ‘хамруулсан хотууд’ сэдвээр олон тооны хэлэлцүүлэг өрнүүлсэн²⁶ ²⁷ ²⁸. Гэсэн хэдий ч хамруулсан хотуудын талаар өргөн цар хүрээтэй ярилцаж, хөгжлийн бэрхшээлийг хамруулсан хот гэдэг утгаар ярьдаг хэдий ч хамруулсан, хамруулсан орчныг төлөвлөх, бий болгох ажлыг дээд хэмжээний бодлогын хөтөлбөрт тусгах байдал нь хязгаарлагдмал хэвээр байна.

НҮБ-ын 2030 хөтөлбөр нь хөгжлийн бэрхшээлийг хамруулах нь ядуурлыг арилгах гол цөм байх ёстой гэж хүлээн зөвшөөрч²⁹, НҮБ-ын ХБХЭК-ийн 9-р зүйл, 'Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг бодитой болгох нь' 2012 оны Инчеоны стратегийн 3-р зорилтод "Биет орчин, нийтийн тээвэр, мэдлэг, мэдээлэл, харилцаа холбоо нь хамруулсан нийгэмд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхээ эдлэх урьдчилсан нөхцөл юм" гэсэн бөгөөд дээрх олон улсын хөтөлбөрүүд нь биет орчин болон хамруулсан нийгэмд бий болгоход онцгойлон холбогдож байна. 2018 онд болсон Дэлхийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн дээд хэмжээний уулзалтаас хамруулсан дэд бүтэц нь дэд бүтцийн салбар дах хөгжлийн бэрхшээлтэй холбоотой зургаан асуудлуудын нэг хэмээн онцолсон юм³⁰. Үүнийг бодит болгоход доогуур орлоготой бүс нутагт хөгжлийн бэрхшээлийг хамруулах загварын талаарх бодлого, мэдлэг ойлголт, удирдамжийг мэдэх зайлшгүй шаардлагатай бөгөөд бидний 6 хотод хийж буй кейс судалгаа нь эдгээр бодлогын зорилтуудыг амьдралд бодит ажил хэрэг болгоход туслах болно.

²⁶ Asian Development Bank, 'Enabling Inclusive Cities: Tool Kit for Inclusive Urban Development' (Manila, Philippines: Asian Development Bank, 1 December 2016), <https://doi.org/10.22617/TIM157428>.

²⁷ The World Bank, 'World Inclusive Cities Approach Paper'.

²⁸ Diana Mitlin and David Satterthwaite, 'On the Engagement of Excluded Groups in Inclusive Cities: Highlighting Good Practices and Key Challenges in the Global South', Urban Development Series Knowledge Papers (The World Bank, 2016).

²⁹ The World Health Organisation, 'World Report on Disability'.

³⁰ Infrastructure and Cities for Economic Development (ICED), 'Delivering Disability Inclusive Infrastructure in Low Income Countries'.



Яагаад хамруулсан буюу хамруулсан загвар гэж?

“Хамруулсан буюу хамруулсан загвар нь нийгмийн бүх гишүүдэд аюулгүй, хүртээмжтэй орчин бүрдүүлэх замаар бүх хүн төрөлхтөн өөрийн эргэн тойронд шударга, тэгш байдлыг мэдрэхэд нь туслах болно”³¹.

Их Британи, Умард Ирландын Нэгдсэн вант улсын Олон улсын хөгжлийн газар (одоогийн FCDO буюу Гадаад, хамтын нөхөрлөл, хөгжлийн алба)-ын тодорхойлсноор хамруулсан буюу хамруулсан загвар нь ‘хөгжлийн бэрхшээлийг хамруулсан дэд бүтэцтэй болгох’ зургаан гол боломжийн талбарын нэг хэмээн онцолжээ³².

Хүртээмжтэй орчин нь ихэвчлэн явахад чөлөөтэй нэвтрэх боломжийг олгодог орчин гэж тооцогддог бол хамруулсан орчин нь бүр цаашилж барилга байгууламжийн орчин болон дэд бүтэц дэх тэгш байдлыг харгалзан үздэг. Хамруулсан орчин нь ялгаатай байдал, уян хатан байдлыг агуулдаг бөгөөд хүн бүр өөр өөр хэрэгцээтэй бөгөөд мөн эдгээр хэрэгцээ байнга өөрчлөгдөж байдаг гэдгийг ойлгодог³³.

Хамруулсан буюу хамруулсан загвар гэдэг нь бодит оролцоо ба инновац бөгөөд хүмүүсийг сонсох тэдэнд зориулж орон зай гаргах явдал юм. Өөрөөр хэлбэл дизайны асуудлыг шийдвэрлэхэд оролцоог хангаж, ялгаатай байдлыг хамруулсан, хүлээн зөвшөөрсөн практик юм. ‘Нэг хэмжээ нэг хүнд тохирох’, ‘нийтлэг шийдэл’ нь хүн бүрийг хамруулахад оновчтой биш бадгаараа хамруулсан загвараас ялгаатай юм³⁴. Хамруулсан буюу хамруулсан загвар нь нийгмийн гадуурхалтыг багасгахад³⁵ тусалж, барилга байгууламжийн орчныг хамруулсан загвар нь хотын хүртээмж, боломж, оролцоог хангаж, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг эдийн засаг, нийгмийн оролцоонд өргөнөөр хувь нэмрээ оруулах боломжийг олгодог.

Дэлхий дээр 1 тэрбум хүн туслах технологи ашиглах шаардлагатай, мөн хүн ам насжиж байгаа, тэгш бус байдал улам бүр доройтож, энэ ертөнцөд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хүртээмжийг хязгаарлаж байгаа нь бидний сонголт биш юм. Хамруулах нь хүн бүрд ашигтай байх ёстой.

³¹ Global Disability Innovation Hub, Queen Elizabeth Olympic Park, and London Legacy Development Corporation, ‘Inclusive Design Standards’, May 2019.

³² Infrastructure and Cities for Economic Development (ICED), ‘Delivering Disability Inclusive Infrastructure in Low Income Countries’

³³ Global Disability Innovation Hub, Queen Elizabeth Olympic Park, and London Legacy Development Corporation, ‘Inclusive Design Standards’.

³⁴ World Economic Forum: Strategic Intelligence, ‘Global Issue: Inclusive Design. Curated by the Smithsonian Institution’, World Economic Forum: Strategic Intelligence, accessed 12 September 2020, <https://intelligence.weforum.org/topics/a1G0X0000057IniUAE?tab=publications>.

³⁵ Dr Ellie Cosgrave, ‘The Role of the Engineer in Creating Inclusive Cities’, n.d., 16.



Хамруулсан буюу хамруулсан загварын зарчим, арга аргачлал, туршлагыг хотын хөгжлийг загварчлахдаа бодлого, хотын мастер төлөвлөгөө, замын дэд бүтэц, барилга, үйлчилгээний судалгаа бага, хязгаарлагдмал нөөц бололцоотой үед хамруулсан буюу хамруулсан загварыг хэрхэн бий болгох талаар ойлгохын тулд судалгаа шинжилгээ хийх шаардлагатай.

Хамруулсан буюу хамруулсан загварын хандлага, туршлагыг биет орчин хүртээмжтэй байхаас илүү зүйлд хэрэглэж болно. Асуудлын төвд хөгжлийн бэрхшээлтэй хүний дуу хоолойг гаргаж, салбар хоорондын уялдаа холбоог бий болгоход ашиглаж болно. Хамруулсан буюу хамруулсан загвар нь Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагын хөгжлийн бэрхшээлтэй тэмцэх үйл ажиллагааны төлөвлөгөөг биелүүлэхэд ‘соёлын онцлогт тохирсон хүн төвтэй хандлага’-ыг хөгжүүлэх арга хэлбэрийг санал болгож хувь нэмрээ оруулж болно³⁶.

Хотын хөгжилд чиглэсэн тусгаарлагдсан арга хэмжээнүүд нь амжилтад хүрэхгүй байгааг нотолгоо харуулж байна. Хотуудын амьдралын чанарыг дээшлүүлэхийн тулд хөндлөнгийн оролцоо, хот байгуулалтын хөтөлбөрүүд нэгдмэл, урт хугацааны туршид тогтвортой байх шаардлагатай³⁷. Хамруулсан буюу хамруулсан загвар нь шийдвэрлэх шаардлагатай бэрхшээлүүдийн талаар хамгийн их мэдлэгтэй хүмүүсийг нэгтгэж, нөхцөл байдалд суурилсан төлөвлөлт, загварын талаар гүнзгий ойлголттой болохыг шаарддаг. Хөгжлийн бэрхшээлийг хамруулсан дэд бүтцэд хамруулсан буюу хамруулсан загварыг ашиглах нь зөвхөн техникийн загвар дээр суурилагаас гадна амьдрал дээр хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан хотыг хөгжүүлэхэд салбар хоорондын болон олон сэдвүүдийг хөндөхөд зуучилдаг.

Бид юуг олж мэдэхийг хүсэж байна вэ?

Энэхүү дэд хөтөлбөрийн хүрээнд судалгааны асуулт нь ”бага, дунд орлоготой орнуудын хамруулсан, хамруулсан орчны одоогийн нөхцөл байдал ямар байгаа, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн нийгмийн оролцоог хангахад хамруулсан загвар ямар үүрэг гүйцэтгэж байна вэ?”.

³⁶ F Khan et al., ‘World Health Organization Global Disability Action Plan: The Mongolian Perspective’, *Journal of Rehabilitation Medicine* 50, no. 4 (2018): 388–366, <https://doi.org/10.2340/16501977-2207>.

³⁷ Dahiya and Das, ‘New Urban Agenda in Asia-Pacific’. Pg.23



1. Судалгаа явагдаж буй хотын барилга, байгууламжийн хүртээмж болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалахад ямар хууль, бодлого, дүрэм журам, заавар байна вэ?
2. Судалгаа хийж буй хотын гол оролцогч талуудын дунд барилга байгууламжийн орчин, бодлого, төлөвлөлт, зураг төсөл, бүтээн байгуулалтад хамруулсан буюу хамруулсан загварыг ашиглах өнөөгийн ойлголт, хандлага, хүлээн зөвшөөрөлт, хэрэглээ ямар байна вэ?
3. Судалгаа хийж буй хотод хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан барилга байгууламжийн орчин бүрдүүлэхэд тулгарч буй саад бэрхшээл болон боломжууд юу вэ?
4. Хамруулсан загвар нь туслах технологи болон туслах технологи хэрэглэгчдэд таатай орчныг бүрдүүлэхэд хэрхэн хувь нэмэр оруулах вэ?



Монгол улсад хийсэн кейс судалгааны танилцуулга

Энэ судалгааны зорилго нь Монгол улсын Улаанбаатар хотын хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан хамруулсан, хүртээмжтэй орчны нөхцөл байдлыг бодлого, үйлдвэрлэл, хамт олны оролцогч талуудын тусламжтайгаар судлахад оршино.

Дэлхийн доогуур орлоготой орнуудад хүртээмж, хамруулсан загварын нөхцөл байдлыг судлах зургаан судалгааны эхнийх нь юм. Эдгээр зургаан бие даасан судалгааг харьцуулж, тайлан боловсруулж, эцэст нь доогуур орлоготой улс орны нөхцөлд дэд бүтэц, барилга байгууламжийн орчин, хот байгуулалтыг илүү хүртээмжтэй, хамруулсан болгоход дэмжлэг үзүүлэх нотолгоо, зөвлөмжийг дэлхийн үйл ажиллагааны тайлангаараа дамжуулан хүргэх юм.

Ази Номхон далайн бүсэд хотын эдийн засгийн өсөлт харилцан адилгүй, тэгш бус байдаг бөгөөд хотын доогуур орлоготой иргэд энэ ачааллыг үүрдэг. Энэ бүсэд дэлхийн нийт хүн амын талаас их нь амьдарч байгаа ба хотжилт улам бүр ихэссээр байна³⁸. Ази Номхон далайн бүсийн хотуудад хамгийн тэгш бус байдал нь орон сууц, дэд бүтэц, үйлчилгээ ба хүртээмжтэй нийтийн тээврийн хэрэгслийн асуудал юм³⁹. Хот байгуулалтын эдгээр тэгш бус байдал нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст харьцангуйгаар нөлөөлж байгаа бөгөөд эдгээр кейс судалгаанууд нь Ази, Африкийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн амьдрах орчин, барилга байгууламжийн хүртээмжийн талаарх судалгаагаар гаргаж ирэх юм.

Ийнхүү хурдацтай хотжиж буй Азийн хотуудын нэг бол Улаанбаатар хот юм. Монгол бол далайд гарцгүй орон бөгөөд дэлхийн хамгийн цөөн хүн амтай улс. 1990-ээд оны эхээр ардчилал, чөлөөт зах зээлийн эдийн засагт шилжсэнээс хойш тус улс эдийн засаг, нийгэм, улс төрийн хүрээнд хурдацтай өөрчлөгдөж байна. Эдгээр өөрчлөлтүүд нь хүртээмжтэй өсөлтийг хангах улс төрийн амбицтай хамт дагалддаг. Гэсэн хэдий ч Монгол дах нийгмийн гадуурхлын хэмжүүрүүд нь нарийн төвөгтэй тул нийгэм, соёл, байгаль орчин, эдийн засаг, улс төрийн хүчин зүйлийг харгалзан үзэх ёстой бөгөөд үүнд Монголын нүүдэлчин ба бэлчээрийн мал аж ахуйн түүхийг багтаасан болно. Монгол дах нийгмийн оролцооны талаар хийсэн судалгаагаар бодлогын өгүүлэмж, амьдралын

³⁸ Dahiya and Das.

³⁹ Judy L. Baker and Gauri U. Gadgil, eds., *East Asia and Pacific Cities: Expanding Opportunities for the Urban Poor* (The World Bank, 2017), <https://doi.org/10.1596/978-1-4648-1093-0>. Pp. XVIII

туршлага⁴⁰ нь оролцоо, хүртээмжтэй хөгжлийн хандлагын ач холбогдлыг үргэлж харуулж чаддаггүй болохыг харуулж байна.

Улаанбаатар бол тус улсын 3 сая оршин суугчдын тал орчим хувь нь амьдардаг Монгол Улсын нийслэл хот юм⁴¹. Хотын оршин суугчдын 60-70 орчим хувь нь хотын төвийг тойрсон төлөвлөөгүй суурин газруудад ‘Гэр хороолол’ гэж нэрлэгддэг газарт амьдардаг⁴². Хотын ихэнх хэсэг нь Зөвлөлт Холбоот Улсын нөлөөнд хөгжсөн бөгөөд түүний үлдэгдэл нь архитектур, хот төлөвлөлтөөс харагдаж байна⁴³. 20-р зууны хоёрдугаар хагаст хот хурдацтай хотжиж эхэлсэн үеэс гэр хороолол хөгжиж эхэлсэн. Улаанбаатар хот болон үүнээс үүдэн гарч буй гэр хорооллын хөдөө орон нутгаас шилжин суурьшихад тулгараад буй бэрхшээл, бэрхшээлийг даван туулахад хариу арга хэмжээ авах арга хэлбэрийг Монгол Улс хамруулсан, тогтвортой хөгжлийг хангахад тулгарч буй томоохон бэрхшээл, боломжуудын нэг гэж Засгийн газар үзэж байна.



Хот хоёр хэсэгт хуваагдсан:

- 1. Харьцангуй хүртээмжтэй дэд бүтэц, үйлчилгээ бүхий хөгжсөн хотын төв*
- 2. Гэр хороолол нь цэвэр усны болон бохирын системгүй. Хүртээмж хязгаарлагдмал.*

Эх сурвалж: Google Streetview

⁴⁰ Bayartsetseg Terbish and Margot Rawsthorne, ‘Social Exclusion in Ulaanbaatar City Mongolia’, *Asia Pacific Journal of Social Work and Development* 26, no. 2–3 (2 July 2016): 88–101, <https://doi.org/10.1080/02185385.2016.1199324>.

⁴¹ Mongolian Statistical Information Service, ‘2015 Population and Housing’, *Census of Mongolia*, 1 January 2016, www.1212.mn.

⁴² Asian Development Bank, ‘Living with Disability In Mongolia’.

⁴³ Alexander C. Diener and Joshua Hagen, ‘City of Felt and Concrete: Negotiating Cultural Hybridity in Mongolia’s Capital of Ulaanbaatar’, *Nationalities Papers* 41, no. 4 (July 2013): 622–50, <https://doi.org/10.1080/00905992.2012.743513>.



Улаанбаатар хотын хамруулсан өсөлт, хөгжил нь өнөөгийн хот байгуулалтын сорилтуудад хамгийн их өртөж болзошгүй хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хамруулах ёстой. Монгол Улс 2009 онд НҮБ-ын ХБХЭК-ыг соёрхон баталснаас хойш хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг эдлүүлэх, хамруулах байдал улам бүр сайжирч байгаа бөгөөд 2016 онд Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль баталсан. Хууль эрхзүйн орчин сайжирч байгаа боловч таатай орчныг бүрдүүлж, орон зайн, нийгэм, эдийн засгийн хамрах хүрээний саад бэрхшээлийг арилгахад хийх зүйл их байна.

Энэхүү кейс судалгаа нь орон нутгийн оролцогч талууд болон хамт олны оролцоотойгоор Улаанбаатар хотын барилга байгууламжийн орчин, дэд бүтцийн хүртээмжийн өнөөгийн байдлын зургийг гаргаж, хамруулахад тулгарч байгаа зарим саад бэрхшээлийг арилгахын тулд хамруулсан буюу хамруулсан загварын талаарх ойлголт өгнө. Кейс судалгаанд эхлээд Улаанбаатар хотын барилга байгууламжийн орчинд нэвтрэх, хамрагдахад нөлөөлөх хүчин зүйлүүд болон судалгааны үндэслэлийг тайлбарлах болно. Дараа нь Улаанбаатар хотыг хамруулах талаарх ойлголт, сургамж, үйл ажиллагааны талаар ярилцахаас өмнө хийсэн үйл ажиллагааны талаар тайлбарлах болно.

Үндэслэл ба холбогдох хүчин зүйлс

Монголын хүн ам өсөн нэмэгдэж байгаа ба 2030 он гэхэд 4 сая хүрэх хандлагатай байна. Мөн өмнө хэлсэнчлэн Улаанбаатар хотдоо төвлөрсөн хотжилт улам бүр ихсэж байна. Доорх статистик тоо баримтаас харахад хүн ам зүй, хөгжлийн бэрхшээлийн тархалт зэргийг харуулав. Статистик мэдээллээс харахад хөгжлийн бэрхшээлийн түвшин эрэгтэйчүүд, хөдөөгийн хүн амын дунд арай өндөр байна.

Монгол улсын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн статистик тоо баримт			
Монгол улсын нийт хүн ам	3238479 ⁴⁴		
Улаанбаатар хотын хүн ам	1345500 ⁴⁵		
Монгол улсын хөгжлийн бэрхшээлтэй хүн ам	105691 ⁴⁶	59700 эрэгтэй	46000 эмэгтэй
Улаанбаатар хотын хөгжлийн бэрхшээлтэй хүн ам	35600 ⁴⁷	19700 эрэгтэй	15900 эмэгтэй

Монгол улсын хөгжлийн бэрхшээл ба хүртээмж

1990-ээд оны дунд үеэс Монгол Улс хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хамруулах чиглэлээр ахиц дэвшил гаргаж, 1995 онд Монгол Улсын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн хамгааллын тухай анхны хуулийг баталж байжээ⁴⁸. Монгол Улс 2009 онд НҮБ-ын ХБХЭК-ыг соёрхон баталж, түүнээс хойш хөгжлийн бэрхшээл, хүртээмжтэй байдлын бодлогод ахиц гарсан. Хамгийн гол нь 2016 онд Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль батлагдсан. Гэсэн хэдий ч ХБИБ-уудын зүгээс хуульд заасан бэлтгэл ажил, үйлчилгээ хангалттай байгаа ч хэрэгжүүлэхэд хангалттай төсөв байхгүй гэж үзэв⁴⁹. 2017 онд Монгол Улс Хөгжлийн бэрхшээлийн тухай анхны цагаан номыг хэвлүүлсэн ба 2019⁵⁰ онд хэвлүүлж, 2020 онд хэвлүүлэхээр бэлтгээд байна. Энэхүү цагаан ном нь Монгол Улсын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бодлогыг нэг баримт бичгээр нэгтгэж, хяналт, хариуцлагын явцыг бий болгоход чухал ач холбогдолтой юм. Эдгээр баримт бичиг нь хөгжлийн бэрхшээлийг

⁴⁴ 'National Statistics Office of Mongolia', 2020, <https://www.en.nso.mn/>.

⁴⁵ Mongolian Statistical Information Service, '2015 Population and Housing'.

⁴⁶ Government of Mongolia and JICA, 'White Paper on Disability in Mongolia 2019' (Government of Mongolia: Ministry of Labour and Social Protection, 2019).

⁴⁷ Government of Mongolia and JICA.

⁴⁸ Government of Mongolia and JICA.

⁴⁹ Federation of Independent Living Organizations of Mongolia (MIL) and Tegsh Niigem, 'Submission from Disabled People's Organizations of Mongolia to Inform the Development of the List of Issues Prior to Reporting for a 2nd Periodic Review of Mongolia under the Convention on the Rights of the Persons with Disabilities', 29 July 2018.

⁵⁰ Government of Mongolia and JICA, 'White Paper on Disability in Mongolia 2019'.



хамарсан дадлыг нэвтрүүлэх, ахиц дэвшлийг хуваалцахад туслах "мэдлэгийн дэд бүтэц" болж ажилладаг .

байна. Энэхүү цагаан ном нь Монгол Улсын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бодлогыг нэг баримт бичгээр нэгтгэж, хяналт, хариуцлагын явцыг бий болгоход чухал ач холбогдолтой юм. Эдгээр баримт бичиг нь хөгжлийн бэрхшээлийг хамарсан дадлыг нэвтрүүлэх, ахиц дэвшлийг хуваалцахад туслах "мэдлэгийн дэд бүтэц" болж ажилладаг⁵¹.

10 жил тутамд хийдэг хүн амын тооллогоор хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх мэдээллийг 2010 онд анх удаа цуглуулсан⁵². Хөгжлийн бэрхшээлийн талаарх мэдээлэл нь баттай биш бөгөөд нийт хүн амын дөнгөж 4-өөс доош хувь нь хөгжлийн бэрхшээлтэй гэж бүртгэгдсэн байгааг Азийн хөгжлийн банкны судалгаагаар статистикийг үнэн зөв гэж үзэхгүй байгаа бөгөөд ДЭМБ-ын хөгжлийн бэрхшээлийн тархалттай тохирохгүй байна^{53 54}. Энэ нь Монгол улсад хөгжлийн бэрхшээлийг хэрхэн ойлгодог, эмнэлгийн эсвэл уламжлалт загвар нь хэвээр байгаа, хөгжлийн бэрхшээлтэй иргэнээр бүртгүүлэх үйл явцтай холбоотой байж болох юм. Хөгжлийн бэрхшээлийг зарим пост-социалист улсуудад хамруулсан тохиолддогтой адил "хөдөлмөрийн чадвараа алдах" гэж тодорхойлдог бөгөөд үүнээс болж хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо өндөр настнуудын дунд буурч харагдаж, нийцэхгүй байна⁵⁵.

Бүртгэгдсэн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 29% нь хөдөлгөөний бэрхшээл, 19% нь оюуны хомсдол, сэтгэцийн эрүүл мэндийн байдал, 15% нь харааны бэрхшээл, 12% сонсголын бэрхшээл, 6% нь ярианы бэрхшээлтэй⁵⁶ байна. Олдмол хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нийт хөгжлийн бэрхшээлтэй хүн амын 56% -ийг эзэлж байгаа бөгөөд осол гэмтэл, эрүүл мэндийн асуудлаас болж хөгжлийн бэрхшээлтэй болох түвшин өндөр байна⁵⁷. Хөдөлмөр эрхэлж буй хүн амын дунд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажилгүйдлийн түвшин хоёр дахин их, эрүүл мэндийн зардал өндөр, хөгжлийн бэрхшээлтэй нэг ба түүнээс дээш хүнтэй өрхийн ядуурлын түвшин хоёр дахин их байна⁵⁸. Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлт хамаагүй доогуур байгаа талаар ХБИБ-ууд санаа зовж

⁵¹ Masateru Higashida, 'Consolidating Information on Disability-Inclusive Policies: A Case Study on White Papers in Mongolia from the Perspective of International Technical Cooperation', *Asia Pacific Journal of Social Work and Development* 30, no. 2 (2 April 2020): 122–30, <https://doi.org/10.1080/02185385.2020.1713208>.

⁵² Gerelmaa Amgaabazar and Kate Lapham, 'Disability Is No Longer Invisible in Mongolia', Open Society Foundations, 12 June 2014, <https://www.opensocietyfoundations.org/voices/disability-no-longer-invisible-mongolia>.

⁵³ Asian Development Bank, 'Living with Disability In Mongolia'.

⁵⁴ Khan et al., 'World Health Organization Global Disability Action Plan'.

⁵⁵ Asian Development Bank, 'Living with Disability In Mongolia'.

⁵⁶ Khan et al., 'World Health Organization Global Disability Action Plan'.

⁵⁷ Government of Mongolia and JICA, 'White Paper on Disability in Mongolia 2019'.

⁵⁸ Asian Development Bank, 'Living with Disability In Mongolia'.

байгаа бөгөөд "Тэгш Нийгэм" холбооноос явуулсан судалгаагаар хөгжлийн бэрхшээлтэй болон ажил эрхэлж буй хүмүүсийн ажилгүйдлийн түвшин 44 хувь, 34% нь хувиараа хөдөлмөр эрхлэгчид, 27% нь төрийн байгууллагуудад, 15% нь ТББ-уудад, 18% нь ТББ-уудад сайн дураараа ажил хийдэг байна⁵⁹.

Хүртээмжийг 2016 оны Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулиар 'саадгүй орчинд нэвтрэх' замаар суулгасан болно. Хот байгуулалтын тухай хууль, Барилгын тухай хуулийг 2016 онд шинэчлэн боловсруулж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан заалтыг өргөжүүлсэн. Гэхдээ эдгээр заалтыг хэрэгжүүлэх механизм нь тодорхойгүй байна. Хуулиудыг илүү системтэйгээр хэрэгжүүлэх шаардлагатай байгаа бөгөөд 'хуулийг хэрэгжүүлэх ёстой' гэж ерөнхийдөө мэдээлдэг⁶⁰.

Хүртээмжийн стандартууд анх 2009 онд боловсруулагдсан бөгөөд одоо шинэчлэгдэж байна. Гэсэн хэдий ч эдгээр нь заавал мөрдөх албагүй байна. Улс доторх хүртээмжтэй байдлын талаарх судалгаа хязгаарлагдмал бөгөөд өргөн хүрээнд хийгдсэн хүртээмжийн үнэлгээ байдаггүй⁶¹. ХБИБ-ууд нь хүртээмжтэй байдлыг сурталчлах зорилгоор үнэлгээ, аудитын ажлыг идэвхтэй явуулдаг бөгөөд 2014, 2015 онд явуулсан төрийн үйлчилгээнд хийсэн аудитын дүнгээс үзэхэд судалгаанд хамрагдсан байгууламжийн гуравны нэгээс бага хувь нь хүртээмжтэй байна⁶².

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн мэдээлснээр орчны саад бэрхшээлүүд нь:

- Дэд бүтцийн хүртээмжгүй байдал
- Хүртээмжгүй нийтийн тээвэр
- Сөрөг хандлага
- Хууль дах хөгжлийн бэрхшээлийн буруу ангилал
- Туслах технологийн хүрэлцээгүй байдал зэрэг хамрагдаж байна⁶³.

Амьдрах орчны саад бэрхшээлүүдэд өвлийн улирлын цаг уурын хүндрэл, лифтгүй өндөр барилгууд (өндөр гадаах шат), халаалтын ба бохир зайлуулах дэд бүтэц болон гэр хорооллын гадаах жорлон багтаж байна⁶⁴.

⁵⁹ Federation of Independent Living Organizations of Mongolia (MIL) and Tegsh Niigem, 'Submission from Disabled People's Organizations of Mongolia to Inform the Development of the List of Issues Prior to Reporting for a 2nd Periodic Review of Mongolia under the Convention on the Rights of the Persons with Disabilities', 29 July 2018.

⁶⁰ Asian Development Bank, 'Living with Disability In Mongolia'.

⁶¹ Sunil Deepak, 'Barriers Faced by Young Adults with Disabilities in Ulaanbaatar, Mongolia: Report of a Community-Based Emancipatory Disability Research (CB-EDR)' (Ulaanbaatar, Mongolia: Tegsh Niigem, n.d.).

⁶² Asian Development Bank, 'Living with Disability In Mongolia'.

⁶³ Delgerjargal Dorjbal et al., 'Living with Spinal Cord Injury in Mongolia: A Qualitative Study on Perceived Environmental Barriers', *The Journal of Spinal Cord Medicine* 43, no. 4 (3 July 2020): 518–31, <https://doi.org/10.1080/10790268.2019.1565707>.

⁶⁴ Danielle Morante, 'Occupational Therapy Emerging in Mongolia: A Case Study', *World Federation of Occupational Therapists Bulletin* 73, no. 2 (3 July 2017): 88–93, <https://doi.org/10.1080/14473828.2017.1281870>.

Монголын Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагууд (ХБИБ) нь маш идэвхтэй. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам (ХНХЯ)-наас мэдээлснээр идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа 43 ХБИБ байна⁶⁵. 2018 онд ХБИБ-уудын бичсэн НҮБ-ын ХБХЭК-ын хоёр дах Сүүдэр илтгэлд Монголын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудлыг тоймлон хүргэсэн. Сүүдэр илтгэлд олон нийтийн ойлголтыг сайжруулах хэрэгцээ байгааг дурдаад ХБИБ-ууд хөгжлийн бэрхшээлийн талаар ойлголт нэмэгдүүлэх сургалт зохион байгуулахыг санал болгосон. Хүртээмжтэй байдал нийтийн барилга байгууламжид асуудал хэвээр байгааг илтгэлд дурдаад тодорхой барилга байгууламжид ерөнхий дүрэм, стандартуудыг мөрдөхгүй байгаа, зураг төслийн явцад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй зөвлөлддөггүй нь хүртээмжийн талаарх асуудлыг ургуулж байдаг. Хуулийн дагуу хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх механизм дутмаг нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хэрхэн зөрчиж байгааг илтгэж, ялгаварлан гадуурхалтын эсрэг хууль тэгш оролцоог дэмжих шаардлагатайг дурдсан байна. ‘Түгээмэл Хөгжил’ бие даан амьдрах төв (БДАТ) нь 2015-2018 оны хооронд хүртээмжийн үнэлгээг хэд хэдэн удаа явуулсан ч эдгээр үнэлгээний үр дүнд өөрчлөлт шинэчлэлт хийгдээгүй байгааг тогтоожээ. Нийтийн эзэмшлийн байгууламжууд ихэвчлэн олон улсын агентлагийн санхүүжилтээр тохижуулалт хийдэг ба өөрсдийн хөрөнгөөр хүртээмжийг сайжруулах төсөвгүй гэж мэдэгдэж байна. Энэ нь норм норматив, стандартын талаар илүү сайн мэдлэгтэй байх шаардлагатай, мөн ажлын байран дээр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс дутагдалтай учир ажилтнууд шаардахгүй, сайжрал бий болохгүй байгаа талаар тайлбарласан байна⁶⁶.

ХБИБ-уудын анхаарал татсан өөр нэг асуудал бол бие даан амьдрах болон хамт олонд түшиглэсэн сэргээн засах хандлагын талаар ойлголтгүй явдал юм. Бие даан амьдрах тогтолцоог дэмжихийн тулд хөгжлийн бэрхшээлийн талаарх уламжлалт буюу эмнэлгийн загварын хандлагыг өөрчлөх ёстой гэж ХБИБ-ууд үзэж байгаа юм. Одоогийн ойлголт нь нийгмийн халамжийн төсвийн ихэнх хэсгийг асрамжийн газар, нөхөн сэргээх байгууллагуудад хуваарилдаг гэсэн үг юм. Үүний нэг жишээ бол хувийн туслах ажилчдын цалин нь улсын дундаж хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний хагасаас бага байна; бие даан амьдрах, тэгш оролцоог хангахад хувийн туслахуудын дэмжлэг зайлшгүй шаардлагатай. Өөр нэг хөндөгдсөн асуудал нь засгийн газрын аль ч хэлтэс бие даан амьдрах тогтолцоог санхүүжүүлснээр нийгэмд ирэх давуу талууд, ашиг тусын талаар тодорхой ойлголтгүй байна.

⁶⁵ Government of Mongolia and JICA, ‘White Paper on Disability in Mongolia 2019’.

⁶⁶ Federation of Independent Living Organizations of Mongolia (MIL) and Tegsh Niigem, ‘Submission from Disabled People’s Organizations of Mongolia to Inform the Development of the List of Issues Prior to Reporting for a 2nd Periodic Review of Mongolia under the Convention on the Rights of the Persons with Disabilities’, 29 July 2018.



ХБИБ-уудын илтгэлд үндэслэж НҮБ-ын Хүний эрхийн хороо дараах зөвлөмжийг өгсөн ба үүнд: нийтийн эзэмшлийн байгууламж, тээврийн хэрэгслийг хүртээмжтэй болгох жилийн төлөвлөгөө боловсруулах, барилга барих зөвшөөрөл өгөх явцад одоо мөрдөгдөх стандартын талаар мэдээлэл өгөх. Мөн өөр стандартуудыг төлөвлөж байгаа эсэх, хүртээмжтэй тээврийн хэрэгслийн төлөвлөгөөний өнөөгийн байдал, түүнийг сайжруулах шинэчлэх төлөвлөгөө байгаа эсэх талаар асуусан. Жишээлбэл, хэзээ бүх автобус тэргэнцэртэй хүнд хүртээмжтэй болох вэ? Нийтийн тээврийн хэрэгсэл хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй болгох тухай тодорхой хугацааг баталгаажуулах санал болгох үйл ажиллагаануудыг мэдэж авах юм⁶⁷.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тулгарч буй саад бэрхшээлийн талаар Монгол Улсад саяхан хийгдсэн Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг эрх мэдэлжүүлэх судалгааны төсөл⁶⁸ нь 12 сэдвээр дээрх саад бэрхшээлийг тодорхойлсон. Үүнд:

1. Гэр хороололд амьдарч буй хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тулгарч буй асуудлууд
2. Нийтийн тээврийн хүртээмжийн асуудлууд
3. Нийгмийн хамгааллын үйлчилгээ
4. Бие даан амьдрахад тулгарч буй асуудлууд
5. ХБИ-ийн бэлгийн боловсрол
6. ХБИ-ийн ажил хөдөлмөр эрхлэлт
7. ХБИ-ийн боловсрол эзэмшилт
8. Ялгаварлан гадуурхалтгүй байдал
9. Хувийн туслах ба дэмжлэг
10. ХБИ-ийг эрх мэдэлжүүлэх
11. Эрүүл мэндийн үйлчилгээ
12. Туслах технологи

Биет орчны дэд бүтцийн саад, хүрээлэн буй орчны саад бэрхшээлүүд нь нийтийн болон хувийн амьдралаас гарах ялгаварлан гадуурхалтыг тойрсон асуудал, боломжуудад хүргэх саад бэрхшээлүүдтэй огтлолцдог. Саад бэрхшээл нь хувийн болон бусад нөхцөл байдлын хүчин зүйлээс хамааран өөр өөр байдаг ч түүнийг арилгах нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст илүү их ашиг тус авчирдаг⁶⁹.

Судалгааны үр дүнгээс үзэхэд Монголын хөгжлийн бэрхшээлийн талаарх ихэнх судалгаа

⁶⁷ Federation of Independent Living Organizations of Mongolia (MIL) and Tegsh Niigem.

⁶⁸ Deepak, 'Barriers Faced by Young Adults with Disabilities in Ulaanbaatar, Mongolia: Report of a Community-Based Emancipatory Disability Research (CB-EDR)'.

⁶⁹ Deepak.



нь эрүүл мэндийн сэргээн засалтад чиглэгддэг бөгөөд энэ нь хүрээлэн буй орчны саад бэрхшээлийн талаарх мэдээлэл хязгаарлагдмал байгааг харуулж байна. Судалгаанаас үзэхэд биет орчны болон хуулийн орчны хүртээмжгүй нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрх мэдэлжээгүйтэй холбоотой. Түүнчлэн зөвхөн асуудалд анхаарлаа төвлөрүүлэлгүйгээр, шийдлийг чухалчилж, эерэг өөрчлөлтийг дэмжих зорилгоор судалгаа шинжилгээг ашиглах нь чухал болохыг тодорхойлсон. Гэсэн хэдий ч саад бэрхшээлийн талаарх бүрэн гүйцэт ойлгох нь үйлчилгээ үзүүлэгчдийн хувьд замыг нь зааж, нөлөөллийн ажлын тэргүүлэх чиглэлийг шийдэх боломж олгодог⁷⁰.

Улаанбаатар хотын хөгжлийн түүх ба соёл

Монгол улс нь нүүдэлчин уламжлалаас эхтэй маш баялаг, өргөн түүх соёлтой⁷¹. Судалгаанаас харахад хот байгуулалт, нягтралыг сайжруулах төлөвлөгөө нь хүмүүсийн амьдралын хэв маягтай⁷² зөрчилдөж байна, мөн нээлттэй орон зайтай байна гэдэг нь Монгол хүмүүсийн хувьд соёлын чухал хэсэг юм. Улаанбаатар хот нь 1639 онд Буддын шашны нүүдлийн 'гэрт суурилсан' хийдээр үүссэн⁷³. Энэхүү түүхэн 'Өргөө' хот (Улаанбаатар хотыг урьд нь ингэж нэрлэдэг байжээ) нь ус, бэлчээрийн талбайн хүрэлцээ, дайсагнасан хүчнүүд зэргээс шалтгаалан нүүдэллэж иржээ. Хот нь одоогийн байршилдаа 1778 онд суурьшсан бөгөөд ус, худалдааны замд ойр учир суурин амьдрах хөшүүрэг нь болжээ. Түүхийнхээ туршид улс, хот хоёулаа Орос, Хятадын хоорондын геополитикийн нөлөөнд автсаар ирсэн. 1921 онд хувьсгалын дараа тус улс Бүгд Найрамдах Монгол Ард Улс нэртэй болж, тусгаар тогтносон боловч Зөвлөлт Холбоот Улсын нөлөө их хэвээр байв. Үүний дараа гарсан өөрчлөлтүүдийн нэг нь хотыг 1924 онд "Улаанбаатар" болгон өөрчилсөн явдал байв. 1990 онд зах зээлийн эдийн засагт шилжсэнээс хойших хэдэн жилийн хугацаанд уг хот өөрчлөгдсөн. Тухайлбал, нүүдэлчин болон суурин амьдралын хэв маяг, социалист уламжлал ба неолиберал буюу зах зээлийн эдийн засагт тулгуурласан хөгжлийн хоорондох хоёр талт нөхцөл, эдгээр хурцадмал байдал нь хотын өнгө төрхөөс илт харагдаж байна⁷⁴.

Нийгмийн болон хамт олны бүтэц нь ихэвчлэн Монголын хамтын амьдралын хэв маягаас үүдэлтэй бөгөөд хэрэв оролцогч талууд энэхүү хамт олны холбоосыг анхааралтай

⁷⁰ Deepak.

⁷¹ Zsolt Szilágyi, 'Lingering Nomad Ideology in 21 st Century Mongolia', Acta Ethnographica Hungarica 61, no. 1 (June 2016): 197–211, <https://doi.org/10.1556/022.2016.61.1.9>.

⁷² Raven Anderson, Michael Hooper, and Aldarsaikhan Tuvshinbat, 'Towers on the Steppe: Compact City Plans and Local Perceptions of Urban Densification in Ulaanbaatar, Mongolia', Journal of Urbanism: International Research on Placemaking and Urban Sustainability 10, no. 2 (3 April 2017): 217–30, <https://doi.org/10.1080/17549175.2016.1223739>.

⁷³ Aubrey Menard, Young Mongols: Forging Democracy in the Wild, Wild East (Penguin Random House SEA, 2020).

⁷⁴ Diener and Hagen, 'City of Felt and Concrete'.



ажиглаж чадвал хамт олны хөгжлийн боломжийг харж болно⁷⁵. Иргэний нийгэм, ТББ-ууд Монголд маш идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг боловч хотод шинээр ирсэн оршин суугчид хамрагдах магадлал багатай тул хөдөө орон нутгаас хот руу шилжин суурьшигчдын тусгаарлагдах байдал нь ихсэж болзошгүй юм. Хот суурин газрын хурдацтай хотжилт нь гэр бүл, хамт олны бүтцийг өөрчилж, хотын амьдралд дасан зохицох уламжлалт хамтын харилцаа тасрахад хүргэж байгааг судалгаа харуулж байна^{76 77}. Гэр хорооллын оршин суугчид нийгмийн амьдралд оролцоход дараах саад бэрхшээлүүдийг мэдрэх боломжтой, үүнд: биет орчны дэд бүтэц муу, төрийн үйлчилгээний хүртээмж хангалтгүй, иргэний нийгмийн үйл ажиллагаанаас хол, хязгаарлагдмал, нийгмийн сүлжээ дутмаг гэх мэт⁷⁸. Барилга байгууламжийг нийгмийн болон соёлын хувьд хамруулсан, боломжийн байдлаар загварчлахын тулд хамтаараа амьдардаг, нүүдэлчин амьдралын хэв маягтай холбоотой түүх, соёлын уламжлалыг хот төлөвлөлт, бүтээн байгуулалтад анхаарч үзэх хэрэгтэй. Монголчуудын нүүдэлчин амьдрал нь байгаль болон газартайгаа илүү тогтвортой харилцаатай нь⁷⁹ цаг уур, хотын өөрчлөлтөд дасан зохицсон, хамруулсан тогтвортой хөгжлийн үнэтэй ойлголтыг санал болгож болох юм.

Хотын хөгжил ба амьдрах орчин

Улаанбаатар хот Богдхан уулын бэл дэх Туул голын хөндийд байрладаг. Нийслэл хот болохын хувьд 2013 оны байдлаар Монголын ДНБ-ий гуравны хоёр нь хотод үйлдвэрлэгдсэн ба нийслэл нь улс төрийн болон эдийн засгийн хувьд чухал ач холбогдолтой юм⁸⁰. Хотын түүхэнд дурдсанчлан Улаанбаатарт хот байгуулалтын нөхцөл байдал хурдацтай өөрчлөгдөж байна. Энэ хотыг хагас сая хүн амд зориулан бүтээсэн ч үүнээс гурав дахин олон иргэд оршин суудаг болсон нь зарим эх сурвалжуудын мэдээлснээр хотын хүн амын тоо 1.4-1.7 сая орчим байна. Тус улсын хүн амын талаас илүү хувь нь нийт газар нутгийнхаа 0.2% -д амьдарч байна⁸¹. Хотын хөгжүүлэлтэд тулгарч буй гурван үндсэн асуудал бол хөдөөнөөс хот руу шилжих хөдөлгөөн, дэд бүтцийн дутагдал, мөн газар ашиглалтын

⁷⁵ Terbish and Rawsthorne, 'Social Exclusion in Ulaanbaatar City Mongolia'.

⁷⁶ Ilana Stol and Enkhjargal Adiya, 'Intergenerational Relationships in Mongolia: Togetherness as a Family Unit', *Journal of Intergenerational Relationships* 8, no. 1 (4 March 2010): 83–89, <https://doi.org/10.1080/15350770903520783>.

⁷⁷ Caroline Upton, 'Social Capital, Collective Action and Group Formation: Developmental Trajectories in Post-Socialist Mongolia', *Human Ecology* 36, no. 2 (April 2008): 175–88, <https://doi.org/10.1007/s10745-007-9158-x>.

⁷⁸ Terbish and Rawsthorne, 'Social Exclusion in Ulaanbaatar City Mongolia'.

⁷⁹ Hirofumi Sugimoto et al., 'Living Environment of Nomads Residing on the Outskirts of Ulaanbaatar, Mongolia – Dispositional Characteristics from the Perspective of a Comparison of Nomads and People Living in Ger Fixed Residences in the City –', *Journal of Asian Architecture and Building Engineering* 6, no. 2 (November 2007): 283–90, <https://doi.org/10.3130/jaabe.6.283>.


⁸⁰ Peilei Fan, Jiquan Chen, and Ranjeet John, 'Urbanization and Environmental Change during the Economic Transition on the Mongolian Plateau: Hohhot and Ulaanbaatar', *Environmental Research* 144 (January 2016): 96–112, <https://doi.org/10.1016/j.envres.2015.09.020>.

⁸¹ Menard, *Young Mongols*.



тухай чанга хатуу хууль, эрх зүйн орчин дутмаг явдал юм⁸². Энэ гурван хүчин зүйлээс үүдэн орчны доройтол, орон байрны зохисгүй нийлүүлэлт, газрын буруу ашиглалт, замын түгжрэл, санхүүжилтийн дутмаг байдал, институтийн чадавх сул, зохисгүй хотын хэт төвлөрөл зэрэг хүндрэлүүд улам нэмэгдэг байна⁸³.

Хөдөө орон нутгаас хот руу чиглэсэн шилжих хөдөлгөөн их байгаа нь цаг агаарын эрс тэс үзэгдлүүд хөдөөгийн малчдын амьжиргаанд нөлөөлөхөөс гадна хотод ажил эрхлэх, боловсрол эзэмших илүү боломжтой холбоотой байна⁸⁴. Энэхүү хурдацтай хотжилтын үр дүн нь хотын хүн амын 60-70%-ийг эзэлдэг төлөвлөгөөгүй томоохон суурин газрууд болох Гэр хорооллын тэлэлт юм.



Улаанбаатар: Гэр хорооллын ерөнхий зураглалыг Google Earth (Улаанбаатар хотын мастер төлөвлөгөө, 2019)

Гэр хорооллын хувьд суурь дэд бүтэц дутагдалтай тул ус түгээх цэгээс усаа зөөдөг, зууханд гал түлэн халаалтаа шийддэг. Гэр хорооллын оршин суугчдын тал орчим хувь нь гэрт, хагас нь байшинд амьдардаг⁸⁵ бөгөөд байшингийн зөвхөн 42% нь дотроо бие засах

⁸² Government of Mongolia and Asia Foundation, ‘Ulaanbaatar Master Plan 2020 and Development Approaches for 2030: Technical Summary’, 2014, <https://asiafoundation.org/publication/ulaanbaatar-city-master-plan-technical-summary/>.

⁸³ Government of Mongolia and Asia Foundation.

⁸⁴ Fan, Chen, and John, ‘Urbanization and Environmental Change during the Economic Transition on the Mongolian Plateau’.

⁸⁵ Takuya Kamata et al., *Managing Urban Expansion in Mongolia: Best Practices in Scenario-Based Urban Planning* (The World Bank, 2010), <https://doi.org/10.1596/978-0-8213-8314-8>

өрөөтэй гэжээ⁸⁶. Гэр хорооллын оршин суугчид үйлдвэрлэлийн болон барилгын салбар гэх мэт биеийн хөдөлмөр эрхлэх нь элбэг (энэ хоёр салбарын ажиллах хүчний 15% нь гэр хороололд байна)⁸⁷. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хувьд эдгээр салбарт хөдөлмөр эрхлэх боломж хязгаарлагдмал нь гэр хорооллын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэх боломж нь илүү хэцүү байж болохыг харуулж байна.

Зам тээврийн дэд бүтэц гэр хороололд тааруухан⁸⁸, нийтийн тээврийн хэрэгслийн сүлжээ нэвтрэх боломж хязгаарлагдмал, авто зам шороон тул хөдөлгөөний аюулгүй байдал муу, тоос шороо, гуу жалга зэрэг нь аюулгүй байдалд саад учруулдаг. Гудамжны гэрэлтүүлэг хангалтгүй байгаа нь эрсдэл дагуулж, Гэр хорооллын гэмт хэргийн гаралт өндөр байгаагийн хүчин зүйл гэж үзэж байна⁸⁹. Судалгаанаас харахад Гэр хороололд амьдардаг нийт судалгаанд хамрагдагсдын 67.6% нь шөнийн цагаар гудамжаар алхахад аюулгүй гэж боддоггүй бөгөөд эмэгтэйчүүд хамгийн ихээр айдгаа илэрхийлдэг байна⁹⁰. Улаанбаатар хотын тээврийн болон нийгмийн тэгш байдлын талаарх өөр нэг судалгаагаар эмэгтэйчүүд нийтийн тээврийн хэрэгслийг илүү их ашигладаг бөгөөд аюулгүй байдал, хүүхэд асрах үүргийн улмаас үйлчилгээг илүү их ашигладаг. Тиймээс бэрхшээл мөн илүү тулгардаг болохыг тогтоожээ. Судалгааны үеэр золбин ноход явган зорчигчдод тулгамдсан асуудал болж байгааг нэмж хэллээ⁹¹. Энэхүү судалгаагаар гэр хороололд амьдардаг иргэд нийтийн тээврийн системд учир дутагдал байгаа тул таксинд сууж автобусны буудал хүрэх гэх мэт нэгээс олон төрлийн тээврийн хэрэгсэлд найдах шаардлагатай болдог⁹².

Хот төлөвлөлтөд гэр хорооллыг хамруулахад хотод гурван бэрхшээл тулгарч байна. Хот байгуулалтын төвийн шийдвэрлэх асуудлын нэн тэргүүнд гэр хорооллын хүртээмжтэй дэд бүтэц, үйлчилгээ буюу зам, халаалтын систем, хатуу хог хаягдлын менежмент, боломжийн үнэтэй орон байрны хангамж зэрэг багтана⁹³. Жишээлбэл, Улаанбаатар хотыг төвлөрсөн халаалтын системээр халаадаг ч гэр хороолд уг төвлөрсөн систем хүрдэггүй, хотын 60% нь халаалтын системгүй амьдарч байна. Гэр хорооллын айлын жилийн халаалтын өртөг нь (200-500\$) нь төвлөрсөн халаалтын системээр дулаанаа шийддэг айлын жилийн зардлаас (72\$)⁹⁴ харьцангуй их байгаа нь тэгш байдлыг улам бүр дордуулж, ядуурлыг нэмэгдүүлэхэд нөлөөлж байна.

⁸⁶ Mongolian National Statistics Office, 'Main Findings of the 2010 Population and Housing Census', 2010, en.ubseg.gov.mn/content/49.

⁸⁷ Kamata et al., *Managing Urban Expansion in Mongolia*.

⁸⁸ Iqbal Hamiduddin et al., 'The UNAA Project: Ulaanbaatar Accessibility Appraisal', n.d., <https://www.unaa-project.org/>.

⁸⁹ Kamata et al., *Managing Urban Expansion in Mongolia*.

⁹⁰ Terbish and Rawsthorne, 'Social Exclusion in Ulaanbaatar City Mongolia'.

⁹¹ Iqbal Hamiduddin, 'Travel and Social Equity in Ulaanbaatar's Ger Districts: The Case of Khoroo 31', www.unaa-project.org.

⁹² Hamiduddin.

⁹³ Kamata et al., *Managing Urban Expansion in Mongolia*.

⁹⁴ Yun Wu et al., 'Paving the Way to a Sustainable Heating Sector A Roadmap for Ulaanbaatar Urban Heating', Energy Sector Management Assistance Program (ESMAP) (The World Bank, 2019)



Улаанбаатар хотыг хөгжүүлэх тэргүүлэх төлөвлөгөө нь хотын нягтаршлыг багасгахад чиглэсэн ч орлого багатай бүлгийн хэсэгт хот сийрэгжих нь тэдний хүртэх ач тус, нийгмийн нөлөөний талаар сайн бодолцох хэрэгтэй⁹⁵. Судалгаанаас харахад гэр хорооллын оршин суугчид ихэвчлэн өндөр байшин-орон сууц гэхээсээ багавтар давхартай орон сууцанд амьдрахыг илүүд үздэг болохыг нотолж байна⁹⁶. Өөр нэг судалгаагаар гэр хорооллын оршин суугчдын 70% нь гэрээсээ шууд гарч ногоон байгууламж руу шилжих боломжтой байхын ач холбогдол, нүүдэлчин хэв маягийн эрх чөлөө, уян хатан байдлыг иш татсан⁹⁷. Гэсэн хэдий ч Азийн хөгжлийн банкаар удирдуулсан гэр хорооллын дэд бүтцийн зарим асуудлыг шийдвэрлэх хямд өртөгтэй орон сууцны төлөвлөгөө хийгдэж байгаа бөгөөд 2016 онд хийсэн судалгаагаар төлөвлөсөн орон сууц нь хүлээн авах боломжтой, хямд үнэтэй бол оршин суугчдын 60% нь нүүх хүсэлтэй байгаа нь харагдаж байна⁹⁸. Эдгээр төслүүд нь гэр хорооллын амьдрах нөхцөлийг сайжруулах өргөн боломжтойг харуулах боловч хүртээмжтэй, хамруулсан байдалд анхаарлаа хандуулах нь шийдлийг тэгш байлгахад чухал үүрэг гүйцэтгэнэ. Өндөр нягтралтай орон сууцны хүртээмжид үзүүлэх нөлөөллийг хөгжлийн төлөвлөгөөнд харгалзан үзэх шаардлагатай.

Хот төлөвлөлт нь Улаанбаатарт харьцангуй шинэлэг зүйл бөгөөд хотын илүү чинээлэг төв болон түүний ойр орчмын гэр хороол гэж бүсчлэн асуудлыг шийдвэрлэх шаардлагатай байгаа юм⁹⁹. Хотын алсын хараа нь нүүдэлчдийн өв соёл, байгаль орчны тогтвортой байдлыг хадгалсан технологийн төв ‘монгол хэв шинжийг агуулсан ухаалаг хот’ болж хөгжихөд чиглэсэн байна. 2030 он хүртэлх ерөнхий төлөвлөгөөнд хот төлөвлөлтийн тэргүүлэх чиглэлийг дараах байдлаар тодорхойлсон болно. Үүнд:

- Тэргүүлэх зорилт 1: Улаанбаатар хот нь уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй, аюулгүй, эрүүл, ногоон хот болно.
- Тэргүүлэх зорилт 2: Улаанбаатар хот нь газар ашиглалтын зохистой төлөвлөлт, дэд бүтэц, орон сууцаар дамжуулан оршин суугчдын амьдрах орчныг хангана.
- Тэргүүлэх зорилт 3: Улаанбаатар хот нь сайн засаглалтай, олон нийтийн болон хувийн хэвшилд үйлчилдэг хууль эрх зүйн орчин хөгжсөн хот байх болно.
- Тэргүүлэх зорилт 4: Улаанбаатар хотын төвөөс гадна суурин, хотхон, дагуул хотуудын цаашдын хөгжлийг хөхиүлэн дэмжих болно.

⁹⁵ Anderson, Hooper, and Tuvshinbat, ‘Towers on the Steppe’.

⁹⁶ Terbish and Rawsthorne, ‘Social Exclusion in Ulaanbaatar City Mongolia’.

⁹⁷ Menard, *Young Mongols*.

⁹⁸ Asian Development Bank, ‘ADB to Help Ulaanbaatar Transform Its Ger Areas into Eco-Districts’, Asian Development Bank, 28 August 2018, <https://www.adb.org/news/adb-help-ulaanbaatar-transform-its-ger-areas-eco-districts>.

⁹⁹ John Larkin and Gantuya Ganzorig, ‘Case Study: Can Better Urban Planning Help Ulaanbaatar Glimpse a Brighter Future?’, Asian Development Bank, 16 August 2018, <https://www.adb.org/results/can-better-urban-planning-help-ulaanbaatar-glimpse-brighter-future>.

- Тэргүүлэх зорилт 5: Улаанбаатар хот Азийн аялал жуулчлалын төвүүдийн нэг болно.
- Тэргүүлэх зорилт 6: Улаанбаатар хот олон улсын хэмжээнд өрсөлдөх чадвартай бизнес төвтэй болж, дэлхийн жишигт нийцсэн нийслэл хот болон хөгжинө¹⁰⁰.

Эдгээр тэргүүлэх чиглэлүүд нь төвлөрлөөс зайлсхийх арга замаар тусгагдсан бөгөөд ингэснээр гэр хорооллыг дэд төвүүдээр дамжуулан хоттой холбоно. Зарим хот төлөвлөгчдийн үзэж байгаагаар авто зам ба тээврийн хэрэгсэл нь хотын иргэдийн зорчиход чиглэн хөгжиж байна гэж үзэх боловч судалгаанаас харахад автобусаар болон явганаар хотоор зорчигчдын эзлэх хувь нь 33.7% ба 31% хувийг эзлэх ба авто машинаар зорчигчид нь нийт хотын хөдөлгөөнд оролцогсдын 23.4% -ийг эзэлдэг гэсэн байна¹⁰¹. Үүнээс харахад хотын хөдөлгөөний хоёр дах гол зорчигч болох явган хүнээ чухалчлахгүй байна. Монгол Улсын Засгийн газар 2000-2007 онд амь насаа алдсан хүмүүсийн 80 хувь нь явган зорчигч байсан гэж мэдээлснээс харахад Улаанбаатарт алхах нь тийм ч аюулгүй гэж үзэхгүй байна¹⁰². Мөн хүмүүс дээрээс (барилгын эд зүйлс) юм унах ба доошоо (нүх, гуу жалганд) унах зэрэг бүх чиглэлээс ирж буй гэмтэл бэртлийн талаар тайлбарлав¹⁰³.

Улаанбаатар хотын иргэд хот дотор 0.07 га газар өмчлөх эрхтэй¹⁰⁴. Энэ нь гэр хорооллын оршин суугчид орон сууцанд амьдардаг хүмүүсээс илүүтэй газраа өмчлөх боломжтой болсон, мөн газар дээрээ гэр барих өртөг бага байдаг. Гэхдээ газар өмчлөх энэ үйл явцад хүнд суртал тулгардаг тул өмчлөхөөсөө түрүүлэн газартаа хашаагаа барьж төлөвлөлтгүй гэр хороолол тэлдэг байна. Хашаа нь хүмүүсийн газраа өмчилж авснаа илэрхийлэх хэлбэр бөгөөд зарим тохиолдолд илүү том газар авах хэрэгсэл болдог¹⁰⁵. Гэр хорооллын оршин суугчдыг орон сууцжуулах зорилгоор гэр хорооллын дахин төлөвлөлтийн төлөвлөгөөнд оршин суугчдын газар өмчлөх эрх¹⁰⁶, дахин төлөвлөлтийн төлөвлөгөөнд олон нийтийн дэмжлэг, орон сууцны хэв маягийн давуу эрх зэргийг харгалзан үзэх хэрэгтэй.

100 Government of Mongolia and Asia Foundation, 'Ulaanbaatar Master Plan 2020 and Development Approaches for 2030: Technical Summary'.

¹⁰¹ Menard, *Young Mongols*.

¹⁰² Herbert Fabian et al., 'Walkability and Pedestrian Facilities in Asian Cities: State and Issues', ADB Sustainable Development Working Paper Series (Asian Development Bank, 2010), http://www.indiaenvironmentportal.org.in/files/Walkability_Final_Report_15Oct2010.pdf.

¹⁰³ Menard, *Young Mongols*.

¹⁰⁴ Rebekah Plueckhahn and Terbish Bayartsetseg, 'Negotiation, Social Indebtedness, and the Making of Urban Economies in Ulaanbaatar', *Central Asian Survey* 37, no. 3 (3 July 2018): 438–56, <https://doi.org/10.1080/002634937.2018.1442318>.

¹⁰⁵ Plueckhahn and Bayartsetseg.

¹⁰⁶ Amnesty International, 'Falling Short: The Right to Adequate Housing in Ulaanbaatar, Mongolia' (Amnesty International, 2016).



Эрүүл мэнд, байгаль орчин ба цаг уур

Монголд эрүүл мэнд, байгаль орчин, цаг уур гурав нь салшгүй хамааралтай юм. Монгол орны хувьд эрс тэс уур амьсгалтай, агаарын температур нь өвөлдөө -40°C , зундаа $+40^{\circ}\text{C}$ хооронд хүрч хэлбэлздэг. Монголд хөдөө орон нутгаас хот руу чиглэсэн хурдацтай шилжилт хөдөлгөөнийг нэмэгдүүлж, хотыг ядууруулж байгаагийн гол хүчин зүйлүүдийн нэг нь "зуд" гэгддэг өвлийн цаг уурын хүндрэл юм.

Хот суурин газрын хурдацтай өсөлт нь орлогын болон боломжийн хувьд асар их тэгш бус байдлыг бий болгож, эрүүл мэнд, сайн сайхан байдалд нөлөөлж байна. Улаанбаатарт эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэхэд тулгарч буй саад бэрхшээл нь 'ядуурал, өдөр тутмын амьдралын эрүүл бус орчин, нийгмийн эмзэг байдал, тусгаарлалт' ялангуяа хотын ядуу хүмүүст ихээр нөлөөлж байна. Эрүүл мэндийн тогтолцоо нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хэрэгцээг хангахад сайн бэлтгэгдээгүй¹⁰⁷.

Улаанбаатар хотын гэр хороололд өвлийн хүйтэнд ус, дулаан болон ахуйн ариун цэврийн наад захын орчин дутагдсанаас үүдэн хүрээлэн буй орчинд агаар, ус, хөрсний бохирдол үүсэж байна¹⁰⁸. Хотын бохирдлын 80%-ийг гэр хороолол үүсгэдэг¹⁰⁹. Агаарын бохирдол, ус, хөрс, агаар дах химийн хүнд элементийн агууламж, цэвэр ус болон ариун цэврийн наад захын цэвэр орчны дутагдлууд нь иргэдийн эрүүл мэндэд хүрээлэн буй орчноос нөлөөлж буй хамгийн том хүчин зүйл болж байна. Гэр хороололд мөн агаарыг бохирдуулагч гол хүчин зүйл нь нүүрсний дутуу шаталтын хий буюу утаа юм. Түүнээс гадна гэр хороололд зам харгуй сайн хөгжөөгүйн улмаас тоосжилт нь гэрийн дотоод болон гадаад бохирдлыг үүсгэдэг. Гэртээ агааржуулалт хийж, хоол бэлтгэх хэрэгслээ сайжруулж, эрүүл мэндээ сайжруулна¹¹⁰. Ус, эрүүл ахуй, ариун цэвэр нь усны хэрэглээ болон хаягдалд аль алинд нь аюултай нөхцөлд байна¹¹¹. Тухайлбал, гэр хороололд цэвэр, бохир усны нэгдсэн холболтын систем байхгүйн улмаас иргэд хэрэглэсэн усаа шууд гудамжиндаа асгадаг. Энэ нь үер, халтиргаа гулгаа болон бохир орчныг бий болгодог ба хэрвээ цаг агаар хуурайшвал газрын хөрсөнд амархан шингэх боловч энэ нь тэдний эрүүл мэндэд маш хор нөлөөтэй юм¹¹². Ундны ус болон эрүүл ахуйн шаардлага хангасан дэд бүтцийн дутагдалтай байдал нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрүүл, аюулгүй, цэвэр орчинд амьдрахад илүү хүндрэл учруулж байгаа, мөн мод хагалах, ус авах зэрэг өдөр тутмын ажлуудыг хийхэд улам хүндрэлтэй, боломжгүй болгож байна.

¹⁰⁷ Khandsuren Lhamsuren et al., 'Taking Action on the Social Determinants of Health: Improving Health Access for the Urban Poor in Mongolia', *International Journal for Equity in Health* 11, no. 1 (2012): 15, <https://doi.org/10.1186/1475-9276-11-15>.

¹⁰⁸ Amarzaya Jadambaa et al., 'The Impact of the Environment on Health in Mongolia: A Systematic Review', *Asia Pacific Journal of Public Health* 27, no. 1 (January 2015): 45–75, <https://doi.org/10.1177/1010539514545648>.

¹⁰⁹ Aubrey Menard, 'Mongolia's Urban Planning Paradox', *New America Weekly*, 31 August 2020, <https://www.newamerica.org/weekly/mongolias-urban-planning-paradox/>.

¹¹⁰ Yeonghwa So et al., 'Characteristics of Lifestyle and Living Environment of Ger District Residents in Ulaanbaatar, Mongolia', *The Korean Journal of Public Health* 55, no. 2 (31 January 2019): 12–21, <https://doi.org/10.17262/KJPH.2018.12.55.2.12>.

¹¹¹ Sayed Mohammad Nazim Uddin et al., 'Exposure to WASH-Borne Hazards: A Scoping Study on Peri-Urban Ger Areas in Ulaanbaatar, Mongolia', *Habitat International* 44 (October 2014): 403–11, <https://doi.org/10.1016/j.habitatint.2014.08.006>.

¹¹² Deepak, 'Barriers Faced by Young Adults with Disabilities in Ulaanbaatar, Mongolia: Report of a Community-Based Emancipatory Disability Research (CB-EDR)'.

Үйл ажиллагааны хураангуй

Судалгааны ажлыг 2020 оны 6-8 дугаар саруудад нийт гурван үе шаттай хийсэн. Судалгааг биечлэн уулзах болон алсын зайнаас онлайнгаар ярих замаар коронавирусын цар тахлын дүрэм журмын дагуу хийж гүйцэтгэсэн.

Үе шат 1. Бичиг баримтад дүн шинжилгээ хийх, оролцогчдыг тодруулах зураглал гаргаж, ажлын уулзалт, хурал зохион байгуулж, судалгаанд оролцогсдоос судалгааг авах гэх зэргээр Улаанбаатар хотын барилга байгууламжийн орчны хүртээмжийн талаарх одоогийн нөхцөл байдлыг ойлгоход анхаарлаа хандуулсан. Уулзалтуудыг засгийн газрын албаны хүмүүс, архитектор, хот төлөвлөлтийн төслийн менежер болон хөгжлийн салбарын зөвлөхүүд оролцсон.

Үе шат 2. Улаанбаатар хотод амьдарч буй хөгжлийн бэрхшээлтэй иргэд барилга байгууламжийн орчин болон дэд бүтцийн өөрт нь үзүүлэх туршлагыг хуваалцсан. Ярилцлага авч, фото зургаар тэмдэглэл хөтөлж, Улаанбаатар хотод амьдарч буй хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тулгарч буй саад бэрхшээлийг ойлгоход хамтдаа дизайн хийж ажилласан. Энэ үед сайн жишээ болохуйц газрыг олж, илүү хамруулсан хот болгох хүсэл эрмэлзлийн талаар санал бодлоо хуваалцсан.



Фото тэмдэглэл: Зурагт манай судалгаанд оролцсон хүн автобусаар явахад хүндрэлтэй байдгаа харуулж байна

Үе шат 3. Судалгааны төгсгөл хэсэгт өмнөх хоёр судалгаагаар гүйцэтгэсэн анхны үр дүнгүүдийг хэлэлцэн үнэлгээ, дүгнэлт өгсөн. Энэ хэсгийн гол зорилго нь нийт судалгаанд оролцогсдын гаргаж ирсэн боломж болон хэрэгжүүлж болох уриалга дээр үндэслэн хамруулсан загварыг гаргаж ирэх юм. Ажлын хүрээнд үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх хамруулсан загварын аргачлалыг боловсруулж, мөн оролцогчид өөрсдийн цаашдын ажилдаа хэрэглэж болох хамруулсан загварын аргаас суралцсан.

Энэхүү судалгаанд засгийн газар ба бодлого, барилгажуулалтын салбар болон хамт



олон гурван үндсэн оролцогч талуудтай байсан. Судалгаанд төрийн болон хотын барилгажуулалтын мэргэжлийн салбарын нийт 15 хүнээс барилга байгууламжийн хүртээмжийн асуудлаар ярилцлага авсан. Мөн 10 хөгжлийн бэрхшээлтэй хүнээс ярилцлага авч, 5 хөгжлийн бэрхшээлтэй хүнээс фото тэмдэглэлээр ярилцлага авсан. Нийт ярилцлагад оролцсон оролцогчдын 17 эрэгтэй, 13 эмэгтэй байсан. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсээс 8 эрэгтэй, 7 эмэгтэй оролцогч байсан. Насны хувьд 18-29-өөс 60+ насныхан байсан ба 30-39 насны 12, 40-49 насны 8 оролцогч байсан. Судалгаанд оролцсон ХБИ нь хөдөлгөөний, харааны болон сонсголын гэх мэт өөр өөр төрлийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс байсан. Хоёр удаагийн семинар ярилцлага зохион байгуулсан бөгөөд нэг удаад нь дан ХБИ, нөгөөд нь ХБИ болон бусад судалгаанд оролцогчид ба анхны цуглуулсан тоо баримт дээр тулгуурлаж олсон асуудлаа ярилцаж, хамтарсан дизайн гаргасан. Үйл ажиллагаанд замын зураглал гаргах, оролцооны зураглал буюу үйл ажиллагаанд ХБИ-д оролцох үеийн хүртээмжийн талаар зураглал гаргах, мөн орчны хүртээмж, хамруулсан загвартай болгох талаар



Семинарыг алсын зайнаас хамтран явуулж байна.

бүсчлэн нэн тэргүүнд анхаарал хандуулах хэсгүүдийг тодруулсан. Эдгээр судалгаагаар олж авсан үр дүнгүүдээ баталгаажуулах ажлын хэсгийн уулзалтуудыг семинар тус бүрийн ард зохион байгуулсан.

Мөн судалгааныхаа талаар мэдээлэл өгөхөөр уг салбарт ажилладаг олон үндэстний хөгжлийн байгууллагууд, орон нутгийн ТББ-ууд болон архитекторуудын байгууллагууд гэх зэрэг долоон байгууллагатай уулзсан.

Монголд хамруулсан загвар болон хүртээмжтэй барилга байгууламжийн орчин бүрдүүлэхэд хэн гол нөлөөтэй

Хэн хамруулсан загвар болон хүртээмжтэй орчин бүрдүүлэхэд гол нөлөөтэй вэ гэдгийг олохын тулд багаараа алсын зайнаас (онлайн) уулзалтуудыг хийж, оролцогч талуудыг тодруулсан. Ингэснээр бүх оролцогч талуудыг гарган ирж хэн хамруулсан загварыг илүү ашиглах, хэрхэн оролцох зураглал бий болгож түүн дээр үндэслэн үр дүнгээ гаргаж авсан.




Фото тэмдэглэл: Зурагт манай судалгаанд оролцсон хүн автобусаар явахад хүндрэлтэй байдгаа харуулж байна





Хамруулсан загварт хөтлөх зам – хаана байна?



Ажиглалт

Оролцогч талууд (бодлого, хамт олон, үйлдвэрлэл /барилга/-тай чухал сэдвүүдийг олж, судалгааны тоо баримтуудыг илрүүлэхэд сэдэвчилсэн дүн шинжилгээг ашигласан. Оролцогч талуудын үзэл бодлуудыг нэгтгэж сэдвүүдээс ойлголтуудыг гаргаж ирэв.

Улаанбаатар хотод амьдарч байгаа хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн туршлага:

Улаанбаатар хотын хөгжлийн бэрхшээлтэй иргэн байхад ямар вэ?

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс барилга байгууламжийн орчинд болон ер нь хамрагдахад ихээхэн саад бэрхшээлтэй учирдаг. Эдгээрийн нэг жишээ бол:

“Улаанбаатар хотод хөгжлийн бэрхшээлтэй амьдрахад хэцүү. Хэдийгээр хот хүртээмжтэй болж байгаа ч гэсэн шинээр хөгжлийн бэрхшээлтэй болсон хүмүүсийг нийгэмшүүлэх бодлого, хөтөлбөр байхгүй байна. Бидэнд зориулсан сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх, амьдрах итгэл төрүүлэх маш их ажил хийх хэрэгтэй. Мөн ХБИ бид өөрсдөө л хийхгүй бол нэг ч хүн ярьж, хийхгүй тул бид хүчтэй байж маш шаргуу хөдөлмөрлөх хэрэгтэй.”



Оролцогчид бицт орчноос ялгаварлан гадуурхалтыг мэдэрдэг

“Очих дуртай даанч очиход хэцүү. Тиймээс би очих гэж оролдоггүй.”

Биет орчны хүртээмж болон хөдөлгөөний бэрхшээлтэй холбоотой бэрхшээлүүдийг бүхий л оролцогч талууд маш сайн ойлгодог ч барилга байгууламжийн орчин хөдөлгөөний бэрхшээлтэй хүмүүст асуудлууд байсаар байна: “Алхам бүрд шаттай тулгардаг”. Хүртээмжтэй гэж яригддаг газрууд ч бүх хэрэглэгчдэд зориулсан хүртээмжтэй биш, төрөл бүрийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг анхаарч үзээгүй байдаг гэж оролцогчид ярьсан. Үүнээс харахад бүх чадваруудыг анхаарч үздэг хамруулсан загварын талаар сургалт хэрэгтэй байгааг харуулж байна. Сонсголын бэрхшээлтэй оролцогчдын авсан жишээгээр тэд ресторанд орж чаддаггүй учир нь ажилчид нь дохионы хэл мэддэггүйн улмаас эсвэл



харилцаа, мэдээллийн дутмагаас бид үйлчилгээг авч чаддаггүй: “Хуулиар хүн бүр тэгш эрхтэй гэж заасан боловч би хангалттай мэдээлэл авч чадахгүй л байна”.

“Бид ресторанд очихоосоо өмнө ширээгээ захиалах хэрэгтэй, гэвч бид утас болон онлайнаар захиалж чаддаггүй. Рестораны ажилчид нь дохионы хэл мэддэггүйн улмаас бид гэртээ л найз нөхөдтэйгээ уулздаг”.



Гал тогооны өрөөний хүртээмжид тулгарч буй асуудал

Бидний амьдардаг гэр ерөнхийдөө хүртээмжгүй, мөн зарим оролцогчид хэрхэн гэртээ дасан зохицож, хөдөлж болохоор тоноглож, өдөр тутмын үйл ажиллагаа хэрхэн гүйцэтгэдгээ илэрхийлсэн. Гэвч ихэнх тохиолдолд тэргэнцэртэй иргэдэд хүртээмжгүй байдаг, жишээ нь гал тогооны өрөөнд ороход, өрөөнөөс өрөө дамжихад бүр байр орон сууцандаа ороход ч гэсэн хүндрэлтэй байдаг: “Манай байшин гаднаа өндөр шатнуудтай,

налуу зам огт байхгүй. Бид бэлэн болсон орон сууц худалдан авсан, барилгын компани хүртээмжийн талаар огт төлөвлөөгүй байсан. Мөн би байрнаасаа гарах боломжгүй учир ихэнхдээ орон дээрээ л өнждөг”. Нэгэн оролцогч “Монгол гэрийн бүтэц нь зарим өөрчлөлтийг хийх боломжгүй байдаг” гэсэн нь цаашдаа уян хатан зохион байгуулалттай хийхийг бодолцож үзэх хэрэгтэйг харуулж байна.

Биет орчны хүртээмжээс үүдэлтэй саад бэрхшээл нь хандлага болон сэтгэцийн эрүүл мэндтэй маш нягт холбоотой байдаг. Орж гарж, зорчиж чадахгүйн улмаас үүссэн стресс нийгмийн амьдралд бүрэн оролцож чадахгүй байгааг мэдрүүлж саад болдог.

Оролцогчид хувийн болон олон нийтийн амьдралд тулгардаг гадуурхалт, ялгаварлалын талаар мөн хамруулсан загвар хүмүүсийг тавтай тухтай байхад хэчнээн чухал болох талаар ярилцсан.

Хүмүүс хаана амьдарч цагийг өнгөрөөхийг хүсэж байна вэ?

Судалгаанд оролцогчид хотын өөр өөр хэсэгт, төрөл бүрийн сууцанд, гэрээс авхуулаад нийтийн болон амины орон сууцанд амьдардаг. Зарим оролцогчид тайван нам гүм газрыг илүүд үзнэ. Тэд мөн маш их чимээтэй хотын төвд хэрхэн амьдарч байгаагаа ярьсан. Гэрт

амьдардаг оролцогчид авто замаас хол амьдрахыг илүүд үзэж байсан. Мөн түүнчлэн тэд төрөл бүрийн сууцны давуу болон сул талаар ярилцаж бүх оролцогчид санал нэгтгэйгээр гэрт амьдрахаас орон сууцанд амьдрахыг илүүд үзсэн.

“Учир нь энэ бол гэрээс цэвэрхэн. Манай байр бол хуучны есөн давхар сууц, маш олон шаттай.”

Харааны бэрхшээлтэй оролцогч хэрхэн нэг газраа амьдрахын давуу талыг дурдсан учир нь тэр хаана, юу байгааг сайн мэддэг гэсэн. Тэрбээр тухайн газраа төрсөн цагаасаа хойш амьдарч байгаа, гэрийнхээ бүх булан тохойг мэддэг гэжээ. Өөр нэгэн оролцогч гэрийнхээ дотор заслыг өөртөө тааруулж тохижуулснаа хэлж байсан. Гэр бүлийн халуун дулаан уур амьсгал болон тохилог байдал нь амьдрах орчны чухал чанар, хотын хөгжлийн төлөвлөгөөнд дахин төлөвлөхдөө үүнийг боломжтой бол харгалзан үзэх хэрэгтэй.

“Би орчноо солих дуртай.”

Ажил сургуулиас өөр төрөл бүрийн үдэшлэг, зугаалга, цэнгээн гэх мэт олон нийтийн үйл ажиллагаанд оролцох чадвар нь хамруулсан хотын хувьд маш чухал зүйл юм. Ногоон байгууламжууд, мөн барилга байгууламжийн шинэчлэл нь фото тэмдэглэл болон үйл ажиллагааны хамтарсан семинарын үеэр илэрхий байсан. Хүмүүс караокед орж цагийг хөгжилтэй өнгөрөөж, стрессээ тайлдаг бол харин тэдгээр караокены газруудад хүртээмжтэй



Гал тогооны өрөөний хүртээмжид тулгарч буй асуудал

налуу шат, харааны бэрхшээлтэй хүмүүст зориулсан тусгай караокены төхөөрөмжгүй, мөн ажилчдад нь ямар ч мэдрэмж ойлголтгүй, үүгээр зогсохгүй ажилчид болон бусад үйлчлүүлэгчдийн тэдэн рүү чиглэсэн хандлага асуудлууд үүсгэдэг. Нэг оролцогч тэргэнцэр ашиглахаар хумс амархан хугардаг учир маникюрын газарт орохыг хүсдэгээ хэлсэн.

Соёлын газрын хүртээмжийг сайжруулах боломжтой талаар семинарын үед нэн тэргүүнд сайжруулах газрын нэрс гаргаж байх үед дурдагдсан. Харааны бэрхшээлтэй хүн музейд орохыг хүсдэг боловч музейн эд зүйлсэд хүргэдэггүй тиймээс тэд жирийн иргэд шиг үйлчилгээ авч мэдрэх боломжгүй байдаг. Үндэсний цэцэрлэгт хүрээлэн, урлагийн болон



зарим газрууд хүртээмжтэй байна. Спорт бол Монголын соёлын чухал хэсэг бөгөөд дасгал, сургуулилт хийх талбай, байгууламж нь ногоон болон нээлттэй байх нь чухал юм. Гэвч үндэсний цэцэрлэгт хүрээлэнд ороход тусгай тоногдсон суултууртай бие засах өрөө хомс, мөн зарим хэсэгт шатнууд байдаг. Ганц эерэг тал нь тус газар бүхэлдээ нийлээн хүртээмжтэй, хүмүүсийн хэрэглэхийг хүссэн дасгалын төхөөрөмжөөр тоноглогдсон байдаг. Харин нийтийн тээврийнх нь хүртээмжгүй байдал нь зарим үйлчлүүлэгчид ирж, очиход хэцүү, таксины төлбөр их гардаг гэх мэт саад байдаг. Зарим оролцогчдын хувьд тэд хэрхэн гэрээсээ гарч, ажилдаа явж, ирж байгаа нь тэдний өдөр тутмын амьдралд маш их төвөг учруулж байгааг дурдсан.

“Би ихэвчлэн үндэсний парк, тоглоомын төв болон бусад олон нийтийн газар найз охинтойгоо явахыг хүсдэг гэвч хамгийн хэцүү нь тийшээ явах болон гэртээ харих зам хэцүү байдаг. Эвдэрсэн зам, зай талбай багатай гудамж болон шатнууд байнга таардаг.”



Гал тогооны өрөөний хүртээмжид тулгарч буй асуудал

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллага бол ХБИ-ийг дэмждэг, нийгэмтэй харилцах гол эх үүсгэвэр юм. Ялгавардагдаагүй мэдрэмж төрүүлэх тиймэрхүү газрууд маш чухал. “Миний хувьд би Түгээмэл хөгжил төвд очих дуртай, би өөр газар очихоор хүмүүс миний яриаг ойлгодоггүй, харин энд олон найз нөхөдтэй, тэдэнтэйгээ чөлөөтэй ярьдаг. Тэд ч мөн намайг ойлгодог. Биет орчин саадгүй шигээ хүмүүс нь сайхан хандлагатай болохоор

би тэнд очих дуртай” Биет орчны хүртээмж болон нийтийн хандлага нь оролцогчдыг нийгмийн үйл ажиллагаанд оролцохыг хязгаарладаг байна.

Хотын хөгжил, дэд бүтэц ба газар

Тусгаарлагдсан хот

Гэр хороололд амьдрах нь хотын бусад хөгжсөн хэсэгт амьдрахаас тэс өөр ойлголт юм. Гурван үндсэн асуудал байдаг. Үүнд:

- тэд гэр дотроо ариун цэврийн өрөөнд орж чаддаггүй,
- тэдний гэр төвлөрсөн ус болон халаалтын системд холбогдоогүй
- зам болон нийтийн тээвэр маш муу хөгжсөн байдаг.



Гэр хорооллын жорлон хүртээмжгүй

Эх сурвалж: Түгээмэл хөгжил төв

Эдгээр шалтгааны улмаас оролцогчид нийтийн орон сууцанд амьдрах нь илүү тохитой, мөн хотын хүн ам нягтаршил ихтэй бол энэ нь улам сонирхолтой гэж болно. Гэр хороолол хүртээмж, дэд бүтцийн хувьд маш асуудалтай гэдэг нь тодорхой бөгөөд хөрөнгө оруулалт хийх шаардлагатай. ХБИ өмнө нь хөдөө болон нүүдлийн амьдралд хэрхэн амьдарч байсан тухай мэдээлэл маш бага байна. Тиймээс үнэндээ илүү соёлжсон, нийгэмшсэн, хурдацтай дахин төлөвлөлтийн төлөвлөгөөнд оруулахад төвөгтэй юм.

Хотын хөгжил, үндсэн дэд бүтцийн хэрэгцээ, илүү хамруулсан болгох нь

Улаанбаатар хотын байгуулалт, дэд бүтцийн талаар анхны тоо баримтыг цуглуулсан. Мөн оролцогчид дэд бүтцийг оролцоо, хамруулалт гэж үздэг: “дэд бүтэц бол тэдний ажил эрхлэх, боловсрол эзэмших хаалгыг нээж дахин амьдралын чанарыг сайжруулна” гэжээ. Үйлдвэрийн (барилга) оролцогч талуудын хувьд барилгын аюулгүй байдал нь хүртээмжгүй, бэртэл гэмтэл учруулахын шалтгаан болж байна гэж үздэг. Зарим оролцогчдын хэлснээр баригдаж байгаа барилгаас юм унаж гэмтэхэд хүргэдэг ба үүнээс үүдэн богино болон урт хугацааны бэртэл авч болох нь судалгаагаар харагдсан¹¹³ бөгөөд энэ нь цаашдаа барилгын дүрэм журмаа сайжруулахыг хэлж байгаа юм. Хөгжлийн бэрхшээлийн цагаан номд дурдсанаар Монголчууд орчноос үүдэлтэй бэртэж, эрүүл мэндээрээ хохирон хөгжлийн бэрхшээлтэй болох эрсдэл ихтэй гэжээ¹¹⁴. Мөн оролцогчид илүү хамруулсан загвар нь ялгаварлан гадуурхал үзэхгүй байхад чиглэнэ гэсэн. Өөрөөр хэлбэл илүү

¹¹³ Menard, ‘Mongolia’s Urban Planning Paradox’.

¹¹⁴ Government of Mongolia and JICA, ‘White Paper on Disability in Mongolia 2019’.



хүртээмжтэй дэд бүтэц нь ялгаварлан гадуурхалтыг бууруулж, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс рүү чиглэсэн олон нийтийн хандлагыг сайжруулж чадна.

“Дэд бүтэц бол бүхий л зүйлсэд зориулсан маш чухал холбоос бөгөөд хэрвээ дэд бүтэц хүртээмжгүй бол бид сурч, ажиллаж чадахгүй. Мөн миний бодлоор орчин хүртээмжтэй бол ялгаварлан гадуурхах нь багасна.”

Орон зайг хүртээмжтэй болгох нь

Хот болон барилгыг хүртээмжтэй болгоход ‘зай талбай’ гаргах нь нэгэн төрлийн зорилт юм. Хуучны барилгуудад шинийг барихаас илүү үнэтэй, ихэнхдээ маш хэцүү байдаг бөгөөд хотыг газрын эзэмшил болон бүсчлэн хуваасан нь дэд бүтцийг хүртээмжтэйгээр төлөвлөхөд хүндрэл учруулдаг. *“Байгууллагууд налуу зам тавьж, хүртээмжтэй орц гарц хийж, замын хашлагыг авч эсвэл тактилан зам тавих зэргээр оролдож байгаа хэдий ч орон зай хангалтгүй үед хангалттай өөрчилж чадахгүй байна”.*

Хотын бүтээн байгуулалт нь *“газар эзэмшил системтэй биш, олон нийтийн барилга байгууламжид зориулж газар чөлөөлөхөд хүндрэлтэй, явган хүний зам, талбай гаргах хангалттай зай байхгүй”* зэрэг замбараагүй хийгдсэн. Зам, тээврийг хариуцсан засгийн газрын агентлагт ажилладаг нэгэн оролцогчийн хэлснээр зураг нь явган хүний замын стандарт (0.5 метрийн ногоон байгууламжтай 1.5м өргөн) байдаг боловч зай талбайн хомс байдлаас явган хүний замыг ихэвчлэн 0.8 – 0.9м өргөн хийж байгаа ба энэ нь тэргэнцэртэй хүмүүс явах боломжгүй байгаа. Иймээс хамруулсан загвар болон хүртээмжийн стандартыг хот төлөвлөхөд баримталж, барилга барих зөвшөөрөл авах үед нэг шалгуур үзүүлэлт болгохыг зөвлөж байна.

Гэр хороололд системтэйгээр төлөвлөлт хийхэд маш хэцүү, тиймээс ийм нөхцөлд амьдарч буй хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хувьд тэд гэрийнхээ эргэн тойрны орчноо хянах боломжгүй байдаг: *“Би хашаанд амьдардаг. Энэ хашаа минийх биш, тиймээс би эзэнд нь орж гарахад хэцүү байна гэж хэлж чаддаггүй”.* Иймэрхүү хөршүүдийн хоорондох албан бус дэд бүтцийн харилцаа нь хотод нэгэн адил зай талбайн хүртээмжийн болон хамруулах асуудал бий болгож байна. Эдгээр асуудлуудтай тулгарч буй оршин суугчдад дэмжлэг үзүүлэхийн тулд хамруулах төлөвлөгөө болон дүрэм журмыг гэр хороололд мөн мөрдөх хэрэгтэй.

Барилга, орон зайн төлөвлөлт нь илүү хамруулсан, хүртээмжийн стандартыг бүрэн биелүүлэх хэрэгтэй. Ер нь барилгыг холбогдох норм, стандартын дагуу барьж, дараа нь хүртээмжийн стандартыг баримталж байгаа нь маш тулгамдсан асуудал болоод

байна. Өөрөөр хэлбэл хэрэглэгч барилгыг хүртээмжтэй болгож өөрчилдөг, тухайлбал дэлгүүрт налуу зам хийх гэх мэт. Хамруулсан загварын сургалт нь үйлчлүүлэгч болон барилгын мэргэжилтэн хоёрын аль алийг нь хүртээмжийг тоймлон харах, зөвхөн техникийн шаардлагаар хязгаарлахын оронд загвараа гаргах явцад бүтээлч байдлаар хандахыг уриалдаг юм.

Ихэнх нийтийн барилгуудад үндсэн үйлчилгээ нь нэгдүгээр давхартаа байдаггүй. Хэрвээ лифт хийвэл тэр нь маш үнэтэй болох учир байгууллагууд үйлчилгээгээ хэрхэн хүргэх болон хаана байрлуулахаа бодох хэрэгтэй. Барилга байгууламжийн орчныг илүү хүртээмжтэй, хамруулсан болгоход биет орчны хамруулсан загварыг үйлчилгээ үзүүлэх, зохион байгуулалтын төлөвлөлтдөө нэмэлтээр хийх хэрэгтэй.



Судалгаанд оролцогч сонсголгүй таксины жолооч эмэгтэйд тулгарч байгаа харилцааны бэрхшээл

Хамруулахад учирч буй хөгжлийн бэрхшээлтэй холбоотой бусад асуудлууд

Хүртээмжтэй байдлын саад тотгорын талаар хэлэлцэж байхад оролцогчид хүйс болон нийгэм, эдийн засгийн байдалтай холбоотой асуудлуудыг ярилцаж байсан. Нийтийн тээвэр хүртээмжгүйгээс такси барихад хүрдэг, харин таксины төлбөр нь автобусаар зорчихоос өндөр тул хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үнэтэй тусч, ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд таксинад болон автобусанд аюулгүй зорчих асуудал тулгарч байна. Мөн эмэгтэйчүүд эрүүл мэндийн үндсэн үйлчилгээгээ хүртэхэд нэмэлт асуудлууд тулгарч байна. Хамруулсан загварыг бүрэн хэмжээгээр нь бий болгоход хүртээмжийг сайжруулах арга хэмжээнд салбар хоорондын асуудлыг тусгах хэрэгтэй.

“Би ганцаараа орой такси барихаас айдаг, заримдаа жолооч нар утасныхаа дугаарыг өгчих, өгөхгүй бол буулгахгүй гэх мэт дарамт үзүүлдэг”.



“Би бол эмэгтэй жолооч, би хоёроос гурван согтуу хүнд таксигаар үйлчилдэггүй. Настай хүмүүст үйлчлэхэд мөн хэцүү тэд таксины явсан төлбөрөөс бага мөнгө заримдаа өгдөг”.

Олон оролцогчид семинарын үеэр тэд бэрхшээлийн улмаас дахин дахин нүүх, жишээ нь хөдөөнөөс хотод, гэр хорооллоос орон сууцанд гэх мэт илүү тохилог амьдралын орчны талаар ярилцсан. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд илүү хүртээмжтэй орчинд үйлчилгээ авахаар нүүдэг ч шинэ нөхцөл байдалд нийгэмшихтэй холбоотой асуудлууд гарч ирж болохын зэрэгцээ эндээс уг хот хэрхэн төлөвлөгдөж, загварчлагдаж, хөгжсөн эсэхийг харж болно.

Тээвэр, хөдөлгөөн болон хүртээмжийн тасралтгүй үргэлжлэх байдал

Зам, тээвэр нь дэд бүтцийн хүртээмж дотроо хамгийн их яригдсан, “хашаанаасаа гарах, нийтийн тээврээр үйлчлүүлэх нь хамгийн хүнд асуудал”. Хүртээмжгүй тээвэр давамгайлдаг тухайд, харин хүртээмжтэй автобусны нэг чиглэлтэй, гэр хороололд зам байхгүй гэх мэт асуудал хөндөгдсөн. Хүртээмжгүй автобуснууд нь маш өндөр шаттай, нарийн хаалгатай, цагийн хуваарь байхгүй, төрөл бүрийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан мэдээллийн хүртээмж дутмаг байдаг. Нийтийн тээврийн хүртээмж нь үр дүнтэй үйлчилгээнээс мөн хамааралтай, автобусны болон таксины жолооч нар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ялгаварладаг: “Автобусанд суухад шат нь өндөр, жолооч нь яаруу, суухаас өмнө хөдөлснөөс би унах аюултай байдаг”. Таксины жолооч нар огт зогсдоггүй, хүртээмжтэй чиглэлийн автобусны жолооч налуу замаа буулгадаггүй, эсвэл карт уншуулахад ХБИ-ийг эвгүй байдалд оруулж, буруу ойлголт төрүүлдэг. Ихэнх ХБИ оролцогчид нийтийн тээврээр үйлчлүүлэхэд тусламж хэрэгтэйг тэмдэглэн хэлсэн ба ихэнхдээ такси болон өөрсдийн хувийн унаагаар явдгаа хэлсэн. Гэвч ихэнх тохиолдолд энэ шийдвэр нь санхүүгийн бэрхшээлтэй тулгардаг, тэдний нэг нь “би үргэлж таксинд сууж чаддаггүй, тиймээс зөвхөн явахад хэцүү муу замтай газар л таксинд суудаг” гэжээ.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан тээврийн бодлогыг барилга, хот төлөвлөлтөөсөө хойно хийж эхэлсэн хэдий ч Зам, Тээврийн Хөгжлийн Яам энэ асуудал дээр дэвшил гаргаж байна: “зам бол нийтийн өмч, тиймээс зам нь хүн бүрд хүртээмжтэй байх ёстой”. Авто замын тухай хуульд хөгжлийн бэрхшээлтэй холбоотой зүйл заалттай, зам хүлээн авах Комисст хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөөллийг оруулдаг. Төрийн байгууллагын оролцогч талууд хотын дэд бүтцийг системтэйгээр төлөвлөөгүйгээс илүү хамруулсан тээвэртэй болоход асуудалтай тулгарч байгаа, хот төлөвлөлтөд зохицуулалт шаардлагатай талаар хэлэлцсэн.

“Монгол улс хүртээмжийн асуудлыг илүү барилгатай холбож хуульчилсан боловч сүүлийн жилүүдэд хууль эрх зүйн орчин нь сайжирч ирсэн ба 2017 онд Авто замын тухай

хуульд нэмэлт өөрчлөлт хийж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан хүртээмжийн асуудлыг тусгасан. Мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хүртээмжийн асуудалд норм, стандартуудыг хамруулсан. Хуульд гэрлэн дохио, авто машины гэрэл, тэмдэг тэмдэглэгээний шаардлагуудыг хамруулсан. Гэхдээ шаардлага хүссэн түвшиндээ хүрээгүй байна.”



Фото тэмдэглэл: Тэргэнцэртэй хүнд тохиолддог бэрхшээл

Явган зорчигчдын хувьд хотоор явахад хэцүү. Хотын төвийн зарим хэсэгт тактилан зам, хүртээмжтэй гарцтай хэдий ч газар бүрд адил биш. Гэр хороололд зам нь засмал биш, эгц өгсүүр газарт цаг агаарын ямар ч нөхцөлд явахад хүнд байдаг.

Манай зарим оролцогчид автомашины замаар явахад хялбар гэж үзэн тэргэнцэртэйгээ явдаг: “энэ нь аюултай, машинууд маш ойрхон явдаг, гэвч надад явах өөр зам байхгүй, өөр сонголт байхгүй.

Явган хүний зам дээр заримдаа шороо овоолчихсон, заримдаа машин зогсчихсон байдаг”. Тасралтгүй хүртээмжтэй байх нь мөнхийн асуудал, жишээ нь “оролцогчийн амьдардаг байранд лифттэй боловч хаалганаас лифт хүртэл шаттай учраас хүртээмжгүй байна гэсэн үг. Тиймээс энэ нь хот төлөвлөлт, хамтын ажиллагааны асуудал болж харагдаж байгаа юм; “ихэнх байшин цөөхөн хүртээмжтэй газруудтай хэдий ч тэдгээрийг холбосон хонгил хүртээмжгүй байдаг”.

Оролцогчид хүртээмжийн тасралгүй, тууштай байхын чухлыг үзүүлэхийн тулд зургаар илэрхийлсэн: “Манай ажил, гэр хоёр хол биш, би 20-30 мин зарцуулдаг. Тиймээс би ихэвчлэн алхдаг, харин зам нь хүртээмжгүй буюу тал нь эвдэрсэн байдаг. Тиймээс явган хүний замаар алхах боломжгүй тул би автомашины замаар явдаг. Гэртээ ирэхэд манай байранд гаднаа налуу



Замын зураглалын жишээ



замгүй, мөн дотроо лифт хүртэл би хэдэн хэдэн шатаар гарах хэрэгтэй болдог.Тиймээс гэртээ орохын тулд надад хүнээс тусламж гуйх хэрэгцээ гардаг. Зөвхөн миний ажлын орчин хүртээмжтэй ч Улаанбаатар хотод зорчих орчин хүртээмжгүй байдаг”.

Бодлогоос бодит үйл ажил руу – хариуцлага болон хэрэгжилт

Монголд хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалсан хууль, бодлогуудыг боломжийн боловсруулсан. Хууль эрх зүйн асуудлуудаас хүртээмжийн тухай хууль шаардлагатай, одоогийн стандартууд нь зөвлөх шинжтэй байна. Хүртээмжийн тухай хуулийг боловсруулж байгаа, үүнд ХБИБ-ууд оролцож байна. Хяналт болон үнэлгээ нь бодлогын түвшинд хамруулах явцад чухал зүйл боловч хүртээмжид үнэлгээ хийх зэрэг одоогийн хяналт, үнэлгээний механизм нь хязгаарлагдмал, тууштай биш байна.

Төрийн албаны оролцогч талууд хамгийн том саад бэрхшээл нь бодлогыг хэрэгжүүлэхэд тулгардаг гэсэн: “Асуудал хуульд биш тогтолцоонд, ялангуяа барилгын зургийг батлах тогтолцоонд байна”. Хүртээмжтэй холбоотой асуудлыг хэрэгжүүлэх, хүчин төгөлдөр болгох механизм байхгүй, барилга барих процесст хүртээмжийн асуудлыг орхигдуулсан, мөн энэ процесст хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэндүү сүүлийн шатад оролцуулж байна. Одоогийн байдлаар барилга баригдаж дуусахад л хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөөллөөс зөвшөөрөл авч байна.

Барилга баригдаж дууссаны дараа гэрээлэгч тал, зургийн дизайнеруудад өөрчлөлт хийх хоёр долоо хоног л өгдөг нь саналыг гүйцэтгэх боломжгүй болгодог. Мөн бидний нэг оролцогчийн хэлснээр заримдаа хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үзэл бодлыг барилга хүлээж авах комиссын бусад гишүүд хэрэгсэхгүй болгож, эсвэл хахууль өгөх нөхцөл үүсдэг. Зөвшөөрлөө авсан барилгууд хүртээмжийн талаар налуу зам, бие засах өрөөнд анхаарлаа хандуулахаас бусад зүйлд маш бага анхаардаг байна. Оролцогч талууд хүртээмжтэй байдлыг шалгах хүснэгтийг илүү

Object: Ramp of outdoor stairs				
Sub-object: Ramp				
Question	Measurement	State	Note	Picture
Ramp width	180	Standard		
Slope percent	17.5	None standard	1:12 or 8% slope	
Smooth and non-slip surface	Yes	Standard		
Height of the kerb	0	None standard	Kerb height has to be not less than 5 cm	
The width of the slope start	180	Standard		
The length of the slope start	150	Standard		
The width of the slope end	180	Standard		
The length of the slope end	150	Standard		
Advice				
Renovate the outdoor ramps by accordance with the standards.				
Стандарт бус налуу замыг үнэлсэн байдлын жишээ				
Эх сурвалж: Түгээмэл хөгжил БДАТ				

сайжруулахаар оролдож байна. Хүртээмжийг шалгах хүснэгт нь хүртээмжийн стандартын дагуу хийгдсэн байх ёстой. Тэгэхгүй бол барилгынхан стандартуудыг дагаж мөрдөж чадахгүй болно.

Стандарт, журамтай холбоотой бас нэг асуудал нь тэдгээр нь бодит байдал дээр хэрэгжих явдал юм. Үйлчлүүлэгчээс эхлээд дизайнер, инженер, гэрээлэгч гэх мэт бүх оролцогч талууд шаардлагыг дагах нь чухал юм: *“хэрвээ хүн бүр ажилдаа дүрэм журмаа дагавал орчин хүртээмжтэй болно”*. Монголд гарсан энэхүү үр дүнгүүд нь Хөгжлийн бэрхшээлийн Дэлхийн тайлангийн үр дүнтэй таарч, стандартыг дагаж мөрдөх сахилга бат, стандартын талаарх мэдлэгийн аль аль нь доогуур, мөн стандартууд заавал мөрдөх биш байна¹¹⁵.

Бодлогоос хэрэгжүүлэх хүртэлх хугацаанд гарч байгаа цоорхойг хүртээмж, хамруулалт гэдэг нэр томъёог оролцогч талууд бүрэн сайн ойлгохгүй байгаагаар тайлбарлаж болох юм. Ихэнх тохиолдолд эдгээр нэр томъёог олон улсын хөтөлбөрүүдээс хуулбарласан байдаг бөгөөд бодлогын бичиг баримтад байгаа хэдий ч нэг оролцогчийн хэлснээр Монголд “боломжит хэрэглэгдэхүүн” болон “хамруулах” зэрэг нэр томъёонуудыг сайн ойлгохгүй байна. Олон нийтийн ойлголт хязгаарлагдмал нь хэрэгжүүлэхэд улам хүндрэл учруулдаг: *“Миний бодлоор эхлээд бид хамруулалт, эсвэл хамруулсан гэдэг нэр томъёог зөв тодорхойлох хэрэгтэй байна”*. Эдгээр нэр томъёонуудыг зөв ойлгох нь нийт оролцогч талуудыг зөвшилцөлд хүрэхэд тус болно.

Зардлыг саад бэрхшээлээс урамшуулал болгож хөрвүүлэх хэрэгтэй

Бодлого боловсруулагч, барилгын салбарын гол оролцогч талууд хамруулсан, хүртээмжтэй загварын үнэ цэнэ, ач холбогдлыг маш сайн ойлгох хэрэгтэй. Биет орчин, туслах технологийн салбарт зардлыг хязгаарлах нь чанараас илүү чухал уу: *“Компани ажлын зардалдаа анхаарлаа хандуулдаг болохоос ажлын чанарт анхаарлаа хандуулдаггүй. Тиймээс бид үүнийг өөрчлөх хэрэгтэй”*. Хамруулсан загвар болон хүртээмж нь зардал ихтэй, үнэтэй гэж хүмүүс боддог. Тухайн төслийг эхнээс нь хамруулсан загвараар үнэлж ойлговол урт удаан хугацаандаа үнэлэмж нь нэмэгдэж, эдийн засгийн хувьд илүү өргөн хүртээмжтэй болж тухайн дизайныг сонгосон шийдвэрийг улам дэмжиж өгдөг.

“[харааны туслах хэрэгслийн талаар] Тэдний чанар сайн биш. Засгийн газар мөнгийг гаргадаг ч хувийн компаниуд импортолж оруулж ирдэг учраас тэд чанарт огт санаа зовдоггүй, зөвхөн тоонд л анхаарал тавьдаг.”

¹¹⁵ The World Health Organisation, ‘World Report on Disability’.



Хэн дизайны гаргаж, түүндээ хэрхэн хариуцлага хүлээдэг вэ?

Хариуцлагын эргэн тойрон дах тодорхой бус байдал нь хариуцлагагүй байдлыг бий болгодог. Хариуцлага нь бодлогын түвшинд, мөн барилгыг гүйцэтгэгчийн түвшинд байх ёстой. Орон нутгийн засаг, захиргааны шийдвэр нь үндэсний бодлогын нэгэн адил чухал: *“Нийслэл хотод хүртээмжийн бодлого хэрэгтэй”*. ХБИБ-уудын ‘асуудал хөндсөн дуу хоолой’ маш чухал гэдгийг төрийн зүгээс оролцогчид үнэлсэн нь илүү хамруулсан хотыг загварчлахад чухал үндсэн хэсэг юм. Гэхдээ энэ механизмыг сайжруулах хэрэгтэй байна. Засгийн газрын зам тээврийн холбогдох агентлагийн хүний авсан жишээнээс харахад хамт олны хариуцлага чухал гэдгийг харуулж байна: *“Бид хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс шиг асуудлыг тийм ч хурдан харж чадахгүй, тиймээс мэдээллийн систем үүнийг хялбар болгоно”*. Хамруулсан загвар нь *“зохион бүтээх шинжлэх ухаан болон төлөвлөлт”* гэсэн хоёр салбараар тодорхойлогддог бөгөөд энэ нь барилга байгууламжийн орчин хамруулсан загварыг хэчнээн тусгасан байгаагаар түүнийг эзэмшсэн байдал харагддаг юм”.

Хариуцлага, хяналтын хувьд 2019 онд Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар байгуулагдсан бөгөөд энэхүү засгийн газрын агентлаг нь хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус зөвлөлийг бодлогоор хангах, салбар зөвлөлд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөөлөл бодлого гаргах түвшинд ажиллахад чухал үүрэг гүйцэтгэдэг.

Техникийн түвшинд зөвшөөрөл олгох улсын комисс, Нийслэлийн Мэргэжлийн хяналтын агентлаг зэрэг бусад байгууллагууд чухал үүрэг гүйцэтгэдэг. Улаанбаатар хотын хүртээмжийн талаарх бодлого нь хотын мастер төлөвлөгөөг сайжруулан, хүртээмжийн онцлог шинжүүдийг анхаарч үзэж өөрчлөхөд тус болно. Улсын нийслэл нь хөдөө орон нутагтаа үлгэр жишээ байх хэрэгтэй. Засгийн газар барилга барихад хүртээмжийн стандартыг баримталж байгаа эсэхийг хянах ёстой гэдгийг оролцогчид мэдээлж байсан. Гэсэн хэдий ч хувийн байгууллагууд зай талбайг хамгийн ашигтайгаар ашиглахад анхаарлаа хандуулдаг: тэд хүсвэл хүртээмжийг эхнээс нь хийдэг. Барилгын талаарх ойлголт мэдлэг, соёлын эерэг өөрчлөлт нь хувийн салбарыг стандартаа мөрдөхөд шахаж хүртээмжийн талаарх иргэдийн шаардлага ихэснэ гэсэн үг.



Хамруулсан хотыг бий болгоход тохируулсан, хамтарсан хандлагыг ашиглах нь

Хүртээмжтэй, хамруулсан болгоход тулгарах саад бэрхшээлүүд нь олон талтай юм

“Миний бодлоор хүртээмжгүй байх нь өөрөө ялгаварлан гадуурхалтын нэг хэлбэр юм”

Биет орчин хүртээмжгүй байдал, олон нийтийн хандлага сөрөг, ойлголт мэдлэг хангалтгүй, үйлчилгээн дэх асуудлууд нь нэгдэн орчныг хүртээмжгүй, гадуурхсан байдалд хүргэдэг. Энэ нь судалгааны үр дүнгээс илэрхий байсан бөгөөд техникийн загварын сэтгэлгүй модон шийдэл нь бүрэн хамруулсан орчныг бий болгоход хангалтгүй юм. Үүнийг үүсгэх олон шалтгаануудын нэг нь эрх зүйн орчны хоорондоо уялдаа холбоогүйгээс үүсгэг гэж оролцогчид тодорхойлж байв: төлөвлөлт ба хөгжил, үйлчилгээ авах ба хөдөлмөрлөх эрх зэрэг нь уялдаа холбоогүй. Барилга байгууламжийн орчныг болон үйлчилгээг төлөвлөх, загварчлахад хүн төвтэй хандлагаар хандах нь эдгээр харилцан уялдаа холбоотой саад бэрхшээлүүдийн гүүр болоход тусална.

“Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс үйлчилгээ авах, мэдээлэл олж авах хүртээмж дутмаг байна. Тэд хаашаа явах, үйлчилгээ хэрхэн авах талаарх мэдэх хэрэгтэй, мөн явж чадахгүй бол өөрт тохирох хэлбэрээр мэдээлэл авах эрхтэй боловч чадахгүй байна, үүнийг сайжруулах хэрэгтэй”

Боловсрол, эрүүл мэнд, цагийг хөгжилтэй өнгөрөөх зэрэг үйлчилгээг хүртэж чадахгүй байгаа нь хот хүртээмжгүй байна гэсэн үг. Эдгээр саад бэрхшээл нь бодит байгаа учир ажилтнуудыг сургах, ойлгуулах, мэдлэгжүүлэх, хандлагыг өөрчлөх хэрэгцээ байна: “Би үргэлж ялгаварлан гадуурхалтыг мэдэрдэг. Жишээ нь би хувийн туслахтайгаа такси барихад жолооч миний хувийн туслахыг хараад зогсдог ч намайг харчхаад явчихдаг”. Хүр бүр үндсэн үйлчилгээ, боломжийг хүртэх ижил тэгш эрхтэй ч хүртээмжгүй орчинд энэхүү эрх, ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд илүү зөрчигддөг: “Сүүлд би эмнэлэг орох гээд чадахгүй эмчийгээ дуудуулсан. Учир нь тэргэнцэр маань хаалгаар багтахгүй байсан”.

Иж бүрэн, олон салбарын, оролцоот хандлага

Оролцогчдыг болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дуу хоолойг нэгтгэхийн ач холбогдол маш чухал юм. Монгол улсын Засгийн газар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагын төлөөлөл оролцуулсан 14 дэд хороо байгуулсан, энэ нь бодлого боловсруулагчдад тэдний дуу хоолойг хүргэх зорилготой юм. Гэвч тэдний дуу хоолойг дэндүү оройтож сонсож, оролцоог хангах механизм хангалтгүй байна.



“Хөгжлийн бэрхшээл салбар бүрд байгаа, учир нь тэнд хүний орчин байгаа”

Эцэст нь хэлэхэд, хамруулсан орчин үүсгэхэд иж бүрэн, системтэй хандлага хэрэгтэй гэдгийг оролцогчид хэлсэн. Хүн бүр ялгаатай байдгийг анхаарч, хүн төвтэй, хамруулсан хандлагаар хотыг төлөвлөх ёстой, ингэснээр хөгжлийн бэрхшээлтэй бүх хүмүүсийг хамруулж чадна. Энэ нь тогтолцоо, үйлчилгээ болон орон зайг загварчлахад илэрч байх ёстой, “хаана хамгийн сайн загвар байна тэнд үйлчилгээ болон ажилчид нь зохицсон байдаг”, мөн туслах технологи, барилга байгууламжийн орчныг холбож: “Туслах технологи болон үйлчилгээ нь дотоод орчин, харин барилга, дэд бүтэц нь гадаад орчин юм. Бүгд нийлээд нэг цогц систем” гэжээ. Сайн хамруулсан дэд бүтэц нь хувь хүнд тусгайлан нөлөөлдөггүй гэдэг нь нотлогдсон¹¹⁶. Монгол Улсад хөгжиж буй хамруулах хандлагын сайн туршлагын нэг жишээ бол санал гомдлыг хүлээж авдаг цахим тогтолцоотой болсон явдал нь нийт иргэдийг хот төлөвлөлтөд оролцох боломжийг бүрдүүлсэн явдал бөгөөд үүнийг боловсронгуй болгож байгаа талаар оролцогчид мэдээлсэн юм.

Хамруулсан загвар



Номын сангийн барилга нь налуу замтай боловч орох хаалгыг өндөрт байрлуулсан нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хамрагдахад шууд бэрхшээл үүсгэж байна

¹¹⁶ Infrastructure and Cities for Economic Development (ICED), ‘Delivering Disability Inclusive Infrastructure in Low Income Countries’.

Хамруулсан загварыг задалбал

Хүртээмж нь барилгын загварын техникийн шаардлагад нийцэж байх нь чухал ч барилгын загвар болон материалын чанар зэрэг чухал юм. Хамруулсан орчин гэдэг нь зөвхөн хүртээмжтэй загвар, бүтээгдэхүүн, орон зай, талбай гэж хязгаарлахгүй, дэд бүтэц нь зөвхөн тэгш, хүртээмжтэй байх асуудал биш юм, энэ нь бүгдэд тэгш хандана гэсэн үг. Чанарын хяналт, мөн тогтвортой байдал чухал ч гэсэн ялангуяа оролцогч талуудын хүртээмжийн талаарх мэдлэг хязгаарлагдмал байна: *“зураг боловсруулах шатанд маш сайн нэг бүрчлэн шаардлагуудыг тусгах шаардлагатай боловч хэрэгжүүлэхэд хэцүү. Барилгын зураг маш тодорхой, нарийвчилсан байх ёстойн зэрэгцээ техникийн шаардлага нь хүртээмжийг маш тодорхой харуулсан байх ёстой”*.

Материалын сонголт нь хамруулсан загварын хамгийн чухал зүйл юм. Халтиргаатай гадаргуу нь асуудал үүсгэдэг гэж оролцогчид хэлсэн, мөн засмал зам дээрх хээ эсвэл нүх нь харааны болон хөдөлгөөний бэрхшээлтэй хүмүүст асуудал болж байгааг хэлсэн. Материалын сонголт, чанар нь туслах технологийн загварт бас чухал, барилга байгууламжийн материалууд хоорондын харилцан үйлчлэл чухал юм. Тухайлбал



Замын хучилт муу байх нь хүртээмжид нөлөөлж, туслах технологийг эвдэлдэг.

халтирдаг явган хүний зам болон таягийн материал хоёрын хоорондын зохицол маш чухал юм: *“Таягийн чанар маш чухал, би түүнийг өдөр бүр хэрэглэдэг, заримдаа хотын явган хүний зам халтиргаатай болдог тул резинэн жийргэвчтэй таяг маш чухал байдаг”*. Туслах технологийн чанар нь барилга байгууламжийн орчинд оролцох боломжийг хүмүүст олгодог бол муу чанарын загвар, материал нь боломжийг хаадаг: *“Засгийн газрын нийгмийн халамжийн үйлчилгээнээс өгдөг тэргэнцэр нь амархан эвдэрдэг, хэрэглэгчийн шаардлагад нийцдэггүй, тиймээс би тэрийг авдаггүй. Би улсаас олгодог мөнгийг авч дээр нь мөнгө нэмээд өөртөө тохирсон сайн, чанартай тэргэнцэр худалдаж авдаг”*. Оролцогчид сайн тохироогүй, чанаргүй туслах технологийн талаар ярьсан нь туслах технологийн хамруулсан загвар нь мөн анхаарах асуудал юм гэдгийг харуулж байна.

Хамруулсан загварыг ерөнхий агуулгаар авч үзвэл: Цаг уур ба газарзүй

Барилга байгууламжийн орчны хамруулсан загвар нь орчны болон газар зүйн онцлогоос

хүчтэй хамааралтай байдаг. Улаанбаатар хот өөрөө хонхорт байрласан учир та хотын төвөөс өгсөж явдаг: “Миний хувьд толгой дээр амьдардаг учир дээшээ доошоо өгсөж, уруудах шаардлагатай болдог. Тэнд ямар ч хүртээмж байхгүй”.



Гэр хорооллын зам

Өвлийн хүйтэн улирал нь хүртээмжид чухал нөлөө үзүүлдэг. Цас, мөс, бороо нь гадаргууг

халтиргаатай болгож хүн болон туслах технологийн аль алинд нь асуудал үүсгэж бэртэж гэмтэх шалтгаан болдог. Тэргэнцэртэй хүмүүс цасанд шигддэг, мөн муу зам, бартаатай газар дээр явахад хүндрэлтэй байдаг. Өвлийн цагт (10-аас -3 дугаар саруудад) хүмүүс ганцаараа явах, бие даах байдлыг мэдэрдэггүйгээ илэрхийлсэн. Өвлийн хүнд хувцас нь хөгжлийн бэрхшээлтэй хүнийг өргөж туслахад хувийн туслахуудад илүү хүндрэлтэй болгодог. Хүйтэн өвөл харааны бэрхшээлтэй хүмүүс даарснаас хурууны мэдрэх чадвараа алдаж Брайл уншихад хүндрэлтэй болдог. Зарим мэдрэхүй нь алдагдсан хүмүүс өвөл гадуур явах тохиолдолд саажсан үе мөч нь мэдрэг чадвараа алдсанаас тухайн хэсгээ хүйтэнд хөлдөөх эрсдэлтэй ба энэхүү шарх нь эдгэртлээ уддаг.



Цаг уур хүртээмжид жил тойрон нөлөөлдөг

Гэр хороололд амьдардаг хүмүүс гэрээ дулаан байлгахын тулд өвлийн хүйтэн, хөлдүү нөхцөлд их хэмжээний түлээ хагалж, бэлтгэх нь хүнд байдаг. Олон хүмүүс нүүрс болон өөр олж цуглуулсан зүйлсийг шатаах нь гэр доторх агаарын бохирдлыг үүсгэдэг, мөн агаарын чанарт муу нь хотыг бүрхсэн их хэмжээний агаарын бохирдлыг үүсгэдэг гэж үздэг. Дэд бүтцийн

түвшинд болон хотын санхүүгийн нөхцөл байдлын улмаас цас, мөсийг цэвэрлэдэггүй бөгөөд мөсийг цэвэрлэхэд маш их цаг зарцуулдаг. Мөн өвлийн улиралд нийтийн тээврийн хүрэлцээгүйн улмаас удаан зогсох эсвэл алхахаас өөр аргагүйд хүргэж, мөн илүү зардалтай такси барихад хүргэх зэрэг санхүүгийн ачааллыг үүсгэдэг. Хүйтний улирал нь



барилга барих хугацааг богиносгодог буюу дулааны 3-6 сарын хугацаанд (4-9 дүгээр сар) л ажиллах боломжтойг оролцогч талууд хэлсэн.

Зуны улиралд мөн тоос их үүсэж, эсвэл хүчтэй бороо орох нь шавар үүсгэж, замын нөхцөл байдлыг мөн хүндрүүлдэг.

Хамруулсан загварыг ойлгож, хэрэглэх нь– хамруулсан загвар гэж юу вэ?

“Хамруулсан загвар гэдэг нь хүн бүрд хүртээмжтэй орчныг бий болгох стандарт ба философи юм. Энэ нь өдөр тутмын хэрэглээнд, амьдрах орчин, боловсролын салбар гэх зэрэгт хамаардаг бөгөөд тийм их зардалтай биш юм. Хүн бүр ижил загварыг ашиглаж болно.”

Оролцогчдын хариултуудаас үзэхэд хамруулсан загварын философийн зарим зарчмуудын тухай итгэл төрүүлэм ойлголтод илэрч гарсан байна. Зөвхөн цөөн оролцогчид л хамруулсан загвар гэж юу болох талаар сонсоогүй байсан. Оролцогчид хамруулсан загварыг дараах байдлаар тодорхойлсон “тэнцүү оролцоог хангах, хүн бүхэнд найрсаг байх”; “ялгаварлан гадуурхахгүй байх эрх”; ашигтай загварын хамгийн энгийн, хялбар арга”; “саадгүй загвар”. Энд ялгаатай байдлыг анхаарч үзэх ёстой гэж нэг оролцогч хэлжээ. Гэвч амьдрал дээр хамруулсан загварын арга, явц нь нотолгоо багатай байсан. Хамруулсан загварын хандлага нь хэрхэн хамруулах, амьдрал дээр оролцоог (нийгмийн амьдралд, шийдвэр гаргахад, дизайн хийхэд) хэрхэн хангах талаар ойлголт нэмэгдүүлэх сургалт шаардлагатай байна. Хамруулсан загвар эсвэл хамруулах нь хүртээмжээс илүү өргөн хүрээтэй нэр томъёо бөгөөд энэ нь нийгэмд илүү ерөнхий байдлаар хэрэглэгддэг.

“Хамруулсан загвар нь хэнийг ч ялгаварлан гадуурхахгүй, аюулгүй орчинд амьдарч, үйлчилгээг тэгш хүртэх талаар бөгөөд бид үүнийг хүртээмжтэй орчин гэж хэлдэг”.

Хэл, нэр томъёоны сонголт нь маш чухал юм. Жишээ нь Барилгын тухай хуульд саадгүй орчин гэдэг ойлголтод анхаарлаа хандуулсан байна. Хүмүүс хамруулсан загвар, нийтлэг загвар, хүртээмжийг хооронд нь хольж сольж хэрэглэж байна. Нэр томъёонуудыг тодорхой тодорхойлж, уялдаа холбоотой бодлого, алсын хараатай болох хэрэгтэй: “Миний хувьд хүртээмж, хамруулсан загварын хооронд ямар нэгэн ялгаагүй байдаг, тиймээс нөхцөл байдлаасаа шалтгаалж заримдаа сольж хэрэглэдэг”. Хэдий ингэж хариулсан боловч хүртээмжийг хүн бүрд ашигтай гэж харж байгаа тухай ярьсан нь сонсоход эерэг байсан бөгөөд хүртээмжээс ахмад настай хүмүүсийг хэрхэн ашиг хүртээх талаар ярилцаж байсан юм.



Аливаа төсөл эхлэхээс нь хамруулсан загварыг төлөвлөх чухал ач холбогдолтойг оролцогчид ойлгосон боловч одоогийн төлөвлөлтийн процессоор барилга барихаас өмнө хүртээмжийг оруулах боломж нь хязгаарлагдмал байна. Учир нь хүртээмжийн стандарт нь зөвлөмжийн чанартай нь албан ёсны батлах процессын нэг хэсэг нь болж чадахгүй байна. ХБИБ-ын төлөөлөл барилгыг зөвхөн бүрэн дууссаны дараа хүртээмжийг үнэлэх боломжтой байна. Төрөөс санхүүжүүлж буй барилгуудад хүртээмжийн хяналт, шаардлагууд нь сайжирч байгаа хэдий ч хувийн хэвшлийн барилгад хяналт муу, үнэ өртөг болон гоо зүйн гэх мэт бусад хүчин зүйлүүд нь давамгайлж байна.

Төсөл эхлэх шатнаас авхуулаад хамруулалтыг нэвтрүүлэхийн чухлыг оролцогчид хүлээн зөвшөөрсөн: *“Хэрвээ тэд энэ ойлголтын талаар ямар ч мэдлэг, мэдээлэлгүй бол дараагийн шатанд энэ жил хийгдэхгүй”*. Тиймээс төслийн “эхний шат”-нд сургалт зохион байгуулах шаардлагатай. Хамруулсан загварын зарчмыг баримталж, алсын хараа, хандлагаа тогтоох нь хамруулсан загварыг тогтвортой болгоход тусална. Өөр нэг оролцогч хамруулсан загварыг хэрхэн төслийн бүх оролцогч талуудад болон төсөл хэрэгжих бүхий л явцад хэрэгжүүлэхийг бодит амьдрал дээр харуулах хэрэгтэй талаар тайлбарласан.

Оролцогч талуудаас хамааран хамруулсан загварыг хэн хэрэглэж болохыг өөр өөр өнцгөөр гаргасан. Төрийн санхүүжилттэй төсөлд хүртээмжийг хэрхэн заавал мөрдөх болгох талаар зарим оролцогчид хэлэлцсэн. Бас нэг хэсэг оролцогчид зураг төслийн болон барилгын компаниуд хүртээмжийн арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд хамтарч ажиллаж болох талаар хэлэлцсэн. Өөр нэгэн оролцогч зарим гэрээлэгч талууд өөрсдийн байгууллагын зорилгоос шалтгаалан хүртээмжийг хийлгэхийг хүсэж эхэлж байна: *“зарим байгууллагууд нийгмийн хариуцлагынхаа хүрээнд зарим өөрчлөлт, тохируулгыг хийх, бие засах өрөөг тохижуулах зэрэг ажлуудыг гүйцэтгэж эхэлж байна.”*

Хамруулалтыг ил болгох нь (хамруулсан загвар)

Хамруулсан загварын үр өгөөжийг хүмүүс ойлгож, харах хэрэгтэй: *“Хэрвээ хүмүүс нүдээрээ харж, биеэрээ шалгавал ... налуу зам гэж юу болохыг ойлгож, эсвэл тэргэнцэр хэрэглэнэ гэдэг нь ямар болохыг ойлгоно ... хүмүүс бодит байдлыг төсөөлөхгүй байна”*. Засгийн газарт барилгыг хэрхэн хүртээмжтэй барих жишиг төслийг боловсруулах төлөвлөгөө байгаа ч сайн хүртээмжтэй орчныг харуулах кампанит ажлуудыг төлөвлөсөн боловч бусад судалгаанд оролцогч талууд энэ кампанит ажлын талаар мэдлэг хязгаарлагдмал байна: *“Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хамгийн сайн хүртээмжтэй орчин бий болгосон байгууллагыг тодруулах үйл ажиллагаа зохион байгуулж байгаа нь сайн жишээг дэлгэрүүлэх зорилготой”*. Хамруулсан загвартай барилга нүдэнд ил бодит харагдвал цаашдын өөрчлөлтөд нөлөөлнө. Одоогийн байдлаар

хамруулсан загварыг төсөвлөх нь илүү зардал гэж хардаг нэг байхад холбогдох зардал нь тодорхойгүй, нууц байх нь хардлага төрүүлнэ.

Туслах технологи ба барилга байгууламжийн орчны хамруулсан загвар

Амьдралыг өөрчлөх, зайлшгүй шаардлагатай туслах технологиуд болон хамруулсан загвартай барилга байгууламжийн орчин хоёр хоорондоо нийлээд хотын хүртээмжийг улам нэмэгдүүлж, тэгш байдлын давуу тал үүсэх чухал ач холбогдолтой юм. Гэвч энэ хоёр хамтдаа биш, аль нэг нь байхгүй бол оролцоо болон хүртээмжид саад бэрхшээлүүд үүсдэг.

“Туслах технологи бол яриангүй маш чухал юм. Энэ нь маш өргөн хүрээтэй. Зөвхөн нэг жишээ нь тэргэнцэр юм. Тэргэнцэртэй хүний асуудлыг шийдэхгүй бол тэргэнцрийн зай, замын тухай хууль, бодлого, биет орчин болон бусад олон зүйлийг зөвхөн тэргэнцрийг тойрон ярьж болно.”

Нэгэн оролцогчийн хэлснээр хүмүүс барилга байгууламжийн орчин дах саад бэрхшээлийг даван туулахдаа туслах технологид найдаж хэрэггүй гэсэн бол бас өөр нэг нь Улаанбаатар хотод туслах технологи ашиглахад маш хүндрэлтэй байсан гэв: “Хэрвээ надад автомат тэргэнцэр байсан бол бүх зүйлс хялбар байх байлаа. Гэхдээ Монголын нөхцөлд, ялангуяа гэр хороололд түүнийг ашиглах боломжгүй. Тиймээс стандартын дагуу сайн зам тавих нь маш чухал.”

Улаанбаатар хотод барилга байгууламжийн хүртээмжгүй орчин болон туслах технологийн хүрэлцээ, чанарын асуудал¹¹⁷ нь хоёулаа нэлээд тулгамдсан асуудал юм. Оролцогчид дэд бүтцийн тааруу нөхцөл, хүртээмжтэй бус байдал болон замын нөхцөл нь туслах технологийг хэрэглэхэд саад учруулдаг талаар их ярив: “Бид гурван жилд нэг удаа таяг улсаас авдаг. Заримдаа хүмүүс, эсвэл машинууд санамсаргүй эвдчихдэг”.



Фото тэмдэглэл хийсэн оролцогч туслах технологийг хэрхэн ашиглагдаа үзүүлэв.

Хонхор, гуу жалга, барилгын ажил, хучаагүй замууд, хашлага, шат нь туслах технологийг

¹¹⁷ WHO and Global Disability Innovation Hub: Country Capacity Assessment: Mongolia (forthcoming)



эвдэлж, мөн түүний эдэлгээнд нөлөөлдөг. Мөн цаг агаарын эрс тэс уур амьсгал нь туслах технологийн хэрэглээнд мөн саад учруулдаг.

“Би гадуур явахдаа тэргэнцрээ алхуулагч болгон хэрэглэдэг. Ядрах үедээ тэргэнцэр дээрээ сууж амардаг.”

Орчныг нээлттэй болгох нь: мэдлэг, боловсрол ба оролцоо

Боловсрол ба мэдлэг

“Хүн бүр, бодлого боловсруулагчид, төрийн байгууллагынхан, төрийн бус байгууллагынхан, барилгын хүмүүс, иргэд бүгдээрээ хамруулалтыг ойлгох хэрэгтэй”

Хүртээмжийн талаар болон саад бэрхшээл, боломж, оролцооны талаар хүн ам боловсролтой болох нь чухал: “Хүмүүс хүртээмжийг ‘мэддэг’ ч энэ нь тодорхой бус, тиймээс хүүхэд болон томчуудыг оролцуулан хүн бүрд ойлгомжтой байдлаар тайлбарлах хэрэгтэй”. Оролцогчид бага наснаас нь сургалтын хөтөлбөрт хөгжлийн бэрхшээлийн талаар боловсролыг оруулах хэрэгтэйг санал болгосон. Хөгжлийн бэрхшээлийг сайн ойлгоход буруу ойлголтыг даван туулах гол хөшүүрэг болно. *“Манай аав ээж тэргэнцэр болон суга таягтай гэрт явж болохгүй гэж боддог. Тэднийхээр энэ бол азгүй явдал юм. Харин би одоо тусдаа амьдардаг”.*

Оролцоо гэж юу гэсэн үг вэ?

Оролцооны ач холбогдлын талаар оролцогчид байнга ярилцсан ба ихэвчлэн загварыг оролцоотойгоор хийхээс илүү нийгмийн амьдралд оролцох эрхийн талаар ярилцсан: “Би оролцдог. Ихэвчлэн цагийг хөгжилтэй өнгөрөөх зүйлсэд оролцдог. Хүртээмжгүй газарт зохион байгуулагдвал би оролцож чаддаггүй. Гэхдээ би аль болох боломжоороо оролцохыг хичээдэг”. Зарим хүмүүс олон нийтийн үйл ажиллагаа болон нийгмийн амьдралд оролцож чадна гэж боддог байхад зарим нь оролцоход саад тулгардаг гэж үздэг: “Би мэдээллийг цагт нь авч чаддаггүй. Мөн энэ нь хүртээмжгүй газарт зохион байгуулагддаг”. Тусгаарлалт, буруу ойлголт болон хүнгүй байх нь оролцоонд болон сайн сайхан байхад саад болдог: “Орон сууцанд өссөн, ерөнхийдөө их ганцаарддаг. Ээж, дүү хоёр намайг асардаг. Надад найз нөхөд байхгүй”.

Загвар гаргах, эсвэл шийдвэр гаргахад оролцуулдаг, мөн хууль боловсруулахад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөөллийг оролцуулдаг гэсэн боловч тийм ч үр дүнтэй байдаггүй байна: “Ерөнхийдөө иргэдийн оролцоог бага гэж үздэг”. ХБИБ-уудыг санхүүжилт, зөвшилцөл, худалдан авалт зэрэг ярилцлагуудад оролцуулдаггүй бөгөөд хэрэв оролцвол илүү хүртээмжтэй болгоход чухал болохоор байдаг. Хэзээ оролцох, зөвлөлдөх нь маш

чухал бөгөөд ихэнхдээ оролцоог хангах явдал нь оройтсон байдаг: “Оролцоо нь зөвхөн барилгыг хүлээн авахад болдог бөгөөд барилгын зураг төсөв боловсруулах үед, барих үед оролцуулдаггүй. Тиймээс гэрээлэгч тал бүх юм дууссаны дараа өөрчлөх шаардлага гардаг”.

“Бид бүхнийг сайжруулж чадах боловч энэ бүхнийг хийхэд маш олон асуудлуудыг шийдэх ёстой байдаг. Жишээ нь бэлтгэл судалгаа, төлөвлөгөө, баталгаа, түншлэгч нараа бэлтгэх болон төсвөө шийдэх гэх мэт. Мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагуудын оролцоо болон манлайлал маш чухал гэж хэлмээр байна. Учир нь тэд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг төлөөлдөг. Засгийн газар болон түүний агентлагууд өөрсдийгөө шүүмжилж чадахгүй, тиймээс төрийн бус байгууллагуудад нээлттэй шүүмжилж чаддаг.”

Өөрчлөлтийг жолоодогчид

“Хүмүүс яагаад барилгыг хүн бүрд хүртээмжтэй барьдаггүйг би ойлгодоггүй”

Хүртээмжийг нэмэгдүүлэхэд өдөөх хүчин зүйлс нь гадаад хүчин зүйлсээр тодорхойлогддог. Жишээ нь 2019 онд болсон “Хамт олонд түшиглэн хамруулан хөгжүүлэх нь” олон улсын хуралд зориулж нийтийн орон зайн хүртээмжийг сайжруулах ажил хийгдсэн юм. Барилгууд нь хүртээмжийн хувьд өндөр түвшинд байх нь олон улсын зочдод нөлөө үзүүлдэг (тухайлбал сүлжээ зочин буудал). Гэвч эдгээр барилгууд олон улсын хүртээмжийн



Харааны бэрхшээлтэй оролцогч аудио ном хийхээр ажиллаж байна.

стандартад нийцэж байгаа эсэх нь тодорхойгүй. Барилга байгууламжийн орчны бүтээн байгуулалтын өртөг нь өндөр байдаг, тиймээс хамруулсан загварын бизнесийн ойлголтыг хөгжүүлэх нь чухал юм. Үүнтэй зэрэгцэн, хамруулсан загварын үнэ цэний талаарх сургалт болон хүмүүсийн амьдралын чанарын үр өгөөж нь илүү дээр ертөнцийг бий болгоход мэргэжилтнүүдэд тусална: “Бүх хүмүүст зориулсан хүртээмжтэй орчин’-ы тухай ойлголтуудыг оюутнуудад заадаггүй”, “архитекторууд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ойлгох хэрэгтэй”.



Хөгжлийн бэрхшээлтэй иргэд хүмүүс ижил тэгш эрхтэй, хүмүүст тусалдаг, эерэг байдаг, ижил хүн гэдэг талаар дуу хоолойгоо сонсгохыг хүсдэг: *“Хотжилт ихсэж байгаа болохоор стандарт, нормуудаа биелүүлээсэй гэж хүсэж байна. Ингэвэл хөгжлийн бэрхшээлд эерэг хандлага бий болно”*. Монголын хөгжлийн бэрхшээлтэй иргэд ялгаварлан гадуурхалтыг мэдэрдэг нь илэрхий бөгөөд хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголтыг өөрчлөхийг маш их хүсдэг: *“Би өөрийн хүссэн газраа цагийг өнгөрөөдөг, хэрвээ бид хичээхгүй бол бид хаашаа ч явж чадахгүй. Тиймээс би өөрсдөдөө боломж бий болгохыг хичээж байна”*.

“Мөн бид бүгд ижил эрхтэй, ижил үүрэг хариуцлагыг үүрдэг. Бид бас сурч, ажиллах ёстой. Хэн нэгнийг гаднаас нь бүү дүгнээсэй. Хүмүүс хүн бүрийн зүрх рүү өнгийж харах хэрэгтэй”

Орчныг боломжтой болгох нь

Барилга байгууламжийн орчин болон туслах технологи хамтарч орчныг боломжтой болгодог. Туслах технологи хэрэглэгчдийн хувьд нэг эсвэл нөгөөх нь хангалттай биш: *“Миний таяг нийгмийн амьдралд оролцоход минь тусалдаг тул энэ нь маш чухал юм”*.

Компьютер, гар утас гэсэн технологиудын үүрэг нь нийгмийг холбох болон амьдралын боломжийг хүртэхэд чухал бөгөөд хоёулаа ‘өдөр тутмын амьдрал’-д чухалд тооцогддог. Манай хөгжлийн бэрхшээлтэй оролцогчдын ихэнх нь ажилдаа компьютер хэрэглэдэг бөгөөд энэ нь ч тэднийг гэрээсээ ажиллах боломжийг олгосон. Гар утасны зарим давуу тал нь түүнийг хаана ч хэрэглэж болдог, цаг хэмнэсэн, холбоо харилцааг хялбаршуулж, нийгмийн харилцааг сайжруулдаг.

Илүү хамруулсан хот уруу

Улаанбаатар хотод барилга байгууламжийн орчин үргэлж өөрчлөгдөж, маш их барилга байгууламж нэмэгдэн, огцом хотжиж, жилийн туршид цаг агаарын янз бүрийн үзэгдлүүд болж, хүртээмжийн хэрэгцээ тогтмол шилжиж, шинэчлэгдэж байна. Сайн хамруулсан загвар нь орчиндоо хялбархан зохицож, хамруулсан загварын сургалт болон дадлага чухал байр суурь эзэлж, хүртээмжийн стандартуудыг баримтлахгүй бол хувьсан өөрчлөгдөж байгаа хотжилттой хамт хөл нийлүүлэн алхаж чадахгүй билээ.



Ямар стандартыг, юуг бид харьцуулж байна вэ?

Улаанбаатар бол стандартыг улсын түвшинд мөрдүүлэхэд хамгийн боломжтой газар: *“Хандлага, хүртээмж, боловсрол, хөдөлмөр эрхлэлт гэх мэт. Нийт хүн амын тал хувь нь Улаанбаатар хотод амьдардаг. Тиймээс энэ бол бодлогын чухал төв юм”*. Хотын хүртээмжтэй байдал нь хөдөө орон нутгаас илүү дээр, илүү хөгжиж байгаа талаар оролцогчид дурдсан.

Хамруулсан загвар нь ‘олон улсын стандарт’ бөгөөд Монгол улс илүү хамруулсан бодлогыг боловсруулахын тулд олон улсын стандартуудыг судалж байна. Одоогийн хүртээмжтэй байдлыг хэмжихэд Япон, Солонгосын нөлөө үүний нотолгоо юм: “Шинэ худалдааны төв бидний нэрлэдгээр Имарт нь Солонгосын хөрөнгө оруулалттай. Тиймээс Солонгос улсын хүртээмжийн стандартаар барьсан. Тэнд хүртээмжтэй бие засах газар болон урсдаг шат хийсэн”. Мөн Монгол улс цаг агаарын хувьд ижил, хүйтний улиралтай орнуудын хүртээмжийн стандартыг мөн судалбал зүгээр юм. Мөн Монгол улс нь бусад Азийн орнуудтай харьцуулахад нийгмийн халамжийн систем нь сайн хөгжсөнд тооцогддог. Тиймээс Улаанбаатар хот болон Монгол улсын хувьд хамруулсан загварын стандартаараа тэргүүлэх боломж байна. Мэдээж оролцогч талууд хамтран ажиллаж, оролцвол боломжтой юм.

Суралцсан зүйлс

Энэхүү судалгаагаар сурсан хамгийн том боломж бол Улаанбаатар хотын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн амьдралыг гүнзгий ойлгож, хотод хэрэгтэй хамруулалт, хүртээмжийн бүрэн 'тогтолцоо'-ны зураг гаргаж, олон оролцогч талуудын ярилцлага өрнүүлэх байлаа. Оролцогчид энэхүү семинар дээр хамтран ажиллах боломж олдсон нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон төрийн байгууллагын оролцогчдын хоорондоо ярилцаж, хаанаас эхлэх талаар санаа бодлоо солилцох боломж олгосон гэж дурдсан.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагын нөлөөллийн ажил нь ихэвчлэн төрийн байгууллагын оролцогчдод, шийдвэр гаргагчдад хүртээмжийн стандартыг ойлгуулахад чиглэсэн байдаг. Оролцооны аргаар зохиосон үйл ажиллагаагаар бусад оролцогч талууд (барилга, хамт олон, засгийн газар) хамтран ажиллаж, ойлголт нэмэгдүүлэх аян, нөлөөллийн ажилд үр нөлөө гарахад үнэтэй хувь нэмрээ оруулж болох талаар ярилцав.

Хүртээмж нь зөвхөн хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагуудад хамаатай зүйл биш юм. Барилга байгууламжийн хүртээмжгүй байдал нь хүн бүрд нөлөөлдөг болохыг оролцогчид



Тэгш хамруулах үйл ажиллагаанд хамтын ажиллагаа маш чухал

зургаар онцолсон. Тэд замын дэд бүтэц хүртээмжгүй байгаагаас хөдөлгөөнд оролцоход саад учирч, осол гэмтэл гарах шалтгаан болдог талаар сэтгэгдлээ илэрхийлсэн. Манай судалгаанд хамрагдсан түншлэгчид аялал жуулчлал нь илүү хамруулсан газрыг сурталчлах боломжийг санал болгож болох юм гэжээ. Одоогоор шинээр баригдсан зочид буудлууд нь илүү хүртээмжтэй барилгын төрлүүдийн нэг бөгөөд энэ нь дотоодын болон олон улсын хүртээмжийн стандартыг холбож байна. Улаанбаатар хот орон нутгийн болон үндэсний, олон улсын зочид, жуулчдад илүү хүртээмжтэй байх боломжтой учир хотын мастер төлөвлөгөөнд нэн тэргүүний хийх зүйлээ үүнтэй уялдуулж, илүү хамруулсан загвар бүхий хот болж болох юм.


Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс хамруулсан загварын талаар мэдлэг, ойлголттой болбол төрийн байгууллагуудын болон нийтийн хандлагыг сайжруулахад тус болж чадна. Хүртээмжийн үнэлгээ гэх мэт үйл ажиллагаануудаар биет орчны хүртээмж болон техникийн засварууд дээр илүү анхаарал тавьдаг. Хотыг илүү хамруулсан загвартай болгоход хичээж туршсан механизмууд нь чухал боловч хамтран загварчлах ойлголтоо нэмэгдүүлэх аян, хамруулсан загварын практик, философиос сурах зэрэг илүү хүн төвтэй бүтээлч аргууд сайн тус болно. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг харж тэдэнд тулгардаг саад бэрхшээлийг ойлгож, соёлын өөрчлөлт, бүтээлч сэтгэлгээ нь мөн ижил чухал юм.

Юу болж байна, юу асуудал болж байна вэ?

Хүртээмжтэй, хамруулсан орчныг бий болгоход “юу болж байгаа” гэдгийг мэдэх нь үндсэн суурь юм. Энэ нь Улаанбаатар хотод ямар газар одоогоор хамруулсан орчинтой, ямар бодлого, үйл ажиллагаа нь өөрчлөлтийг бий болгоход үр нөлөөтэй, илүү хамруулсан хот болгоход хэн нөлөөлж болохыг ойлгох гэсэн утгатай байх юм.

Мөн хүмүүст юу асуудал болж байгааг мэдэх нь чухал. Оролцогчид хүртээмжийн биет бүрэлдэхүүн хэсгүүд, чухал газрууд, хандлага, ойлголт, боловсрол зэргийг хамруулсан барилга байгууламжийн орчин гэж хэлсэн. Асуудал болж байгаа газар, дэд бүтцэд нийтийн тээвэр, боловсрол, эрүүл мэнд гэх мэт нийтийн үйлчилгээ, кино театр, караоке, фитнес зэрэг соёл амралтын газрууд, цэцэрлэгт хүрээлэн, парк зэрэг ногоон байгууламжууд, зам, барилга байшинг нэрлэв. Хүртээмжийн биет бүрэлдэхүүн хэсэгт налуу зам, шатгүй орц, өргөн хаалга, тактилан зам, хүртээмжтэй бие засах газар, мэдээллийн хүртээмж зэргийг нэрлэв. Гэхдээ эдгээрийг стандартын дагуу барьж, загварчлах ёстой. Бүх оролцогч талуудын хандлага, мэдлэг, ойлголт, боловсрол чухал нөлөөтэй.

Төрийн болон үйлдвэрийн салбарынхан хөгжлийн бэрхшээлтэй хүн хэрхэн амьдарч байгаа талаарх ойлголтоо нэмэгдүүлэхийн зэрэгцээ хамруулсан загварын чадвар, үнэ цэнийг мэдэх хэрэгтэй. Тэд мөн илүү хамруулахад нөлөөлөх хүчин зүйлсийн үүргийг ойлгох хэрэгтэй. Олон нийтийн ойлголт, боловсрол нь буруу ойлголтыг арилгаж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог дэмжихэд тус болно. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд мөн өөрсдийн туршлага, төрөл бүрийн хэрэгцээ, чадвараа таниулах хэрэгтэй. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд илүү хамруулсан нийгмийг бүтээдэхэд хэрхэн тусалж чадахаа харуулах



Дасгал хийх хүртээмжтэй гадна орчин чухал



нь эерэг өөрчлөлт бий болгож, хүмүүсийн хандлага, оролцоог нэмэгдүүлнэ.

Хамруулсан загварын мэдлэг сул, хүртээмжийн үндсэн шаардлагын ойлголт нь хамгийн бага түвшинд байгаа нотолгоо нь стандартын шаардлага хангахгүй байгаагаар илэрдэг. Хүмүүс сайн хамруулсан загвар харах чадвартай байх хэрэгтэй. Хотод байнга очдог, алдартай газарт хамгийн сайн хамруулсан загварыг бий болговол олон нийт өөрсдийн өдөр тутмын амьдралдаа хамруулсан загвараас үр ашгийг нь хүртэнэ. Хотод хамруулсан загварын хамгийн сайн загварыг бий болгож, загварыг болон барилгын явцыг үнэлбэл шийдвэр гаргагч болон санхүүжүүлэгчид хамруулсан загварыг практикт хэрхэн нэвтрүүлэх, түүний үнэ өртөг, нийгэмд үзүүлэх үнэ цэнийг ойлгох болно.

Мөн түүнчлэн хотод загварын инновацыг харах боломжтой байгаа. Гэр хороололд Гэр өргөө (GerHub) ТББ-ын боловсруулсан Гэр Инновацын сүлжээ нь цаг агаарын онцлогт тохирсон, ганган, шинэлэг барилгын загварыг санал болгосон. Хотын албан ёсны төлөвлөгөөний үйл ажиллагаанаас гадна “Гэр Өргөө” нь хамт олон болон судалгаа, инновацыг нэгтгэж, гэрийн загварыг дахин зохион бүтээж, соёлын хувьд мэдрэг зүйлийг дахин бодож үзэх бүтээлч боломжийг санал болгосон¹¹⁸.

Монгол улс болон Улаанбаатар хот нь огцом өөрчлөгдөж байгаа, энэ нь төлөвлөгөөгүй хөгжилд хөтөлж улмаар дэд бүтцийн хомсдол, хөдөөгөөс хот руу чиглэсэн иргэдийн нүүдэл гэх мэт хотын хөгжлийн асуудлуудыг зогсолтгүй бий болгож байна. Эдгээр бэрхшээлүүд нь хотод амьдардаг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн амьдралыг илүү хүнд болгож, амьдралын үндсэн хэрэгцээ болох ус, эсвэл өвлийн нөхцөлд дулаан байх зэргийг улам хүндрүүлж, хотод хууль ёсны барилга байгууламжтай орчин аюулгүй, таатай амьдрах асуудлыг хязгаарлаж байна. Хөгжлийн бэрхшээлийг хамруулах хөтөлбөрүүдийг эдгээр том хэмжээний дэд бүтэц болон хөгжлийн асуудлууд дунд орхигдуулахгүй байх ёстой бөгөөд үүнийг боломж гэж харах хэрэгтэй. Хотын хөгжилтэй холбоотой шийдвэр гаргах явцад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дуу хоолойг сонсох нь илүү хүртээмжтэй, хамруулсан барилга байгууламжийн орчныг хэлбэржүүлж, 2030 оны Улаанбаатар хотын мастер төлөвлөгөөнд тусгагдсан тэргүүлэх зорилтуудыг хэрэгжүүлэхэд нь тусалж, тогтвортой хөгжлийн зорилтыг биелүүлэхэд Монгол улсын алсын харааг чиглүүлж, хөгжүүлэхэд тусална.

Туслах технологи болон барилга байгууламжийн орчныг хэрэглэх талаар бид юу сурсан бэ?

Энэхүү кейс судалгааны үед хуваалцсан ажиглалтуудаас харахад хүртээмжийг бий болгох, туслах технологийг ашиглах, хүртээмжтэй хамруулсан барилга байгууламжийн орчны хооронд гүнзгий уялдаа холбоо байна. Хүртээмжтэй барилга байгууламжийн

¹¹⁸ For more information on the various initiatives led by GerHub please visit: <https://gerhub.org/>



орчны загварт туслах технологийн хэрэглээг анхаарч үзэх ёстой ба хамруулсан байхын тулд туслах технологийг ашиглахыг мөн дэмжих хэрэгтэй. Кейс судалгааны оролцогчдын хэлснээр хүртээмжгүй барилга байгууламжийн орчин нь туслах технологийн хэрэглээг хязгаарлаж, эвдрэл гэмтэлд хүргэдэг. Оролцогчид туслах технологийг оролцоог хангагч, эрх мэдэлжүүлэгч гэж харж байгаа бөгөөд эдгээр нь хамруулсан хотод байх ёстой зүйл юм.

Тэргүүлэх чиглэлийг тогтоох нь

Илүү хамруулсан хот болох нь ганц шөнийн ажил биш бөгөөд өөрчлөлтүүдийг аажмаар, нөөц бололцооныхоо хүрээнд хийх хэрэгтэй. Тийм учраас хүмүүсийн нэн тэргүүнд тавьж буй зүйлүүдийг болон боломжит газруудыг ойлгох нь маш чухал. Ярилцлагад оролцсон оролцогчид нийтийн тээвэр, нийтийн газруудын хүртээмжтэй байдал, налуу зам, амьдрах орчин, хууль эрх зүйн орчин, хөдөлмөр эрхлэх зэргийг хамгийн гол анхаарлын төвд байх ёстой салбарууд гэж хэлсэн. Одоогоор хүмүүс хамруулсан загварын үнэ өртгийн талаар сайн мэдэхгүй, энэ нь санхүүгийн ачаалал өгнө гэж боддог нөхцөлд сайжруулахад хэрхэн судалгаа, төсөв хэрэгтэй талаар нэлээд хэдэн оролцогчид ярилцсан. Үйлдвэрийн болон хэрэгжилтийн түвшинд шинэ байшингийн загвар болон зураг боловсруулах явцад бүр эхнээс нь хамруулсан загварыг болон хүртээмжийн стандартыг суулгасан байх ёстой ба төслийн бүх оролцогч талууд энэ үйл ажиллагааг дэмжих ёстой.

Бодит ажлуудыг нээн илрүүлэх нь

Семинарын үед оролцогчид бодит ажлуудыг нээн илрүүлэхээр гурван бүлэгт хуваагдаж ажилласан. Баг бүрийн оролцогчид барилга байгууламжийн орчин, үйлчилгээ, бодлогын түвшинд хамруулах ажлуудыг жагсаасан. Мөн тэдгээрийг нэн тэргүүнд хийгдэх шаардлагатайгаар нь эрэмбэлж, хэн хариуцахыг мөн нэрлэсэн.

Оролцогчдын гаргаж ирсэн нэг санаа нь нийтийн тээврийг хэрхэн хүртээмжтэй болгох талаар ярилцсан. Нийтийн тээврийн тодорхой хувийг хүртээмжтэй болгох нь хангалтгүй гэж оролцогчид санал болгосон. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд нийтийн тээврийн салбарын худалдан авалтын комисст орж, дэд бүтцийг хэрэгжүүлэхдээ үйлчилгээний ажилтнууд болон нийтийн тээврийн салбарын бүх ажилтнуудыг сургалтад хамруулах хэрэгтэй гэсэн.

Энд үзүүлсэн загвар нь хүртээмжийг сайжруулахад хийх үйл ажиллагааны механизмын жишээ юм. Энэ механизмыг аль ч салбарын хүртээмжийг сайжруулах процесст хэрэглэж болох ба биет орчны загварыг өөрчлөхөд хэрэгжүүлэхээр хязгаарлагдахгүй. Гол санаа нь ямар нэг саадыг илрүүлж, тэрхүү саадыг даван туулах шаардлагыг тодорхойлж, хариуцагч тал эсвэл нөлөөлөгч (манлайлагч)-ыг олж, үйл ажиллагааг шаардлагын дагуу хэрэгжүүлэх ёстой. Илүү хамруулсан хот бий болгох өргөн алсын хараатай үед эдгээр ажлууд биеллээ олох ба чиглүүлэх зарчмуудын мөн хэрэгжүүлэх хэрэгтэй.



Үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах

Оролцогчдын авсан нэг жишээ нь өрхийн эрүүл мэндийн төв байсан, энэ төв нь эрүүл мэндийн үйлчилгээ авах хамгийн эхний цэг боловч хүртээмжгүй тухай ярьсан. Эдгээр төвүүд нь орон нутгийн засаг захиргааны хамгийн бага нэгж болох Хороотой хамт, гэхдээ үргэлж хоёрдугаар давхарт байрладаг ба цахилгаан шатгүй байдаг.


Мөн нэг оролцогч сонсголгүй хүн ямар төрийн үйлчилгээ тэдэнд боломжтой байдаг талаар мэдээлэл авахад ямар хэцүү болохыг тайлбарласан. Энэ жишээнд оролцогчид хүртээмжийг сайжруулахад тэдэнд тулгарах бодит орчны загварыг өөрчлөх талаар ярилцсан.



“Дүүргийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтэс”: сонсголын бэрхшээлтэй, ялангуяа сонсголгүй хүмүүс мэдээлэл дутмаг учраас энэ төвөөс ямар үйлчилгээ авахаа мэддэггүй



Эрүүл мэндийн төвийг илүү хүртээмжтэй болгох Үйл ажиллагааны төлөвлөгөө



Төрийн байгууллагуудад хүртээмжийг дэмжих Үйл ажиллагааны төлөвлөгөө

Оролцогчдын бас нэг хуваалцсан жишээ нь байгууллага хооронд хүртээмжийг хянах, эсвэл дэмжихэд төрийн байгууллагуудын хоорондын хамтын ажиллагаа, хариуцлагын талаар байсан.

Олсон үр дүнд үндэслэн илүү ерөнхий үйл ажиллагаануудыг хийхийг санал болгож байна. Үүнд:

Үнэ цэнэ:

- Монголд зориулж хамруулсан загварын тодорхойлолтыг маш ойлгомжтойгоор томъёолж, нөлөөллийн ажлыг тодорхой болгох хэрэгтэй.
- Хамруулсан загварын тодорхой зардал нь хамруулсан загварын төсвийг бий болгоно. Олон нийтийн ойлголт дүгнэлт маш үнэтэй. Бид тэдэнд тийм их мөнгө хэрэггүй гэдгийг харуулах хэрэгтэй.
- Стандартыг хамгийн доод шаардлагаас илүү загварчлахыг дэмжиж алсын хараагаа боловсруул.
- Оролцогч талууд хамруулсан загварт нөлөөлөхөд нотолгоо (жишээ нь энэ кейс судалгаа)-г хэрхэн ашиглах талаар олж судал.
- Хамруулсан загварын үнэ цэнийг Гэрээлэгч талд ойлгуул.

Хариуцлага:

- Бүх шатанд хамруулсан загварын олны танил хүмүүсийг (тэмцэгч) томил
- Стандартууд заавал мөрдөх байх шаардлагатай
- Хамруулсан загвар/ хүртээмжийн шалгах хуудас нь илүү иж бүрэн байх ёстой. Одоогийн хүртээмжийн үнэлгээ нь өөр шалгуурыг ашиглаж байгаа. Өөрөөр хэлбэл энэ нь хүртээмжийн талаар тогтвортой баримт (дата) бий болгож чадахгүй байна.
- Хууль дүрмийг дагаж хариуцлагын механизм болон хариуцлагатай оролцогч талуудтай байх ёстой.

Үйл явц (процесс):

- Хамруулалтыг бүр эхнээс нь эхлэх ёстой. Сургууль дээр хамран сургалт, хөгжлийн бэрхшээлийг хамруулах талаар ойлголт нэмэгдүүлэх хэрэгтэй
- Загвар болон төсвийг салгаж ойлгохгүй байх
- Хуучны барилгуудад, урт хугацааны турш төсөвлөж, системтэйгээр өөрчлөлт хийх нь нөөцийн хязгаарлалтад оруулахгүй байхад тусална

Зөвлөлдөх болон Хамтын ажиллагаа:

- Тогтвортой зөвлөлдөх механизмыг бий болгох
- Загвар гаргах, төсөвлөх үед зөвшилцөх зэрэг асуудлуудад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй зөвлөлдөх ёстой. Ингэж байж хамруулсан загварыг урьдчилж төсөвлөдөг.



- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй бүр эхнээс нь зөвлөлд.

Ойлголт:

- Хамруулсан загварын үр өгөөжийн талаарх олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэх
- Төрөл бүрийн, ялангуяа мэдрэлийн болон сурах бэрхшээлд онцгойлон анхаарч, чадварт анхаарлаа хандуулах ёстой
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэд байнга тулгардаг бэрхшээлүүдээ маш сайн ойлгодог боловч түүнийг хэрхэн засахаа үргэлж мэдээд байдаггүй. Хамруулсан загварын сургалт нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг бодлого тодорхойлогч болон барилгын мэргэжилтнүүдтэй хамтарч загварын шийдэл гаргахад тусална.
- Хамруулсан загварыг хэрхэн хийх талаар зурагтай, тодорхой гарын авлага байвал нүдээр үзэх нь маш чухал.

Хязгаарлалтууд ба цаашдын судлах зүйлүүд

- Уг судалгаатай холбоотой дараах хязгаарлалтууд илэрсэн. Үүнд:
- Коронавирусын цар тахлын онцгой нөхцөл байдлын судалгааг хийсэн учир судалгааны баг орон нутгийн зарим үйл ажиллагаа хязгаарлагдмал, тохируулах шаардлагатай байлаа. Хэдийгээр онлайн ажиллагаа явуулж байсан боловч зарим зүйлсийг хийх болон зөвшилцөлд хүрэхэд хязгаарлалт байсныг дурдах хэрэгтэй.
- Оролцогчид гурван үндсэн хөгжлийн бэрхшээлийн хэлбэртэй байсан. Гэхдээ цаашдын судалгаанд илүү олон хэлбэрийн хөгжлийн бэрхшээлийг хамруулах хэрэгтэй. Жишээ нь: танин мэдэхүйн эсвэл мэдрэхүйн бэрхшээлтэй хүмүүсийг цаашдын үйл ажиллагаанд оролцуулж, хамруулсан загварын талаар зөвлөлдөх нь чухал.
- Судалгааны баг газар дээр нь очин ажиллах боломжгүй бөгөөд коронавирусын цар тахлын нөхцөл байдлын улмаас зарим нэг хамтын ажиллагааны амьд төслүүд хойшлогдсон нь тайланд тусгагдсан төслүүдийг тоог хязгаарлаж байлаа.
- Энэ судалгааг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаас хамруулалт ба хүртээмжийг харж хийсэн. Хамруулсан загвар нь орхигдсон байж болох бусад бүлгийн хүмүүс (арьсны өнгө, анги, хүйс эсвэл нийгэм эдийн засгийн статус гэх мэт)-ийг бас тооцох хэрэгтэй гэдгийг дурдах нь чухал.

Цаашид хийх шаардлагатай нэн тэргүүний судалгаанууд


- Энэ нь цаашдын судалгааны үед ашиглагдах боломжтой зүйлс юм. Үүнд:
- Хөгжлийн бэрхшээлийг хамруулсан нийгэм-соёлын хүчин зүйлсийн судалгаа эсвэл хамруулсан загварын хандлагын нийгэм-соёлын хүчин зүйлсийн судалгаа



- Бодлогын хөтөлбөрийг хэрэгжүүлэхийн тулд хүйс ба хөгжлийн бэрхшээл, анги ба хөгжлийн бэрхшээл, арьсны өнгө ба хөгжлийн бэрхшээлийн гэх зэргийн харилцан хамаарал бүхий баттай өгөгдөл (дата) боловсруулах нь ашигтай байх болно. Энэ судалгаа нь гэр хорооллын оршин суугчид болон эмэгтэйчүүдэд тохиолдсон туршлагын талаар зарим зүйлийг хөндсөн боловч энэ сэдвээр илүү дэлгэрэнгүй судалгаа хийх нь шаардлагатай байж болох юм.
- Хотын дахин төлөвлөлт болон дахин хөгжүүлэхэд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг оролцуулсан судалгаа
- Статистикаас харахад хөдөө орон нутагт хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн ихэнх нь амьдарч байгаа учир хөдөө орон нутгийн барилга байгууламжийн орчны хамруулалт ба хүртээмжийн судалгааг хийхэд магадгүй тэдэнд хүрч ажиллахад илүү хүндрэлтэй байх.
- Тогтвортой хөгжлийн нэн тэргүүний зорилтуудад хамруулсан загварын эзлэх үүргийн талаарх судалгаа. Тухайлбал, уур амьсгалд дасан зохицох арга хэмжээ ба хамруулсан загвар, хүртээмжийн хоорондын харилцан хамаарлыг судлах ашигтай байж болох юм.



Хамруулах чиглэл – тэд хаашаа чиглэж байна вэ?





Дүгнэлт: Хамруулахад чиглэсэн үйл ажиллагаанууд

“Хамруулсан, хүртээмжтэй Улаанбаатар бол хүн бүхэн шударга, тэгш байдлаар оролцох боломжтой газар юм. Нийгмийн бүх гишүүдэд аюулгүй, хүртээмжтэй орчныг бий болгосноор хот хүн бүрд хүссэн боломжоо олж авах, оролцох боломжийг олгоно.”

Илүү хүртээмжтэй Улаанбаатар хотын цогц алсын хараа, үйл ажиллагааны төлөвлөгөөг гаргахдаа оролцогч талуудын дунд хөгжлийн бэрхшээлийн талаар болон хамруулсан загварын чиглэлээр сургалтад эхлээд хамруулсан байх ёстой. Эдгээр алхмууд нь хүн бүрийн, түүний дотор хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн амьдралыг сайжруулах олон талт байдлыг болон хотын загварыг хийх боломжийг олгоно. Хурдацтай өөрчлөгдөж буй хотод тохирсон загварыг бий болгохын тулд хамруулсан загварыг техникийн стандартаас илүү сэтгэлгээ, арга зүй гэж ойлгох хэрэгтэй. Өөрөөр хэлбэл, загварын хувьд сэтгэлгээтэй байх ёстой гэдэг нь хотын баялаг түүхтэй нүүдэлчин амьдралын хэв маягийг илүү үр дүнтэй болгож, хотод хүмүүс янз бүрийн аргаар амьдрахыг бодолцон үзэж, хөгжлийн бэрхшээлүүд, тухайлбал уур амьсгалтай холбоотой асуудлуудад хариу үзүүлэх хэрэгтэй.

Бүх оролцогч талууд сайн туршлагыг хэрэгжүүлж, хамруулахад чиглэсэн үйл ажиллагаа хийх хариуцлагыг хүлээнэ. Бодлогын түвшинд хуулийг дагаж заавал мөрдөх ёстой стандарттай байх ёстой. Салбарын хэмжээнд хамруулсан загварын сайн туршлага, дизайны тойм, хяналт шалгалт явагдах ёстой. Хамт олон хүртээмжийн үнэлгээ, нөлөөллийн ажлаар дамжуулж өөрсдийнхөө хэрэгцээг дамжуулах ёстой¹¹⁹.

Үйл ажиллагааг нэн тэргүүнд хэрэгжүүлэх дараалал:

- Хүмүүсийн хувьд юу чухал болохыг олж мэдэх
- Хотын оролцогч талууд хамруулсан, хүртээмжтэй Улаанбаатар хотыг бий болгох алсын хараагаа хуваалцах хэрэгтэй
- Ойлголт нэмэгдүүлэх, боловсрол амин чухал юм. Оролцогч талуудад хамруулсан загвар хүн бүрд ашигтай, хамруулах соёлыг бий болгох талаар сургалтад хамруулж болно.
- Барилга байгууламжийн орчны хүртээмж нь зөвхөн техникийн стандарт биш юм. Хамруулсан загвар нь гоёмсог, илүү сайхан байж болно. Хамруулсан загвар бол сайн загвар юм.
- Улаанбаатар бол цаг уур, соёл, газар зүйн өвөрмөц тогтолцоотой учир тэдгээрт тохирсон өвөрмөц хамруулсан загварын стратеги хэрэгтэй.

¹¹⁹ For more information on the various initiatives led by GerHub please visit: <https://gerhub.org/>



- Төсөл эхлэх үеэс хамруулсан загварыг хэрэгжүүлж, төсөвт суулгавал илүү үр дүнтэй байх болно.
- Хаа нэг газраас эхлүүл. Хамруулсан загвар хотыг амьдрахад илүү таатай болгодог талаар хүмүүс өөрсдөө судлах хэрэгтэй.

Нэмэлтээр анхаарах ёстой зүйлс:

- Хүртээмжийн талаар тогтвортой өгөгдлийг боловсруулах. Хүртээмжийн үнэлгээ хийхэд стандартчилагдсан хяналтын хуудас нь сайжруулах зүйлүүдийн талаар тууштай, баттай нотолгоог бий болгож чадна. Боломжтой бол үүнд хүртээмжийн зардлын талаарх санхүүгийн дүн шинжилгээг багтаавал зүгээр (барилгыг дараа шинэчлэн тохижуулах үед).
- Төслийг дөнгөж эхлэх үед хамруулсан загвараас ашиг хүртэж байгааг нотлох, зардлыг тодруулж, боломжтой үнийг баримтлах зэргийн өөрчлөлтийг системтэйгээр хийж эхлэх
- Төсвийн механизм, нотолгоог тодорхойлохын тулд жишиг төслийг ашиглах
- Хотыг тээвэр, замын дэд бүтцийг ашиглаж хөдөлгөөнд оролцох
- Туслах технологийн хүртээмжийг өргөжүүлж, дэд бүтэц, үйлчилгээний салбаруудын хоорондох хамтран ажиллах
- Төрийн болон үйлдвэрийн (барилгын) салбарын оролцогч талуудад зориулж хамруулсан загвар, түүний хэрэглээний талаар сургалт явуулах
- Туслах технологи ба хүртээмжтэй барилга байгууламжийн орчин хоорондын чухал харилцааны талаар барилга байгууламжийн мэргэжилтнүүдийн дунд сургалт явуулах, ойлголт нэмэгдүүлэх
- Хүртээмжийн стандартын механизмыг хэрэгжүүлэх, стандарт ба үнэлгээний хяналтын хуудас хоорондын уялдаа холбоог хангах
- Төвлөрлийг сааруулах хандлага– хэрэгцээг үнэлэхдээ хөршүүд ба бүсүүдэд анхаарлаа хандуулах¹²⁰
- Хамруулсан загварыг бүх салбарууд хэрэглэж, урт хугацааны төлөвлөгөө гаргаж тогтвортой байлгах хэрэгтэй.
- Хамруулсан загварыг эхнээс нь хэрэгжүүлбэл эдийн засгийн үр ашиг нэмэгдэнэ.
- Хамруулсан загвар, хүртээмжийн стандартуудыг хот төлөвлөлтөд нэгтгэн оруулж, барилга барих зөвшөөрөл олгох процессын нэг хэсэг нь байх ёстой
- Хамруулсан загварын иж бүрэн хандлага нь одоогийн бодлого, хэрэгжилтийн гүүр болж өгөх болно

¹²⁰ UN-Habitat, 'Flagship Programme 1: Inclusive, Vibrant Neighbourhoods and Communities'.

Бодлого боловсруулагч, шийдвэр гаргагч нарт чиглэсэн зөвлөмж:

- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэд бүтцийг хөгжүүлэх төсвийг боловсруулах, шинээр барилга барих комисс зэрэг худалдан авалтын процесс болон санхүүгийн шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцуулах
- Засгийн газрын санхүүжилтээр баригдах барилга байгууламжийн орчны төслүүдийн алсын хараа, загварыг боловсруулах
- Жил бүрийн төсөвт ХБИБ-уудаар үнэлгээ хийлгэх, зөвлөлдөх үйл ажиллагааг төлөвлөх
- Үндэсний бодлого, хууль тогтоомж нь орон нутгийн бодлого, төлөвлөгөөнд тусгаж, хот төлөвлөлтөд хамруулсан загварын алсын харааг хамруулах

Барилга, зам тээвэр, дэд бүтцийн салбарт чиглэсэн зөвлөмж:

- Хамруулсан загвар, түүнтэй холбоотой одоо байгаа үндэсний болон олон улсын хүртээмжийн стандартуудын талаар сургалт явуулах
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй зөвлөлдөж хамруулсан загварын механизм бий болгох
- Хамруулсан загварын зааварчилгаа нь ойлгомжтой, практикт түшиглэсэн байх ёстой
- Хэрэглэгчидтэй хамт очиж, хүртээмж гол хаалган дээр ирээд хүртээмжийн хэрэгцээ дуусгавар болдоггүйг харуулж хүртээмжийг төлөвлөх

Хамт олонд чиглэсэн зөвлөмж:

- Хамруулах явцад ахиц дэвшил гаргах олны танил хүмүүсийг олж илрүүлэх
- Барилга байгууламжийн орчинд үнэлгээ хийх
- Хамруулсан орчны үнэ цэний талаарх мэдлэгийг соёлын үйл ажиллагаа, суртал ухуулгаар дамжуулан түгээх
- Шийдвэр гаргах, зураг төсөв боловсруулах үйл явц, үнэлгээ зэрэгт оролцох, хэрэв санал болгохгүй бол өөрсдөө оролцохыг хүсэх

Орчныг боломжтой болгох нь

- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст орчин бүрдүүлэхэд: таатай хууль тогтоомжийн орчин, зураг төсөл боловсруулах, шийдвэр гаргах үйл явцад оролцох, соёлын эерэг өөрчлөлт, хүртээмжтэй, хамруулсан барилга байгууламжийн орчин, сайн чанарын, боломжийн үнэтэй туслах технологи зэргийг хамруулсан байх хэрэгтэй.



Хамруулсан Улаанбаатар хот ямар харагдах вэ?

- Олон төрлийн хөгжлийн бэрхшээл болон бусад чадварын хүрээг хамарсан, заавал мөрдөгдөх хүртээмжийн стандартуудтай байх
- Олон нийтийн газар болон үйлчилгээнүүд нь хүн бүрд тэгш үйлчилдэг хүртээмжтэй, найрсаг байх
- Сайн чанарын, боломжийн, туслах технологийг хүртэх боломжтой байх
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст туслах, тэднийг ойлгох соёлтой байх
- Хүн бүр тэгш хүртэх, тэгш боломжтой байх, тэгш оролцоотой байх

Цаашид яах вэ?

Энэхүү тайланд Улаанбаатар хотын дэд бүтэц, хүртээмжийн талаар хийсэн дөрвөн сарын судалгааны гол үр дүнг тоймлон харуулав. Энэ судалгаа нь бага, дунд орлоготой орнуудад хамруулсан загвар болон барилга байгууламжийн орчны талаарх зургаан нөхцөл байдлын судалгааны эхнийх нь юм. Бусад нөхцөл байдлын судалгааны гарах үр дүнтэй нэгтгэн, хамруулсан загварын талаарх олон улсын хэмжээний тайлан гаргаж, мэдээлэх болно.

Энэхүү судалгааны үр дүнг олон улсын болон орон нутгийн түвшинд хамруулсан загварын судалгаа, сургалтад хамрагдсан оролцогч талуудад шууд хуваалцах ба тодорхой үйл ажиллагаануудыг төлөвлөж байна. Дэлхийн хөгжлийн бэрхшээлийн инновацын төв (GDI Hub) нь Азийн хөгжлийн банктай хамтран Монгол улсад идэвхтэй ажиллаж байгаа бөгөөд судалгааны баг Улаанбаатар хотод хэрэгжиж буй идэвхтэй төслүүдэд хамруулсан загварын талаар дэмжлэг үзүүлэх болно. Судалгааны баг нь судалгааны хамтрагчдадаа шинэ хүртээмжийн тухай хуулийн талаар зөвлөгөө өгөх зэрэг үйл ажиллагаанд үргэлжлүүлэн дэмжлэг үзүүлэх зэргээр уг судалгааны үр дүн мэдээлэл өгнө.

АШИГЛАСАН ХЭВЛЭЛИЙН ТОЙМ

- Agarwal, Anjlee, and Andre Steele. 'Disability Considerations for Infrastructure Programmes'. Evidence on Demand, 8 March 2016. https://doi.org/10.12774/eod_hd.march2016.agarwaletal.
- Amgaabazar, Gerelmaa, and Kate Lapham. 'Disability Is No Longer Invisible in Mongolia'. Open Society Foundations, 12 June 2014. <https://www.opensocietyfoundations.org/voices/disability-no-longer-invisible-mongolia>.
- Amnesty International. 'Falling Short: The Right to Adequate Housing in Ulaanbaatar, Mongolia'. Amnesty International, 2016.
- Anderson, Raven, Michael Hooper, and Aldarsaikhan Tuvshinbat. 'Towers on the Steppe: Compact City Plans and Local Perceptions of Urban Densification in Ulaanbaatar, Mongolia'. *Journal of Urbanism: International Research on Placemaking and Urban Sustainability* 10, no. 2 (3 April 2017): 217–30. <https://doi.org/10.1080/17549175.2016.1223739>.
- Asian Development Bank. 'ADB to Help Ulaanbaatar Transform Its Ger Areas into Eco-Districts'. Asian Development Bank, 28 August 2018. <https://www.adb.org/news/adb-help-ulaanbaatar-transform-its-ger-areas-eco-districts>.
- . 'Enabling Inclusive Cities: Tool Kit for Inclusive Urban Development'. Manila, Philippines: Asian Development Bank, 1 December 2016. <https://doi.org/10.22617/TIM157428>.
- . 'Living with Disability In Mongolia: Progress Toward Inclusion'. Manila, Philippines: Asian Development Bank, December 2019. <https://doi.org/10.22617/TCS190596-2>.
- Baker, Judy L., and Gauri U. Gadgil, eds. *East Asia and Pacific Cities: Expanding Opportunities for the Urban Poor*. The World Bank, 2017. <https://doi.org/10.1596/978-1-4648-1093-0>.
- Cosgrave, Dr Ellie. 'The Role of the Engineer in Creating Inclusive Cities', n.d., 16.
- Dahiya, Bharat, and Ashok Das. 'New Urban Agenda in Asia-Pacific: Governance for Sustainable and Inclusive Cities'. In *New Urban Agenda in Asia-Pacific*, edited by Bharat Dahiya and Ashok Das, 3–36. *Advances in 21st Century Human Settlements*. Singapore: Springer Singapore, 2020. https://doi.org/10.1007/978-981-13-6709-0_1.
- Dawson, Richard. 'Delivering Effective and Inclusive Infrastructure'. ESRC Evidence Briefings. Economic and Social Research Council, March 2018. <https://esrc.ukri.org/news-events-and-publications/evidence-briefings/delivering-effective-and-inclusive-infrastructure/>.
- Deepak, Sunil. 'Barriers Faced by Young Adults with Disabilities in Ulaanbaatar, Mongolia: Report of a Community-Based Emancipatory Disability Research (CB-EDR)'. Ulaanbaatar, Mongolia: Tegsh Niigem, n.d.
- Department for International Development, UK Government. 'Disability, Poverty and Development'. Department for International Development, 2000.
- Diener, Alexander C., and Joshua Hagen. 'City of Felt and Concrete: Negotiating Cultural Hybridity in Mongolia's Capital of Ulaanbaatar'. *Nationalities Papers* 41, no. 4 (July 2013): 622–50. <https://doi.org/10.1080/00905992.2012.743513>.
- Disability Inclusive and Accessible Urban Development Network (DIAUD), World Enabled, and CBM. 'The Inclusion Imperative: Towards Disability-Inclusive and Accessible Urban Development. Key Recommendations for an Inclusive Urban Agenda', 2016, 40.
- Dorjbal, Delgerjargal, Birgit Prodingler, Claudia Zanini, Baljinnyam Avirmed, Gerold Stucki, and

- Sara Rubinelli. 'Living with Spinal Cord Injury in Mongolia: A Qualitative Study on Perceived Environmental Barriers'. *The Journal of Spinal Cord Medicine* 43, no. 4 (3 July 2020): 518–31. <https://doi.org/10.1080/10790268.2019.1565707>.
- Fabian, Herbert, Sudhir Gota, Alvin Mejia, and James Leather. 'Walkability and Pedestrian Facilities in Asian Cities: State and Issues'. ADB Sustainable Development Working Paper Series. Asian Development Bank, 2010. http://www.indiaenvironmentportal.org.in/files/Walkability_Final_Report_15Oct2010.pdf.
- Fan, Peilei, Jiquan Chen, and Ranjeet John. 'Urbanization and Environmental Change during the Economic Transition on the Mongolian Plateau: Hohhot and Ulaanbaatar'. *Environmental Research* 144 (January 2016): 96–112. <https://doi.org/10.1016/j.envres.2015.09.020>.
- Federation of Independent Living Organizations of Mongolia (MIL), and Tegsh Niigem. 'Submission from Disabled People's Organizations of Mongolia to Inform the Development of the List of Issues Prior to Reporting for a 2nd Periodic Review of Mongolia under the Convention on the Rights of the Persons with Disabilities', 29 July 2018.
- Global Disability Innovation Hub, Queen Elizabeth Olympic Park, and London Legacy Development Corporation. 'Inclusive Design Standards', May 2019.
- Government of Mongolia, and Asia Foundation. 'Ulaanbaatar Master Plan 2020 and Development Approaches for 2030: Technical Summary', 2014. <https://asiafoundation.org/publication/ulaanbaatar-city-master-plan-technical-summary/>.
- Government of Mongolia, and JICA. 'White Paper on Disability in Mongolia 2019'. Government of Mongolia: Ministry of Labour and Social Protection, 2019.
- Hamiduddin, Iqbal. 'Travel and Social Equity in Ulaanbaatar's Ger Districts: The Case of Khoroo 31'. 2019. www.unaa-project.org.
- Hamiduddin, Iqbal, Rebekah Plueckhahn, Daniel Fitzpatrick, GerHub, and PublicLab Mongolia. 'The UNAA Project: Ulaanbaatar Accessibility Appraisal', n.d. <https://www.unaa-project.org/>.
- Hamraie, Aimi. 'Designing Collective Access: A Feminist Disability Theory of Universal Design'. *Disability Studies Quarterly* 33, no. 4 (5 September 2013). <https://doi.org/10.18061/dsq.v33i4.3871>.
- Higashida, Masateru. 'Consolidating Information on Disability-Inclusive Policies: A Case Study on White Papers in Mongolia from the Perspective of International Technical Cooperation'. *Asia Pacific Journal of Social Work and Development* 30, no. 2 (2 April 2020): 122–30. <https://doi.org/10.1080/02185385.2020.1713208>.
- Infrastructure and Cities for Economic Development (ICED). 'Delivering Disability Inclusive Infrastructure in Low Income Countries'. Inception Report: Summary, 2019.
- Jadambaa, Amarzaya, Jeffery Spickett, Burmaajav Badrakh, and Rosana E. Norman. 'The Impact of the Environment on Health in Mongolia: A Systematic Review'. *Asia Pacific Journal of Public Health* 27, no. 1 (January 2015): 45–75. <https://doi.org/10.1177/1010539514545648>.
- JICA. 'Ulaanbaatar, a Reborn City: 10 Years of Urban Development in a Rapidly Expanding City'. News, 26 October 2016. https://www.jica.go.jp/english/news/field/2019/20191016_01.html.
- Kamata, Takuya, James A. Reichert, Tumentsogt Tsevegmid, Yoonhee Kim, and Brett Sedgewick. *Managing Urban Expansion in Mongolia: Best Practices in Scenario-Based Urban Planning*. The World Bank, 2010. <https://doi.org/10.1596/978-0-8213-8314-8>.
- Khan, F, B Amatya, B Avirmed, Y Yi, B Shirmen, G Abbott, and M Galea. 'World Health

- Organization Global Disability Action Plan: The Mongolian Perspective'. *Journal of Rehabilitation Medicine* 50, no. 4 (2018): 388–366. <https://doi.org/10.2340/16501977-2207>.
- Larkin, John, and Gantuya Ganzorig. 'Case Study: Can Better Urban Planning Help Ulaanbaatar Glimpse a Brighter Future?' Asian Development Bank, 16 August 2018. <https://www.adb.org/results/can-better-urban-planning-help-ulaanbaatar-glimpse-brighter-future>.
- Lhamsuren, Khandsuren, Tserendolgor Chojijiljav, Enkhtuya Budbazar, Surechimeg Vanchinkhuu, Diana Blanc, and John Grundy. 'Taking Action on the Social Determinants of Health: Improving Health Access for the Urban Poor in Mongolia'. *International Journal for Equity in Health* 11, no. 1 (2012): 15. <https://doi.org/10.1186/1475-9276-11-15>.
- Menard, Aubrey. 'Mongolia's Urban Planning Paradox'. *New America Weekly*, 31 August 2020. <https://www.newamerica.org/weekly/mongolias-urban-planning-paradox/>.
- . *Young Mongols: Forging Democracy in the Wild, Wild East*. Penguin Random House SEA, 2020.
- Mitlin, Diana, and David Satterthwaite. 'On the Engagement of Excluded Groups in Inclusive Cities: Highlighting Good Practices and Key Challenges in the Global South'. *Urban Development Series Knowledge Papers*. The World Bank, 2016.
- Mongolian National Statistics Office. 'Main Findings of the 2010 Population and Housing Census', 2010. en.ubseg.gov.mn/content/49.
- Mongolian Statistical Information Service. '2015 Population and Housing'. *Census of Mongolia*, 1 January 2016. www.1212.mn.
- Morante, Danielle. 'Occupational Therapy Emerging in Mongolia: A Case Study'. *World Federation of Occupational Therapists Bulletin* 73, no. 2 (3 July 2017): 88–93. <https://doi.org/10.1080/14473828.2017.1281870>.
- 'National Statistics Office of Mongolia', 2020. <https://www.en.nso.mn/>.
- 'New Urban Agenda'. United Nations, 2017.
- Pineda, Victor Santiago. 'Enabling Justice: Spatializing Disability in the Built Environment', n.d., 14.
- Pinilla-Roncancio, Monica, and Sabina Alkire. 'How Poor Are People With Disabilities? Evidence Based on the Global Multidimensional Poverty Index'. *Journal of Disability Policy Studies*, 17 May 2020, 104420732091994. <https://doi.org/10.1177/1044207320919942>.
- Plueckhahn, Rebekah, and Terbish Bayartsetseg. 'Negotiation, Social Indebtedness, and the Making of Urban Economies in Ulaanbaatar'. *Central Asian Survey* 37, no. 3 (3 July 2018): 438–56. <https://doi.org/10.1080/02634937.2018.1442318>.
- So, Yeonghwa, Naae Lee, Seyeon Kim, Youngji Lee, Chimedsuren Ochir, and Kiyoungh Lee. 'Characteristics of Lifestyle and Living Environment of Ger District Residents in Ulaanbaatar, Mongolia'. *The Korean Journal of Public Health* 55, no. 2 (31 January 2019): 12–21. <https://doi.org/10.17262/KJPH.2018.12.55.2.12>.
- Stol, Ilana, and Enkhjargal Adiya. 'Intergenerational Relationships in Mongolia: Togetherness as a Family Unit'. *Journal of Intergenerational Relationships* 8, no. 1 (4 March 2010): 83–89. <https://doi.org/10.1080/15350770903520783>.
- Sugimoto, Hirofumi, Umekazu Kawagishi, Koki Kitano, Ishjamts Gonchigbat, and Naoyuki Hirota. 'Living Environment of Nomads Residing on the Outskirts of Ulaanbaatar, Mongolia— Dispositional Characteristics from the Perspective of a Comparison of Nomads and People Living in Ger Fixed Residences in the City —'. *Journal of Asian Architecture and Building Engineering* 6, no. 2 (November 2007): 283–90. <https://doi.org/10.3130/jaabe.6.283>.

- Szilágyi, Zsolt. 'Lingering Nomad Ideology in 21 st Century Mongolia'. *Acta Ethnographica Hungarica* 61, no. 1 (June 2016): 197–211. <https://doi.org/10.1556/022.2016.61.1.9>.
- Terbish, Bayartsetseg, and Margot Rawsthorne. 'Social Exclusion in Ulaanbaatar City Mongolia'. *Asia Pacific Journal of Social Work and Development* 26, no. 2–3 (2 July 2016): 88–101. <https://doi.org/10.1080/02185385.2016.1199324>.
- The World Bank. 'World Inclusive Cities Approach Paper'. The World Bank, May 2015.
- The World Health Organisation. 'World Report on Disability'. The World Health Organisation, 2011.
- Uddin, Sayed Mohammad Nazim, Zifu Li, J.C. Gaillard, Pauley F. Tedoff, Heinz-Peter Mang, Jean Lapegue, Elisabeth Maria Huba, Olivia Kummel, and Eric Rheinstein. 'Exposure to WASH-Borne Hazards: A Scoping Study on Peri-Urban Ger Areas in Ulaanbaatar, Mongolia'. *Habitat International* 44 (October 2014): 403–11. <https://doi.org/10.1016/j.habitatint.2014.08.006>.
- UN-Habitat. 'Flagship Programme 1: Inclusive, Vibrant Neighbourhoods and Communities'. UN-Habitat. Accessed 19 September 2020. <https://unhabitat.org/programme/inclusive-vibrant-neighbourhoods-and-communities>.
- Upton, Caroline. 'Social Capital, Collective Action and Group Formation: Developmental Trajectories in Post-Socialist Mongolia'. *Human Ecology* 36, no. 2 (April 2008): 175–88. <https://doi.org/10.1007/s10745-007-9158-x>.
- Venter, Christoffel J., Thomas E. Rickert, and David A. C. Maunder. 'From Basic Rights to Full Access: Elements of Current Accessibility Practice in Developing Countries'. *Transportation Research Record: Journal of the Transportation Research Board* 1848, no. 1 (January 2003): 79–85. <https://doi.org/10.3141/1848-11>.
- World Economic Forum: Strategic Intelligence. 'Global Issue: Inclusive Design. Curated by the Smithsonian Institution'. World Economic Forum: Strategic Intelligence. Accessed 12 September 2020. <https://intelligence.weforum.org/topics/a1G0X0000057IniUAE?tab=publications>.
- Wu, Yun, Arto Emerik Nuorkivi, Pekka Kalevi Salminen, Peter Johansen, and Rong Cui. 'Paving the Way to a Sustainable Heating Sector A Roadmap for Ulaanbaatar Urban Heating'. Energy Sector Management Assistance Program (ESMAP). The World Bank, 2019. <https://documents.worldbank.org/pt/publication/documents-reports/documentdetail/361331554753311754/paving-the-way-to-a-sustainable-heating-sector-a-roadmap-for-ulaanbaatar-urban-heating>.

Монгол Улсын Улаанбаатар хотын барилга байгууламжийн орчны хүртээмж ба хамруулсан загвар



ТТ 2030 Кейс судалгаа www.AT2030.org

2020 оны 9 дүгээр сар

